



Монгол-Германы хамтарсан төсөл
Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого
Үйлдвэр, худалдааны яам - Германы техникийн хамтын
ажиллагааны нийгэмлэг



Төв шуудан, Хайрцаг-1264 Улаанбаатар 210613 Монгол Улс
Утас: +976-11-315464/318038 Факс: +976-11-315955
И-мэйл: trade@gtz-mongolia.org

**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
ДХБ-Д ЭЛСЭХЭД АВСАН ҮҮРЭГ, АМЛАЛТ:
ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА
ХЯТАД-МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНД
ҮЗҮҮЛЭХ УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Бэлтгэсэн

Вольфганг фон Лингэлсхайм-Зайбике

2004 оны 10 дугаар сар

Зохиогчийн зүгээс Хатагтай Л.Хулан болон түүний багийнхан өөрт нь тусалж, мэдээ, мэдээлэл цуглуулж өгсөнд талархал илэрхийлж байна. Ямар нэгэн алдаа мадаг, орхигдсон зүйл байх аваас үүнийг зохиогч бүрэн хариуцна. Энэхүү илтгэх хуудас нь Монгол Улсын Засгийн газар болон ГТХАН-ийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Гарчиг

	Хуудас
Товчилсон үгс	iv
Товчлол	vi
I Оршил	1
II Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа	4
III Хятад олон талт худалдааны тогтолцоон дахь гишүүний хувьд	7
III 1 Өмнөх үг	7
III 2 ДХБ-ын эрх зүйн гол баримт, бичиг ба ДХБ-д элсэн ороход Хятадын авсан үүрэг, амлалтын товчоон	7
III 2.1 Барааны худалдааны дөрвөн үндсэн дүрэм	9
III 2.1.1 “Тарифжуулах”	9
III 2.1.2 Тарифыг заавал баримтлах	10
III 2.1.3 Нэн тааламжтай үндэсний нөхцөл (НТҮН)	10
III 2.1.4 Үндэсний нөхцөлийн дүрэм	11
III 2.2 Хэрэгжүүлэлтийн ерөнхий гурван дүрэм	12
III 2.2.1 Гаалийн татварыг ногдуулах үнийг тодорхойлох нь	12
III 2.2.2 Заавал дагаж мөрдөх стандарт, эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн дүрэм, журмыг хэрэгжүүлэх нь	13
III 2.2.3 Импортын тусгай зөвшөөрлийн олголт	14
III 2.3 Бусад зарим дүрэм	15
III 2.3.1 Татаасын тухай дүрэм	15
III 2.3.2 Дампингийн эсрэг дүрэм	17
III 2.3.3 Татаастай буюу дампингтай бараанд учирсан хохирол, учир шалтгааны холбоосыг тодорхойлох дүрэм	18
III 2.3.4 Хамгаалалтын тухай дүрэм	18
III 2.4 Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээний дүрэм	19
III 2.5 Үйлчилгээний худалдааны тухай дүрэм	20
III 2.6 Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбоотой асуудлын тухай дүрэм	22
III 2.7 Шүүхийн хянан шийдвэрлэлт	23
III 2.8 Шилжилтийн дахин хянах механизм	23
IV Хятад улс сонгосон чиглэлээрээ ДХБ-ын дүрмийг хэрхэн даган биелүүлж байна вэ?	25
IV 1. Хятад ДХБ-ын дүрмийг хэрхэн ойлгосон нь гадаад худалдааны дэглэмд туссан нь	25
IV 1.1 Өмнөх үг	25
IV 1.2 Гадаад худалдааны талаарх наймаачны ойлголт (худалдаа хийх эрх)	26
IV 1.3 Худалдаанд тавьсан хязгаарлалт	27
IV 1.4 Гаалийн татварыг ногдуулах үнийг тодорхойлох, тарифын ангилал	28
IV 1.5 Заавал дагаж мөрдөх стандарт, эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн дүрэм, журмыг хэрэгжүүлж байгаа нь	29
IV 1.6 Импортын тусгай зөвшөөрөл олгох ажлын зохион байгуулалт	31

IV 1.7	Хятадын эдийн засаг дахь татаасын үүрэг	32
VI 1.8	Гадаад худалдааны шалгалт, худалдааны эрх зүйн хамгаалалтын хэрэглүүр	34
IV 2	Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээ	36
IV 3	Үйлчилгээний зах зээлийг нээх	37
IV 3.1	Ерөнхий хандлага	37
IV 3.2	Худалдаа ба түгээлт	39
IV 3.3	Тээвэрлэлт ба материал, техникийн хангамжийн үйлчилгээ	42
IV 4	Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын талаарх дүрэм	43
IV 5	Хятад улс дүрэм, журмыг хэрхэн дагаж мөрдөж байгаа тухай товчхон	44
IV 6	Дүрэм, журмыг цаашид дагаж мөрдөх шаардлагатай урьдчилсан нөхцөл болох улс төрийн хүсэл зориг, практик чадавх	45
V	Хятад улс ДХБ-д элсэн ороход авсан амлалт, үүргийн үзүүлж болох нөлөө	47
V 1	БНХАУ-ын эдийн засагт үзүүлэх нөлөө	47
V 1.1	Цаашид хийгдэх бүтцийн өөрчлөлт	47
V 1.2	Хөдөө, аж ахуй	48
V 1.3	Аж үйлдвэр	49
V 1.3.1	Хүнс, ундаа	49
V 1.3.2	Түүхий эд	49
V 1.3.3	Сүлжмэл эдлэл, хувцас	50
V 1.3.4	Цахилгаан хэрэгсэл, мэдээллийн технологи, цахилгаан холбоо	52
V 1.3.5	Тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийн салбар	53
V 1.3.6	Материал техникийн хангамж ба чингэлгийн тээвэрлэлт	53
V 2	Бүсийн эдийн засгийн харилцаанд үзүүлэх нөлөө	54
V 2.1	Хятадын дотоод зах зээлд нэвтрэх боломж өсөх байдал	56
V 2.2	Хятадаас оруулж байгаа импорт өсөх байдал	56
V 2.3	Гуравдагч орны зах зээлийн өрсөлдөөн нэмэгдэх байдал	57
V 2.4	ГШХО-ын шинж, чанарын өөрчлөлт	57
VI	Дүгнэлт, зөвлөмж	59
	Лавлах материал	63

Товчилсон үгс

ДЭУАТГ	Дампингийн эсрэг үйл ажиллагааны тухай хэлэлцээр
ЧХШХЦУГ	БНХАУ-ын Чанарын хяналт, шалгалт, хорио цээрийн удирдах газар
АСЕАН	Зүүн өмнөд Азийн улсуудын холбоо
млрд	миллиард
ХЗДМГТ	Хятадын заавал дагаж мөрдөх гэрчилгээжүүлэлтийн тогтолцоо
ХҮГМИУГ	Хятадын үндэсний гэрчилгээжүүлэлт, магадлан итгэмжлэлийн удирдах газар
ЕЭЗК	Европын эдийн засгийн комисс
ЕХ	Европын Холбоо
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
АДЭЗТ	Алс Дорнодын эдийн засгийн тойм
ГХН	Гадаад худалдааны наймаачин
ГХТХ	БНХАУ-ын Гадаад худалдааны тухай хууль
ТХЕХ	Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр
ҮХЕХ	Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээр
ОӨЭ	Оюуны өмчийн эрх
МТХ	Мэдээллийн технологийн хэлэлцээр
НБХА	Компани нэгдэх ба худалдан авах
НТҮН	Нэн тааламжтай үндэсний нөхцөл
МТЯ	Мэдээллийн технологийн яам
ХЯ	Худалдааны яам
ХЭЗХЯ	Худалдаа, эдийн засгийн харилцааны яам (ХЯ-ны хуучин нэр)
ОТХТ	Олон талт худалдааны тогтолцоо
ҮШХК	Үндэсний шинэчлэл, хөгжлийн комисс
ТБСТ	Тарифын бус саад тотгор
ЭТП	БНХАУ ДХБ-д элсэх тухай протокол
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс СБА Судалгаа, боловсруулалтын ажил
АХТ	Хятад ДХБ-д элссэн тухай ажлын хэсгийн тайлан
СУГ	Хятадын стандартчилалын удирдах газар
ТНТАХТХ	Татаас, нөхөн төлөөсийн арга хэмжээний тухай хэлэлцээр

ЭЗТБ	Эдийн засгийн тусгай бүс
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
УӨҮГ	Улсын өмчийн үйлдвэрийн газар
ЭАУЭА	Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ авах тухай хэлэлцээр
ХТСТ	Худалдаан дахь техникийн саад, тотгорын тухай хэлэлцээр
ХТАН	Хорин тохойтой адилтгах нэгж
ХХОАХ	Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээ
ОӨЭХХА	Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудал
ШДХМ	Шилжилтийн дахин хянах механизм
ТТК	Тарифын түвшний квот
НҮБХХБХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын худалдаа, хөгжлийн бага хурал
АНУХТ	Америкийн Нэгдсэн Улсын худалдааны төлөөлөгч
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
ГДХОААН	Гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж
ДОӨБ	Дэлхийн оюуны өмчийн байгууллага
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ББХХ	Бүс-боомтын харилцах хэсэг

Товчлол

Сүүлийн жилүүдэд БНХАУ нь худалдааны хэмжээ болон Монголын экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, молибдены баяжмал, ноос, ноолуурын зах зээлийн хувьд Монголын худалдааны хамгийн чухал түнш болсон. Монгол улсын Хятадтай хийдэг худалдааны тэнцэл нь ашигтай байдаг тул үндэсний эдийн засагт үзүүлдэг нийт худалдааны алдагдлын сөрөг үр нөлөөг багасгахад нэмэртэй байж болно.

Тийм ч учраас Монгол Улсын Засгийн газар “Дундад улс”-тай харилцах худалдааны бодлогын тодорхой стратегийг боловсруулах хэрэгтэй. Энэ үүднээс Дэлхийн Худалдааны Байгууллагад (ДХБ) хоёр орон хоёулаа элссэнээр Монголд ямар боломж гарч ирэх, Монгол олон талт болон хоёр талт харилцаанд худалдааны эрх ашгаа хэрхэн баримтлах талаар бодож үзэх шаардлагатай.

ДХБ-д элссэнээр Хятад тарифаа бууруулж, улсын худалдаа, тусгай зөвшөөрлийн шаардлага, квотын хязгаар зэрэг тарифын бус олон саад тотгорыг арилгаж, янз бүрийн татаасыг алга болгож, хууль тогтоомжийг хэвлэн нийтэлж, нэгэн жигд хэрэгжүүлж, ялангуяа ялгаварлан гадуурхал их түгсэн хэлбэрийг хориглох замаар зах зээлээ нээнэ гэсэн үг. Гадаадын хөрөнгө оруулагчид илүү эрх чөлөөтэй болж, үйлчилгээгээр худалдааг чөлөөлснөөр өнөөг хүртэл бараг оршиж байгаагүй олон шинэ бизнесийг хөгжүүлэхэд түлхэц өгнө.

ДХБ-д элссэнээс хойш хоёр жил хагас болоход Хятадын дүрэм, журмыг дагаж мөрдсөн байдал нь холимог бөгөөд жигд биш байна: Хятад олон бараа, бүтээгдэхүүний тарифын хэмжээг нэлээд их бууруулж, улсын худалдаанд хамаарах бараа, бүтээгдэхүүний төрлийг цөөрүүлж, худалдаа, импортод квот тогтоохыг багасгасан. Хятад мөн гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад дотоод худалдаа хийх эрх олгох замаар худалдааны эрхийг өргөжүүлсэн. Тусгай зөвшөөрөл өгөх журам урьд өмнөхөө бодвол арай ил тод болсон.

Гэхдээ хүнд суртлын инерц, эмзэг салбарыг хамгаалах хүсэл, эрмэлзэл нь гишүүнээр элсэх үеийн хөөрлөөр эхлэлээ тавьсан хэрэгжүүлэлтийн явцад саатал гаргахад нөлөөлж байна: Гадаад худалдааны дэг журмыг тогтоосон хууль тогтоомж, ялангуяа саяхан батлагдсан Гадаад худалдааны тухай хууль, дампингийн эсрэг болон татаасын тухай дүрэм журам болон зарим дагалдах хууль дүрэм нь ДХБ-ын хэм хэмжээтэй зөрчилдөх буюу тодорхой бус байна. Тиймээс эдгээр хууль тогтоомжийг ДХБ-ын тогтолцооны үзэл, санаатай нийцүүлэхийн тулд хуулийг хэрхэн хэрэгжүүлэх талаар хангалттай удирдамж, чиглэлийг эрх баригчдад өгөхгүй байна. Ил тод байдал үгүй байгаа нь гадаадын компаниудад бэрхшээл учруулсаар байна: Бүрхэг, нэгэн жигд бус хэрэгждэг хуулийн заалт, ялангуяа техникийн стандарт, импортын тусгай зөвшөөрлийн зохицуулалт, тарифын квот зэрэг хуулийн заалтууд ноцтой анхаарал татдаг.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн уламжлал болох татаасын хувьд Хятадын нийт эдийн засаг нэлэнхүйдээ тархсан үзэгдэл хэвээр үлдсэн бөгөөд оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх чиглэлээр ДХБ-ын дүрэм, журмыг маш муу дагаж мөрджээ.

Олон салбарт импортын шинэ саад тотгор, тухайлбал гэрчилгээжүүлэх шинэ тогтолцоо, үр ашиггүй тохирлын үнэлгээний журам бий болгосноос гадна үйлчилгээний янз бүрийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг (хугацаагүй) хязгаарласан.

Гэвч ДХБ-ын дүрэм, журмыг цаашид хэрэгжүүлэхийг Хятадын худалдааны томоохон түншүүдээс шахалт үзүүлэх нь Хятадын эдийн засаг, нийгмийн тогтолцоог улам нээлттэй, чөлөөтэй дэг журамтай болгоход түлхэц өгөх болно. Эдийн засгийн өсөлт өндөр байх төлөвтэй тул Хятадтай хөрш зэргэлдээ оршдог

улс орнуудын хувьд Хятад руу гаргах экспортыг нэмэгдүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах замаар энэхүү хөгжлийн үр шимийг хүртэх асар их боломж байна. Энэхүү ГШХО нь Хятадад гадаадын компаниудын явуулж байгаа бизнесийн үйл ажиллагааны дутууг нөхсөн буюу дэвшилтэт бус технологийн үйл ажиллагаа явуулахад хэтэрхий өртөг ихтэй газрууд болох Хятадын Дорнод ба Өмнөд хэсгүүдийн томоохон бөөгнөрлөөс зугтсан буюу шахагдан гарсан хөрөнгө оруулалт байж болно.

Япон болон Зүүн Азийн шинээр аж үйлдвэржсэн орнууд шинээр үүсэн бий болж байгаа үйлдвэрлэлийн сүлжээний төвийн хувьд Хятадын өсөлтөөс хамгийн түрүүнд хувь хүртэх болно. Гэхдээ тус бүсийн хөгжиж буй орнуудад ч гэсэн боломж бий. Ийм боломжийг алдахгүйн тулд Монголын Засгийн газар Хятадтай эдийн засгийн харилцаагаа хөгжүүлэхийг дэмжсэн идэвхтэй худалдааны бодлогыг явуулах нь тун зүйтэй. Зарим арга хэмжээг дангаар авах ёстой бол бусад санаачилгыг Бээжинтэй худалдааны бодлогын хэлэлцээ хийсний эцэст эхлүүлж болно. ДХБ-ын Шилжилтийн дахин хянах механизмын бүртгэлд орсон БНХАУ нь ДХБ-д элсэхдээ авсан амлалт, үүргээ даган биелүүлэхийг хамгийн ил тод дэмждэг Хятадын худалдааны гол түншүүдтэй далд боловч ойрхон хамтран ажиллахыг Монгол Улсад зөвлөсөн.

I. Оршил

Сүүлийн жилүүдэд БНХАУ нь худалдааны хэмжээ болон Монголын экспортын бүтээгдэхүүний зах зээлийн хувьд Монголын худалдааны хамгийн чухал түнш болсон. Хятадын хөгжин цэцэглэж буй эдийн засаг олон жилийн турш их хурдацтай өсөн нэмэгдэх төлөвтэй байгаа тул түүний хөрш зэргэлдээ орнууд энэхүү өсөлтийн үр шимийг хүртэх асар их боломж байна. Монгол Хятадтай хийдэг худалдаандаа бүтцийн эерэг үлдэгдэл бий болгосон тул үндэсний эдийн засагт үзүүлдэг нийт худалдааны алдагдлын сөрөг үр нөлөөг багасгахад нэмэртэй байж болно.

Тийм ч учраас Монгол Улсын Засгийн газар “Дундад улс”-тай харилцах худалдааны бодлогын тодорхой стратегийг боловсруулах хэрэгтэй. Энэ үүднээс Дэлхийн худалдааны байгууллагад (ДХБ) хоёр орон хоёулаа элссэнээр Монгол Улсад ямар боломж гарч ирэх, Монгол Улс олон талт болон хоёр талт харилцаанд худалдааны эрх ашгаа хэрхэн баримтлах талаар бодож үзэх шаардлагатай. Тус судалгааны нэг зорилго нь дээрх асуудлаар зарим дүгнэлт хийж, практик зөвлөмж боловсруулахад оршиж байна. Цаашилбал тус судалгаа нь Монголын хэлэлцээ хийгчдэд Хятад ДХБ-д элсэхдээ авсан амлалт, үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар мэдээлэл өгөхийг зорьсон билээ.

Гэвч Хятадын ДХБ-ын өмнө авсан амлалт, үүрэг нь бараа, үйлчилгээний худалдаа болон оюуны өмчийн эрхтэй холбоотой асар олон асуудлыг хамарсан. Эдгээр нь бүгдээрээ Монголд ижилхэн ач холбогдолтой биш юм. Тиймээс тус судалгаанд сонгосон хэдэн асуудлыг голлон авч үзэхийн зэрэгцээ тухайн асуудлын салшгүй хэсэг болох Олон талт худалдааны тогтолцоог (ОТХТ) бүхэлд нь авч үзсэн.

Тодорхой амлалт, үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар ярихын тулд эхлээд тэрхүү амлалт, үүргийн талаар ярих ёстой. Ингэхдээ мөн мөрдөж биелүүлнэ хэмээн амласан дүрмүүдийн талаар эргэн дурдах хэрэгтэй. Энэ нь тус судалгааны бүтцийг тодорхойлсон: Хятадын ДХБ-д элсэх тухай протоколын заалтуудыг сайн ойлгохын тулд бид III бүлэгт Хятадын биелүүлэх ёстой ОТХТ-ны үндсэн зарчим болон дүрмийг товч тодорхойлж, энэ зорилгодоо хүрэхийн тулд хүлээсэн зарим үүргийн талаар дурдана. Дээрх үндсэн зарчим, дүрмийг ийнхүү тусгах нь зарим талаар онолын шинжтэй боловч ДХБ нь дампинг, татаас гэх мэт чиглэлээр юуг үнэхээр зөвшөөрч, хориглож байгаа талаар давамгайлж байж магадгүй буруу ойлголтыг залруулахад нэмэр болно.

Амлалт, үүргүүдийг тодорхойлсны дараа эдгээрийг хэрхэн биелүүлж байгаа талаар авч үзнэ. Энэхүү бүлэг (IV) нь өмнөх бүлгийн бүтцийн дагуу зохион байгуулагдана. Тухайлбал, сэдвийн хувьд ижилхэн дарааллыг баримтлах бөгөөд энэ удаа хэрэгжилтийн өнөөгийн байдлыг дүгнэж, энэ тухай олон улсын хэлэлцүүлгийн талаар дурдана. Ингэхдээ бид нэлээн хувьсамтгай асуудлыг авч үзэж байгаа гэдгийг байнга санах хэрэгтэй. Учир нь тасралтгүй явагдах хэлэлцүүлгийн үр дүнд юмс байнга хөдөлж, хөгжиж байдаг.

Тус бүлэг нь судалгааны гол хэсэг хэдий ч хамрах асуудлыг сонгосон бөгөөд судалгааны даалгаварт дурдсан асуудлуудыг голлон анхаарсан боловч эдгээрээр хязгаарлаагүй: БНХАУ-ын Гадаад худалдааны тухай шинэ хууль (ГХТХ), зарим салбарын татаасын практик, ялангуяа худалдаа, тээвэрлэлттэй холбоотой үйлчилгээний зах зээлийг хэрхэн нээж байгаа талаар энэ бүлэгт орсон.

Энэхүү бүлгийн дараа ДХБ-ын дүрмийг хэрэгжүүлэх нь Хятадын эдийн засагт, ялангуяа түүний нэг худалдааны түнш болох Монгол Улсад чухал ач холбогдолтой байж болох зарим салбарт ямар нөлөө үзүүлж болох талаар авч үзсэн. Асуудлыг бүрэн авч үзэхийн тулд бид БНХАУ нь ДХБ-д элссэнээр бүсийн

эдийн засгийн харилцаанд ямар нөлөө үзүүлэх талаар бичсэн болно. Учир нь Монгол Хятадтай хийх худалдааны бодлогыг дахин хянах гэж байгаа бол дээрх зүйлсийг харгалзан үзэх ёстой. Хятад ДХБ-д элссэнээр олон улсад үзүүлэх нөлөөллийн талаар олон судалгаа хийгдсэн тул бид ердөө л эдгээр судалгааны дүнг хураангуйлж, өөрсдийн цөөн хэдэн бодлыг нэмэрлэсэн билээ.

Тус судалгаа нь хангалттай их байдаг бичмэл материал болон БНХАУ-ын ДХБ-д элсэх асуудал, олон улсын худалдаан дахь тус улсын ая зантай холбоотой олон улсын яриа хэлэлцээнд оролцож байгаа болон эдгээр үйл явдлыг сайн ажиглаж байгаа Брюссель, Бээжин, Улаанбаатар хотын зарим хүмүүстэй хийсэн ярилцлага дээр үндэслэсэн болно.

Ашигласан хамгийн гол эх сурвалж нь ДХБ-д Хятадыг элсүүлэх талаарх албан ёсны баримт бичгээс гадна БНХАУ-ын ДХБ-ын дүрмийг хэрхэн мөрдөж байгааг тогтмол шалгадаг Шилжилтийн дахин хянах механизмын (ШДХМ) бүртгэл юм. Хоёрдогч эх сурвалж нь нууцлалыг хадгалах талаар ойлголцсоны үндсэн дээр зохиогчид өгсөн засгийн газрын баримт бичгүүд юм. Хятадын ДХБ-ын өмнө авсан амлалт, үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх хамгийн дэлгэрэнгүй бөгөөд баялаг судалгааболох Америкийн Нэгдсэн Улсын Худалдааны төлөөлөгчийн тайлан нь жил бүр хэвлэгддэг. Эдгээр найдвартай эх сурвалжаас зохиогч их хэмжээний мэдээлэл авч, олон газар шууд иш татаж ашигласан болно. Европын Холбооны Худалдааны танхим, АНУ-Хятадын бизнесийн зөвлөл зэрэг Хятадад худалдааны сонирхолтой гадаадын бизнесүүдийг нэгтгэсэн олон улсын байгууллагуудын ном, хэвлэлд бизнес эрхлэгчдийн туршлагын талаар бичсэн байдаг нь албан ёсны баримт бичигт орсон баримт мэдээнд нэмэр хачир болно. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын байгууллагууд нь маш их материалыг хэвлэдэг. Хуулийн пүүс болон зөвлөх албануудын гаргасан мэдээллийн хуудаст заримдаа Хятадын эдийн засаг, худалдааны тогтолцооны эрх зүйн маш нарийн асуудлуудын талаар бичсэн байдаг. Холбогдох эрхзүйн баримт бичгүүдийг БНХАУ-ын Худалдааны яам (ХЯ)-ны вэб хуудаснаас англи хэл дээр үзэж болно. Түүнчлэн зохиогч ДХБ-ын тогтолцооны талаарх зарим стандарт, гарын авлага, сурах бичиг ашигласныг дурдах нь зүйтэй.

Ишлэл татсан зүйлийн тоог аль болох бага байлгаснаар уншигчийг гол эх сурвалжаас өөр зүйлд сатааруулахгүйг хичээсэн. Хамгийн гол ном, хэвлэлийг лавлах материалын жагсаалтад нэгтгэн оруулсан. Зохиогч нь нарийн ширийн ном зүйн ажил хийх цаг зав гараагүй тул энэ жагсаалтыг бүрэн болсон гэж хэлж чадахгүй.

Зохиогчийн ярилцаж, мэдээлэл болон санал, бодлоо солилцсон гол хүмүүсийг дурдвал:

Ноён *Рупэрт Шлэгэлмилх*, ЕХ-ны комисс, Худалдааны хэрэг эрхлэх газар, ЕХ-Хятадын харилцааг хариуцсан албаны дарга,

Ноён *Франк Шмийдэл*, Европын комисс, Гадаад харилцааны хэрэг эрхлэх газар, Монгол, Хятадыг хариуцсан ажилтан,

Ноён *Сэржио Балибреа*, Бээжин дэх Европын комиссын төлөөлөгчийн газрын нэгдүгээр нарийн бичгийн дарга,

Ноён *Лу Чиутуан Киутуан*, БНХАУ-аас Германд элчин сайдаар сууж байсан, Хятадын Ардын гадаад бодлогын хүрээлэнгийн ерөнхийлөгч Элчин сайд,

Ноён Ху Иэнгжи, БНХАУ-ын Худалдааны яамны ДХБ-ын асуудал хариуцсан газрын дэд дарга,

Ноён Чэн Фули, БНХАУ-ын Худалдааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд дарга,

Ноён Ли Хаезн, БНХАУ-ын Худалдааны яамны Европын газрын дэд дарга,

Ноён Сун Гуаншун, БНХАУ-ын Шинэтгэл, хөгжлийн үндэсний комиссын хэлтсийн дарга,

Хатагтай *Гэрлинд Хэкманн*, Бээжин дэх Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Элчин сайдын яамны эдийн засгийн зөвлөх,

Хатагтай *Пэтра Зигмунд*, Бээжин дэх Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Элчин сайдын яамны худалдааны зөвлөх,

Ноён *Жэймс Л.Лой*, Бээжин дэх Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамны худалдааны бодлогын ахлах ажилтан,

Ноён *Дэвид Б. Таллок*, Бээжин дэх Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамны худалдааны бодлогын ажилтан,

Д-р *Бйум Этгэн*, Бээжин дэх Европын Холбооны Худалдааны танхимын төлөөлөгчийн газрын Эрх зүйн хорооны дарга өмгөөлөгч,

Д-р *Холгэр Ханиш*, Бээжин дэх Германы аж үйлдвэр, худалдааны төлөөлөгч,

Д-р *Юргэн Штайгэр*, ГТХАН-ийн Хятад дахь төлөөлөгчийн газрын Эдийн засаг, эрх зүй, мэргэжлийн хэлтсийн захирал, хөтөлбөрийн захирал,

Ноён *Д.Галсандорж*, Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын дарга,

Хатагтай *Пунцагноровын Нарангуа*, Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын дэд дарга,

Д-р, инж. *Д.Цогбаатар*, Монгол Улсын Улаанбаатар хот дахь “Эрдэнэт” Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах үйлдвэрийн төлөөлөгчийн газрын тэргүүн нар болно.

Зохиогч нь Монгол-Германы хамтарсан “Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого” төсөлд томилогдон ажиллах хугацаандаа асар их эх сурвалж, үнэтэй материал цуглуулсан ноён *Кристиан Зилис*, Бээжинд уулзалт ярилцлага хийх дэлгэрэнгүй хөтөлбөр зохион байгуулахад их хүчин чармайлт гаргаж, зарим ярилцлагыг хийхэд тусалсан Бээжин дэх Германы Элчин сайдын яамны эдийн засгийн зөвлөх хатагтай *Гэрлинд Хэкманн* нарт онцгой их талархсанаа илэрхийлье.

II. Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа

Монголын эдийн засагт уул уурхай, мал аж ахуй зэрэг тоотой хэдэн салбар давамгайлдаг. Дотоодын хэрэгцээ хязгаарлагдмал учраас Монгол Улс мах, ноос, ноолуур, өлөн, арьс, шир зэрэг мал аж ахуйн гаралтай олон бүтээгдэхүүнийг зөвхөн экспортолдог. Зэс, молибдены баяжмал, хайлуур жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний хувьд мөн адил зөвхөн экспортолдог.¹ Алт нь гадаад валют олдог нэг гол бүтээгдэхүүн юм.

1990 онд ЭЗХТЗ задарсны дараа Монголын гадаад худалдаа үндсээрээ өөрчлөгдсөн билээ. Сүлжмэл эдлэлийг тооцохгүй бол аж үйлдвэрийн барааны экспорт маш их буурсан буюу бүрмөсөн зогсож, түүхий эд голлох болсон. 2001 оны байдлаар үнийн дүнгээр зэсийн баяжмал нийт экспортын 37%-ийг эзэлж, ноолуур, ноолууран бүтээгдэхүүн 24 хүртэл хувийг эзэлж байлаа. Эдгээр бүтээгдэхүүн нь дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзлээс маш их хамааралтай учраас Монголын эдийн засаг нэн эмзэг юм.²

Гэхдээ өнгөрсөн зууны 90-ээд оны үед Монголын гадаад худалдааны хэмжээ маш их өссөн. 1995 онд гадаад худалдааны нийт эргэлт 1 сая америк доллар хүрэхгүй байсан (937.2 сая ам.доллар, үүнээс экспортын хэмжээ 521.9 сая ам.доллар)³ бол 2003 онд 1,416.9 сая ам.доллар хүртэл өсжээ. Энэ хугацаанд экспорт 521.9 сая ам.доллараас 615.9 сая ам.доллар хүртэл бага зэрэг өссөн байхад, импорт 415.3 сая ам.доллараас 801 сая ам.доллар хүртэл буюу бараг хоёр дахин өсжээ. Энэ өсөлт нь Оросоос импортолдог эрчим хүчний үнэ өсөж байгаатай холбоотой. Үүний улмаас Монголын худалдааны тэнцэл 1995-2003 онд тасралтгүй сөрөг гарч байв.

Нөгөө талаар Монголын Хятадтай хийсэн худалдаа эрүүл, эерэг гарч байлаа. Тухайлбал, 1995 онд Хятадтай хийсэн худалдааны эерэг үлдэгдэл 33.3 сая ам.доллар байсан бол 2003 онд 90.7 сая ам.доллар болж өссөн байна. Өмнөд хөршдөө гаргадаг экспорт нь Монголын нийт худалдааны алдагдлыг багасгахад нэмэр болдог тул “Дундад Улс”-тай тогтоосон худалдааны харилцаа нь бүхэлдээ Монголын эдийн засагт шийдвэрлэх ач холбогдолтой юм.

90-ээд оны хоёр дахь хагасаас эхлэн Хятадтай худалдаа хөгжиж эхэлсэн. 1995 онд Хятадтай хийсэн худалдаа дөнгөж 122.3 сая ам.доллар буюу Монголын нийт гадаад худалдааны 13%-ийг эзэлж байлаа. 2003 он гэхэд энэ хэмжээ 483.3 сая ам.доллар (нийт гадаад худалдааны 34.1%) хүрч өссөн. Монголын Хятадад гаргасан экспортын хэмжээ (1995 онд 77.8 сая ам.доллар буюу нийт экспортын 14.9%-ийг эзэлж байв) 287 сая ам.доллар (буюу нийт экспортын 46.6%) хүртэл өссөн бол Хятадаас оруулж ирэх импортын хэмжээ 44.5 сая ам.доллараас (нийт импортын 10.7%) 196. сая ам.доллар (24.5%) хүртэл өсжээ.

Монголоос Хятад руу гаргах экспортын хэмжээ 1997 онд хамгийн их өсөж 234.4 сая ам.доллар хүрснээр 1996 оны экспортоос даруй 189.4%-иар нэмэгдсэн бөгөөд 2000 онд мөн нэлээд их өсжээ (274.3 сая ам.доллар; 32%). Хятадаас оруулж ирэх импорт үүнээс арай бага хувиар өссөн. Тухайлбал 1997, 1998 онд импортын хэмжээ бага зэрэг буурсан, 2001 онд “дөнгөж” 8.6%-иар өссөнийг эс тооцвол жил бүр хоёр оронтой хувиар өсөж байлаа.

Зэс, молибдены баяжмал нь Монголын Хятадад гаргадаг экспортын гол бүтээгдэхүүн юм. Хятадын эдийн засгийн эрчтэй өсөлтийн үр дүнд эдгээр

¹ Банзэ, “ДХБ-д Хятад улс гишүүнээр нэгдэн орох нь Монгол улсад нөлөөлөх тухай асуудал”, х. 2

² Мөн эх сурвалжид

³ Монголын Улсын Үйлдвэр, худалдааны яамнаас өгсөн статистик мэдээн дээр үндэслэв

бүтээгдэхүүний борлуулалт 1995 онд ялихгүй хэмжээтэй буюу 6.3 сая ам.доллар байснаа 2003 онд 177.3 сая ам.доллар болж өссөн нь Хятад руу гаргадаг нийт экспортын 36.7%-ийг бүрдүүлж байна. Экспортын хоёр дахь гол бүтээгдэхүүн бол хонины нэхий, ямааны арьс юм. Тухайлбал 2003 онд нийт 36.9 сая ам.долларын хонины нэхий, ямааны арьс экспортолсон нь нийт экспортын 7.6%-ийг эзэлж байна. Хамгийн гайхалтай нь экспортод гаргасан ноолуур (самнасан болон угаасан) дөнгөж 20.4 сая ам.доллар (буюу Хятад руу гаргасан нийт экспортын 4.22%) байсан нь Монголын нийт экспортод тус бүтээгдэхүүний эзэлдэг хувиас (24%) хамаагүй бага байлаа. Гэхдээ Улаанбаатарт уулзаж ярилцсан нэрээ хэлэхийг хүсээгүй нэгэн хүний хэлснээр Хятад руу гаргадаг ноолуурын ихэнх хэсгийг албан бус замаар гаргадаг тул худалдааны албан ёсны тоо баримтад Монгол-Хятадын худалдааны харилцаан дахь ноолуурын эзлэх хувийн жинг ихэд дарсан байдаг ажээ.⁴ Хятадад мөн маш бага хэмжээгээр боловч газрын тос гаргадаг (2003: 4.6 сая ам.доллар).

Монголын экспортын гол бүтээгдэхүүний хувьд Хятадын зах зээлд нэвтрэх боломж ерөнхийдөө таатай. Тухайлбал, зэс, молибдены баяжмал болон газрын тосны гаалийн татварын заавал дагаж мөрдөх хувь хэмжээ тэг байдаг. Гэхдээ газрын тосны хувьд одоо хүртэл улсын худалдаанд хамаарах бүтээгдэхүүн хэвээр байгаа юм.⁵ Арьс ширний гаалийн татварын заавал дагаж мөрдөх хувь хэмжээ (одоо хүртэл тусгай эрх олгосон худалдаанд хамаардаг хэвээр)⁶ 9-14% байгаа бөгөөд ноолуурын хувьд үзүүлэлтээсээ хамааран 7.7%-9% тус тус байна. Монголд ноолуурын экспортод 15%-ийн татвар ногдуулсан боловч Хятадын худалдан авагчид төлөхгүй байх нь олонтаа.⁷ Монголоос Хятад руу одоохондоо их хэмжээгээр экспортолдоггүй хувцас хунарын тухайд 2004, 2005 онд импортын татвар тус тус 25% байсан.

Хятадаас оруулж ирдэг Монголын импортын бүтээгдэхүүн нь хөнгөн аж үйлдвэрийн маш олон төрлийн бүтээгдэхүүн, үүний дотор ихэвчлэн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээс бүрддэг. Импортын нэг гол бүтээгдэхүүн бол хувцас (сүлжмэл бараа, оёмол хувцас) бөгөөд 2003 онд 11.1 сая ам.доллар хүрч байв.⁸

Хятадын бараа, бүтээгдэхүүний хувьд Монголын зах зээлд нэвтрэх боломж нөхцөл мөн адил таатай. 1994 онд Монгол Улсын Засгийн газар 33 гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд ногдуулах импортын татварын хувийг 10%-иас тэг хүртэл бууруулсан. 1997 онд ДХБ-д элсэхдээ Монгол Улс цөөн нэр төрлийн (тансаг хэрэглээний) бараа, бүтээгдэхүүнээс бусад бүх бараа, бүтээгдэхүүнд ногдуулдаг импортын татварыг тэглэсэн.

Цар хүрээ, хэмжээний хувьд хязгаарлагдмал Монгол-Хятадын эдийн засгийн харилцаа нь Монгол Улс дахь Хятадын хөрөнгө оруулалттай цөөн хэдэн аж ахуйн нэгжээр хязгаарлагдана. Тэдгээрийн нийт хөрөнгө оруулалт нь албан ёсны бүртгэлээр дөнгөж 145 сая ам.доллар ажээ.⁹ Үйл ажиллагаа нь гол төлөв сүлжмэл

⁴ 32, 60-р хуудсыг үзнэ үү - Марфи (FEER 27. 2002 оны 6-р сар, х. 37) 2000 онд үйлдвэрлэсэн нийт түүхий ноолуурын 44%-ийг (50 сая ам.долларын үнэ бүхий) Хятад руу хууль бусаар гаргажээ. Штиль - "Монгол, Хятадын ноолуурын үйлдвэрийг харьцуулсан дүн шинжилгээ" номын х.10 болон энэ тухай дурдсан бусад хуудсыг үзнэ үү.

⁵ Дэлгэрэнгүй мэдээллийг х.9-өөс үзнэ үү

⁶ Дэлгэрэнгүй мэдээллийг х.10-аас үзнэ үү

⁷ Штиль, мөн эх сурвалж х. 10

⁸ Монголын улсын Үйлдвэр, худалдааны яамнаас өгсөн статистикийн мэдээнд зөвхөн гол бүтээгдэхүүнүүдийг тусгасан бөгөөд нарийн ширийн мэдээлэл хангалттай биш байлаа. Хятадаас оруулах импорт нь маш бага хэмжээгээр орж ирэх зүйлсээс бүрддэг байх магадлал их бөгөөд ийм бараа, бүтээгдэхүүний тоо, баримтыг оруулаагүй.

⁹ Улаанбаатар дахь Германы Элчин Сайдын Яам, "Эдийн засгийн жилийн тойм - 2002", х.8 (Монголын статистик мэдээнд үндэслэсэн)

эдлэл болон хувцасны үйлдвэрт төвлөрчээ. Хятадын хөрөнгө оруулагчдын олонх нь Хятадын сүлжмэл эдлэл болон хувцасны экспортод ногдуулсан хатуу квотоос зугтсан хувийн бизнесүүд юм. Эдний хамтарсан үйлдвэрүүд заримдаа Хятадаас импортоор оруулж ирсэн бараг бэлэн бүтээгдэхүүнд шошго наах төдий багахан өртөг нэмэх л ажил хийдэг ажээ. Цаад тал нь 2004 оны эцэс гэхэд Хятадын сүлжмэл бараа, бүтээгдэхүүний экспортод тавьсан квот хязгаарлалтыг арилгах тул түүний дараа удахгүй Хятадын зарим хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа татна гэсэн айдас Улаанбаатарт их тархжээ.

Далайд гарцгүй орны хувьд Монгол Улс Хятадаар дамжуулан хийдэг тээвэрлэлтээс маш их хамааралтай. Монголын гадаад худалдааны бараа, бүтээгдэхүүний ихээхэн хэсгийг Улаанбаатараас 1,700 км зайтай орших Тяньжин боомтоор дамжуулан тээвэрлэдэг. Тээвэрлэлтийн өндөр үнэ, өртөг нь экспорт, импортын бүх бараа, бүтээгдэхүүний үнэ дээр нэмэгддэг. Энэхүү тээвэрлэлтийн ихэнх хэсгийг татахын тулд Хятадын төмөр зам Монгол руу ирж, очих тээврийн тарифыг хэдэн жилийн өмнө 50%-иар бууруулсан боловч мөрдөж байгаа тарифын хэмжээ Хятадын дотоодын тарифаас мэдэгдхүйц их байсаар байна.¹⁰

¹⁰ Мөн х. 32, 60/61-ийг үзнэ үү.

III. Хятад олон талт худалдааны тогтолцооны гишүүний хувьд

III 1 Өмнөх үг

Арван зургаан жилийн турш хүнд, хүчир хэлэлцээ явуулсны эцэст 2001 оны 12 дугаар сарын 11-нд БНХАУ ДХБ-д элсэн орсон.¹¹

Хятадын ДХБ-д элсэн ороходоо авсан амлалт, үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг дүгнэх гэж байгаа бол Хятад ЭТП-д гарын үсэг зурж байхад ямар дүрэм, зарчмыг дагаж мөрдөнө гэж байсныг эргэн санах хэрэгтэй. ДХБ-ыг байгуулсан Марракешийн гэрээний XII зүйлд заасан “нэгдсэн амлалт үүрэг авах дүрмийн” дагуу ийнхүү элсэхдээ улс төрийн хэллэгээр Олон талт худалдааны тогтолцоо (ОТХТ) гэх бүхэл багц гэрээ, хэлэлцээрийг дагаж мөрдөх үүргийг хүлээдэг. (ЭТП-ын 1-р заалтыг мөн үзнэ үү).

ОТХТ-г улс орнууд бие биетэйгээ худалдааны харилцаанд ороходоо дагаж мөрдөх шаардлагатай олон улсын дүрэм, журам гэж ерөнхийд нь тодорхойлж болно. Эдгээр дүрэм журмын үндсэн зорилго нь улс орнуудыг нээлттэй, либерал худалдааны бодлого явуулахыг хөхиүлэн дэмжихэд оршино. Эдгээр дүрэм журмыг дэлхийн худалдааны өөрчлөгдөх нөхцөл байдалтай нийцүүлэхийн тулд тасралтгүй хувьсган өөрчилж, тодруулж байдаг.¹²

ОТХТ нь олон улсын барааны худалдаагаар хязгаарлагдсан дүрэм, журам болох Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрээс (ТХЕХ) үүссэн юм. Анх 1948 онд маш цөөн тооны улс орон ТХЕХ-ийг байгуулжээ. Удаан хугацааны турш ТХЕХ-ийг голдуу баян чинээлэг хөгжингүй орнууд сонирхдог гэж боддог байсан тул нэг маягийн баячуудын клуб гэж үздэг байлаа. Олон жилийн турш ялангуяа хөгжиж буй орнуудын худалдааны асуудлыг шийдвэрлэхийн тулд шинэ зүйл заалт оруулахаар ТХЕХ-т нэмэлт, өөрчлөлтийг оруулж байлаа. Үүний зэрэгцээ ТХЕХ-ийн зарим гол зүйлийг тусгасан дагалдах олон гэрээ, хэлэлцээрийг баталсан.

1986-1994 онд хийсэн Худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатанд хамгийн том нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. ТХЕХ-т нэмэлт, өөрчлөлт оруулсны зэрэгцээ (одоо ТХЕХ 1994 гэж нэрлэдэг) хөдөө аж ахуй, сүлжмэл эдлэл, татаас, дампингийн эсрэг ба хамгаалах арга хэмжээ болон бусад асуудлаар тусгай хэлэлцээрүүд баталсан. Үүнтэй адилаар Уругвайн үе шатны үр дүнд үйлчилгээний худалдаа, оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлуудаар шинэ дүрэм, журмыг батлав.¹³

Өнгөрсөн зууны сүүлийн хорин жилээс эрс хурдассан даяаршлын үйл явц, коммунизм нуран унаснаар ихэнх оронд зах зээлийн хандлагатай эдийн засгийн тогтолцоо, бодлого аажмаар нэвтэрсний үр дүнд, ОТХТ хуучин социалист байсан болон хөгжиж буй орнуудын сонирхлыг их татсан. Дэлхийн хамгийн том социалист бөгөөд хөгжиж буй улс болох Хятад ДХБ-д 143 дахь гишүүнээр элссэнээр энэхүү баримтыг баталгаажуулж байна. 2004 оны 10-р сарын байдлаар ДХБ-ын гишүүдийн тоо 147-д хүрчээ.

III 2 ДХБ-ын эрх зүйн гол баримт, бичиг ба ДХБ-д элсэн ороход Хятадын авсан үүрэг, амлалтын товчоон

Уругвайн үе шатны хэлэлцээгээр тохирсны дагуу ДХБ-ын тогтолцоо нь гурван үндсэн материаллаг багц хэлэлцээрээс бүрдэх ажээ:

¹¹ Хэлэлцээний түүхийг дараах номоос үзнэ үү: Чан, “Хятад ба ДХБ: Дүрмийг дагаж мөрдөх онол, практикийн асуудал” х.2 з. (5)

¹² “Дэлхийн худалдааны тогтолцоонд бизнес эрхлэх лавлах” х. 3

¹³ Мөн эх сурвалжид х. 4/5

1. Барааны худалдаа

- Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ 1994)
- Дагалдах хэлэлцээрүүд
 - ③ ТХЕХ 1994-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр (Гаалийн үнэлгээ)
 - ③ Ачуулахын өмнөх хяналтын тухай хэлэлцээр (АӨХТХ)
 - ③ Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр (ХТСТ)
 - ③ Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ авах тухай хэлэлцээр (ЭАУЭА)
 - ③ Импортын тусгай зөвшөөрөл олгох журмын тухай хэлэлцээр
 - ③ Хамгаалах арга хэмжээний тухай хэлэлцээр
 - ③ Татаас, саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр (ТСАХТХ)
 - ③ ТХЕХ 1994-ийн VI зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр (Дампингийн эсрэг дүрэм) (ДЭД)
 - ③ Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (ХХОАХ)
 - ③ Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцасны тухай хэлэлцээр
 - ③ Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр
 - ③ Гарал үүслийн талаарх дүрэм, журмын тухай хэлэлцээр

2. Үйлчилгээний худалдаа

- Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээр (ҮХЕХ)

3. Оюуны өмчийн эрх (ОӨЭ)

- Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр (ОӨЭХХА)¹⁴

Энэхүү тогтолцоонд Хятадын элссэн баримт бичиг нь 900 орчим хуудас бөгөөд хамгийн чухал хэсэг нь Элсэх тухай протокол (ЭТП) ба Хятад ДХБ-д элссэн тухай ажлын хэсгийн тайлан (АХТ) юм. Нарийн төвөгтэй шинж, тусгай амлалтын хүрээ, элсэх үед зөвшөөрсөн гажилтын тоо зэргээр ДХБ-ын түүхэнд урьд өмнө гарч байгаагүй элсэлт болсон.¹⁵ Энэхүү баримтыг Хятадын засгийн газрын төлөөлөгчид дэлхийн худалдааны нийгэмлэгт нэг орон элсэхэд асар их буулт хийсэн явдал болсон гэж заримдаа тэмдэглэж хэлдэг. Гэхдээ энэхүү “буулт”-ын шалтгааныг Хятадын анх хаалттай, өвөрмөц, ил тод биш эдийн засгийн тогтолцоо, ДХБ-ын гишүүн улс орнуудын ямар нэг хэмжээгээр зах зээлийн хандлагатай, нээлттэй эдийн засгийн тогтолцооны хооронд урьд өмнө байсан - зарим талаар одоо ч оршоор байгаа – асар их зөрүү ялгаагаар амархан тайлбарлаж болно. Тийм учраас БНХАУ-ын эдийн засаг, худалдааны тогтолцоог ДХБ-ын гишүүн улс орнуудын тогтолцоотой нийцүүлэхийн тулд уг баримт бичигт шийдвэрлэх ёстой асар олон асуудлыг тусгах шаардлагатай болсон.

Энэхүү судалгааны хүрээнд БНХАУ-ын элсэхдээ авсан амлалт, үүргийг дэлгэрэнгүй тодорхойлох боломжгүй. Нөгөө талаар ДХБ-ын дүрэм, зарчмыг БНХАУ хэрхэн биелүүлж байгааг дүгнэх хэмжүүр байдлаар тэдгээрийг товчхон тодорхойлох шаардлагатай.

ОТХТ-ны асар их, бүр тоо томшгүй олон дүрэм журмыг дөрвөн үндсэн зарчим, хэрэгжүүлэлтийн ерөнхий гурван дүрэм, бусад зарим дүрэм зэрэг гол хэдэн зүйл болгон хураангуйлсан “Дэлхийн худалдааны тогтолцоонд бизнес эрхлэх

¹⁴ Мөн эх сурвалж х.5

¹⁵ Чан-ыг үз, мөн эх сурвалж х.3 (зүүлт 3)

лавлах”¹⁶-ад боловсруулсан матрицыг энэ зорилгод ашиглавал хэрэгтэй мэт санагдана. Энэхүү хандлагыг бараа, үйлчилгээний худалдааны зэрэгцээ оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдох арга хэмжээнд баримтална. Бид эдгээр үндсэн зүйлийн талаар ойлголттой болсныхоо дараа ОТХТ-ны үзэл санаа, дүрэм журмыг баримтлахын тулд Хятадын авсан гол амлалт үүргийг тодорхойлно. ЭТП, АХТ-д ОТХТ-ны дүрмээс түр хугацаанд гажихыг зөвшөөрсөн зарим чиглэлийг заасан. Ийм хөнгөлөлтийг мэдэгдэж, харилцан тохиролцсон үед хэрэгжүүлэх боломжтой бөгөөд цаг хугацааны хувьд үе Шаттайгаар хэрэгжүүлнэ. Бусад аливаа гажилтыг дүрэм журмыг дагаж биелүүлээгүй гэж үзнэ.

III 2.1 Барааны худалдааны дөрвөн үндсэн дүрэм

ТХЕХ-ийн тогтолцоо дөрвөн багана дээр тулгуурладаг:

- Дотоодын үйлдвэрлэлийг тарифаар хамгаалах (“тарифжуулах”)
- Заавал баримтлах тариф,
- Нэн тааламжтай үндэсний нөхцөл (НТҮ),
- Үндэсний нөхцөлийн дүрэм.

III 2.1.1 “Тарифжуулах”

ТХЕХ худалдааны дэвшилтэт либералчилал хийх зорилготой боловч, гишүүн улс орнууд нь дотоодын үйлдвэрлэлээ гадаад өрсөлдөөний эсрэг хамгаалах шаардлагатай байж болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ ийнхүү хамгаалахдаа тарифын бус саад тотгор (ТБСТ) хэмээх захиргааны хязгаарлалтаас илүү тариф хэрэглэхийг шаарддаг.

Худалдааны бүхий л түүхэнд хэрэглэж байсан хамгийн үр дүнтэй ТБСТ бол улсын худалдааны монополи юм. Засгийн газар худалдааны эрх олгодог бол бараа, үйлчилгээний хил дамнасан хөдөлгөөнийг хянах өөр хязгаарлалт хэрэггүй. Тийм учраас БНХАУ ДХБ-д элсэхдээ хэрэгжүүлэх нэг гол зорилт нь уламжлалт улсын худалдааны монополи эрхийн үлдэгдлээс салахад оршино. Энэ үүднээс ЭТП-ын 5-р заалтад “Хятад худалдааны эрхийг дэвшилтэт байдлаар либералчилна. Ингэснээр элссэнээс хойш гурван жилийн дотор Хятадын бүх аж ахуйн нэгж Хятадын гаалийн нутаг дэвсгэр даяар бүх бараагаар худалдаа хийх эрхтэй болно. Гэхдээ Хавсралт 2А-д заасан бараануудыг зөвхөн улс худалдаалдаг хэвээр байх болно...”¹⁷ Худалдааны ийм эрх нь бараа импортлох, экспортлох эрх юм. ТХЕХ 1994-ийн III зүйлийн дагуу ийм бүх барааны дотоод борлуулалт, борлуулах, худалдан авах санал, тээвэрлэлт, түгээлт, ашиглалт, үүний дотор эцсийн хэрэглэгчид шууд хүртээмжтэй байх нь үндэсний нөхцөлд хамаарна. Хавсралт 2Б-д заасан барааны хувьд Хятад тухайн хавсралтад заасан хуваарийн дагуу худалдааны эрхийг олгох хязгаарлалтаа аажмаар арилгана”¹⁸ гэжээ.

ТХЕХ 1994-өөр Хятадын засгийн газар олон жилийн турш худалдааны урсгалыг хянахдаа хэрэглэсээр ирсэн цөөн тооны нөхцөл байдалд тооны хязгаарлалт тогтоохыг зөвшөөрсөн. Тиймээс ЭТП-ын 7-р заалтад импортын тусгай зөвшөөрөл, импортын квот, импортын тендерт хамаарах бүтээгдэхүүний урт жагсаалтыг

¹⁶ х. 7 f.

¹⁷ Импортын хувьд ийм бүтээгдэхүүн гэвэл: Үр тариа, хүнсний ногоо, тос, элсэн чихэр, тамхи, түүхий болон боловсруулсан газрын тос, химийн бордоо, хөвөн. Экспортын хувьд, цай, цагаан будаа, эрдэнэ шиш, шар буурцаг, вольфрамын хүдэр, аммоны бүтээгдэхүүн, вольфрамын бүтээгдэхүүн, нүүрс, түүхий болон боловсруулсан газрын тос, торго, хөвөн, хөвөн бүтээгдэхүүн, сурьма, мөнгө улсын худалдаанд хамаарах бүтээгдэхүүн юм.

¹⁸ Тусгай эрх олгосон худалдаанд хамаарах бүтээгдэхүүн гэвэл каучук, мод, фанер, ноос, акрилик, ган зэрэг болно

“нэмэгдүүлэхгүй байж, улмаар арилгах” ёстой гэж заасан. Эдгээр хязгаарлалтын олонхыг 2004 он гэхэд арилгах ёстой бөгөөд цөөн тоон хязгаарлалтыг л (автомашин болон түүнтэй төстэй бүтээгдэхүүнтэй холбогдох) 2005 он хүртэл байлгахыг зөвшөөрсөн.

Зарим барааны импортыг хязгаарлах шаардлагатай бол, ТХЕХ энэхүү зорилтыг тарифын түвшний квот буюу ТТК-оор хэрэгжүүлэх хэрэгтэй гэж заасан. Үүний дагуу тодорхой квот хүртэл импортын татвар бага байх бөгөөд квотоос дээш гарвал их (ердийн) татвар ногдуулна.

III 2.1.2 Заавал баримтлах тариф

ТХЕХ-ийн дүрмээр тарифаа бууруулж, олон талт худалдааны хэлэлцээн дэх худалдааны бусад саад тотгорыг арилгах замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах хамгаалалтаа сулруулах, болж өгвөл болиулахыг улс орнуудаас уриалсан. Ийнхүү бууруулсан тарифыг улс орон бүрийн үндэсний жагсаалтад оруулж цаашид нэмэгдүүлэхгүй байхыг шаарддаг. Эдгээр жагсаалт нь ТХЕХ-ийн эрх зүйн тогтолцооны нэгэн салшгүй хэсэг юм.

ДХБ-д элсэхээсээ өмнө болон элсэх үедээ Хятад үнэхээр маш лут тарифын хөнгөлөлтүүд хийсэн. Үүний үр дүнд 2001 онд 12% байсан жигнэсэн дундаж тариф нь хэрэгжүүлэлтийн үеийн эцэст 6.8%¹⁹ болж буурсан. Гэхдээ тариф бууруулах арга хэмжээний ихэнхийг элсэн орсноос хойш таван жилийн дотор хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Гэвч тарифын энэхүү бууралтыг 1992-2001 оны хооронд 29%-иар буурч байсантай харьцуулбал бага юм.

ДХБ-д элссэний дараах тарифын түвшнийг "заавал баримтлах" ёстой. Тухайлбал Хятад ДХБ-ын дүрмийн дагуу тарифын хөнгөлөлтүүдээ дахин тэнцвэржүүлэх зэргээр ДХБ-ын худалдааны түншүүддээ “нөхөн төлбөр” хийхгүйгээр заавал баримтлах тарифаа нэмэгдүүлж болохгүй. Ингэсэн тохиолдолд ДХБ-ын бусад гишүүд адилтгах хөнгөлөлтүүдээ цуцлах арга хэмжээ авна. Хятад мөн гол салбарын хөгжилд шаардлагатай гэж засгийн газрын тодорхойлсон барааны хувьд ДХБ-аас шаарддаг түвшнээс маш доогуур тариф хэрэглэж болно.²⁰

III 2.1.3 Нэн тааламжтай үндэсний нөхцөл (НТҮ)

НТҮ-ний зарчмын зорилго нь худалдааны түншүүдийг хооронд нь ялгаварлан гадуурхахыг таслан зогсоход оршино. Энэхүү дүрмийн дагуу улс орнуудыг хооронд нь ялгаварлан гадуурхахгүйгээр импорт, экспортын бараанд тариф болон бусад дүрэм журам хэрэглэх ёстой. Тэгэхээр нэг улс нөгөө улсаас оруулж байгаа импортод бусад улсаас оруулж байгаа импортод ногдуулдгаас өндөр гаалийн татвар ногдуулахыг хориглоно.²¹ Тийм учраас БНХАУ хөрш зэргэлдээ орнуудтайгаа хийх хилийн худалдаа хэмээгчийг зохицуулдаг тариф, тусгай зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлсөн буюу тэдгээрийг хөнгөлсөн тусгай дүрэм журмаа ажмаар арилгах ёстой. (ЭТП-ын 4-р заалт)

Гэхдээ энэ дүрэмд хамаарахгүй зарим зүйл бий:

Бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн гишүүн орнуудын хоорондох худалдаа хөнгөлөлттэй тарифтай буюу гаалийн татваргүй байдаг нь дээрх дүрэмд

¹⁹ Мартин-Бхаттасали-Ли, Хятад ДХБ-д элссэн нь – Хятадад үзүүлэх нөлөө, Зүүн Азийн интеграци, х.4 АНУ-ын худалдааны төлөөлөгчийн тооцолсноор, ДХБ-ын гишүүн болсон эхний жилд буюу 2002 онд тариф 15%-иас 12% болтол буурсан (“АНУ-ын Худалдааны Тойм – Хятад улс” х. 61)

²⁰ АНУ-ын Худалдааны Тойм, мөн эх сурвалж.

²¹ Бизнес лавлах х. 7

хамаарахгүй нэг зүйл юм. Хэрэв Хятад АСЕАН-тай худалдаа хийх чөлөөт худалдааны бүс байгуулах гэж байгаа бол үүнийг ашиглаж болно. Ийм гэрээ хэлэлцээр нь Монгол Улсад экспортын зарим өрсөлдөгч бүтээгдэхүүний хувьд муугаар нөлөөлж болно.

Хөнгөлөлтийн ерөнхий системээр мөн дээрх дүрмээс чөлөөлөгдөж болно. Энэхүү системийн дагуу хөгжингүй орнууд хөгжиж буй орнуудын импортод хөнгөлөлттэй тарифыг ногдуулах буюу тэдгээр орны импортыг гаалийн татвараас чөлөөлж, бусад орны импортод НТҮ-ний тарифыг ногдуулдаг.

III 2.1.4 Үндэсний нөхцөлийн дүрэм

НТҮ-ний дүрэм өөр өөр улс орноос гаралтай бараа, бүтээгдэхүүнийг хооронд нь ялгаварлан гадуурхахыг хориглодог бол Үндэсний нөхцөлийн дүрэм нь импортын ба дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүдийг дотооддоо татвар ногдуулж, дүрэм журам хэрэгжүүлэхдээ хооронд нь ялгаварлан гадуурхахыг хориглодог.²²

Хятадын хувьд Үндэсний нөхцөлийн зарчмын дагуу үл ялгаварлах дүрэм нь НТҮ-ний зарчмын дагуу үл ялгаварлах дүрмээс хамаагүй илүү чухал юм. Учир нь гадаадын болон Хятадын компаниудыг хооронд нь ялгаварлан гадуурхах төдийгүй Хятадын болон гадаадын хөрөнгө оруулалттай Хятадын компаниудыг хооронд нь ялгаварлан гадуурхах явдал түгээмэл хэвээр байна. Тийм учраас БНХАУ-ын элсэн орох тухай баримт бичигт энэхүү асуудлын талаар нэлээд дэлгэрэнгүй тусгасан байдаг.

ЭТП-д бичсэнээр – үндэсний нөхцөлийн зарчим хэмээх үүргийн дагуу “Хятад ДХБ-д элсэн орохдоо гадаадын иргэд, аж ахуйн нэгжүүд, гадаадын санхүүжилттэй аж ахуйн нэгжүүд бусад иргэд болон аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг нөхцөлөөс муу биш нөхцөлийг олгоно ...” гэж ЭТП-д удаа дараа заасан. Ялангуяа дараах зүйлсийн хувьд энэхүү нөхцөлийг олгохоор заажээ. Үүнд:

- Худалдаа хийх эрх (5:2)²³,
- Импорт, экспортын тусгай зөвшөөрөл (8:2),
- Импорт, экспортод ногдуулах татвар, хураамж (11:4),
- Импорт, үйлдвэрлэлд шаардлагатай бараа, үйлчилгээ худалдан авах,
- Барааг дотоодын зах зээл болон экспортод зориулан үйлдвэрлэх, сурталчлах, борлуулах нөхцөл (3а)
- Үндэсний болон орон нутгийн эрх барих байгууллага, улсын үйлдвэрийн газруудын үйлдвэрлэл, тээвэрлэлт, эрчим хүч, үндсэн харилцаа холбоо, бусад дэд бүтэц, хүчин зүйлийн чиглэлээр нийлүүлдэг бараа, үйлчилгээний үнэ, хүртээмж (3б).

Импортын болон дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнд ижил нөхцөл олгохын тулд дүрэм журам, стандарт, тохирлын үнэлгээний журам, хураамж, холбогдох эрх бүхий байгууллагуудын тухай заасан ЭТП-ын 13:4 зүйлд үүнтэй төстэй заалт оруулсан.

Тодорхой бус дүрэм журам, эрх баригчдын ил тод бус үйл ажиллагаа нь дотоодын аж ахуйн нэгжүүдийг бодвол гадаадын аж ахуйн нэгжүүдэд илүү бэрхшээл учруулж байгаа тул худалдааны дэглэмийн ил тод байдлыг хангах нь үндэсний нөхцөлийн бас нэг чухал зүйл юм.

²² Мөн эх сурвалж. х. 8

²³ Мөн дээрхийг үзнэ үү х. 9

Ил тод байдал гэдэг нь ДХБ-ын дүрэм журмыг Хятадын гаалийн нийт нутаг дэвсгэр даяар, үүний дотор тусгай хууль дүрэм үйлчилдэг эдийн засгийн тусгай бүсүүд, нээлттэй хотууд, хилийн бүсүүдэд нэгэн жигд хэрэгжүүлнэ гэсэн үг. Зүй ёсоор мэдэгдсэн бүс, дэглэмүүдийг энэ заалтаас чөлөөлнө (ЭТП-ын 2А, Б заалтууд).

ДХБ-ын дүрэм журмыг дагаж мөрдөхийн тулд Хятад импорт, экспортын зөвшөөрөл өгөх ажлыг хариуцсан бүх байгууллага, ийм тусгай зөвшөөрөл авах журам, шалгуур, тендер явуулахыг шаарддаг бүтээгдэхүүнүүд, импортлох буюу экспортлохыг хязгаарласан буюу хориглосон бүх бараа, технологийн жагсаалтыг хэвлэнэ (ЭТП-ын 8-р зүйл).

Цаашилбал Хятад ДХБ-д тусгай зөвшөөрөл, квотын бүх шаардлага, журам (ЭТП-ын 8-р зүйл), Татаас, саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн (ТСАХТХ) I зүйлд заасан утгын хүрээнд тодорхой бүтээгдэхүүнээр олгосон, дэмжсэн, зохион байгуулсан татаас, үүний дотор ердийн экспортын татаасын (ЭТП-ын 10-р зүйл) талаар мэдэгдэх ёстой.

Хятад мөн Үндэсний нөхцөлийн зарчимтай зөрчилддөг олон шатлалт үнэ тогтоох практикаа устгах ёстой. Учир нь гадаадын иргэд болон хөрөнгө оруулалттай компаниуд бараг бүх юманд илүү үнэ төлөх ёстой байдаг. Үнийн хяналтыг арилгахаар олон жил чармайж байгаа боловч зарим бүтээгдэхүүн хувьд үнийн хяналттай хэвээр байна. Ямар ч тохиолдолд ийм арга хэмжээг нийтэд мэдэгдэх ёстой (ЭТП-ын 9-р зүйл).²⁴

Худалдааны дэглэмийн бүрэн ил тод байдлыг хангахын тулд арга хэмжээтэй холбоотой, олон нийтэд мэдэгдэх шаардлагатай мэдээллийг олж авах боломжтой лавлах цэгийг байгуулах ёстой (ЭТП-ын 2В:3).

III 2.2. Хэрэгжүүлэлтийн ерөнхий гурван дүрэм

Дээр тодорхойлсон дөрвөн үндсэн дүрмийн зэрэгцээ гаалийн нутаг дэвсгэрт орж ирэх барааг зохицуулах хэрэгжүүлэлтийн ерөнхий дүрмүүд бий.²⁵

III 2.2.1 Гаалийн татвар ногдуулах үнийг тодорхойлох

ДХБ-ын гаалийн зорилгоор барааг үнэлэх тухай дэлгэрэнгүй дүрэм нь ТХЕХ 1994-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрт (Гаалийн үнэлгээ) багтсан. Энэхүү үнэлгээний тогтолцоо нь худалдааны практикийг харгалзан үзсэн энгийн, шударга шалгуур дээр үндэслэсэн. Үндсэн дүрэм нь гаалийн татвар ногдуулах үнэ нь импортлогч улсад экспортлох үед яг төлсөн буюу төлөх үнэ дээр үндэслэх ёстой гэсэн дүрэм юм. (Тус хэлэлцээрийн 1:1 зүйл). “Нэхэмжлэлийн үнэ” хэмээгчид зуучлалын төлбөр (худалдан авах зуучлалаас бусад), баглаа боодол, сав, туслах зүйлс (материал, багаж хэрэгсэл гэх мэт), үйлчилгээ (төлөвлөх, зохион бүтээх гэх мэт), лиценз ашиглалтын төлбөр, хураамж, импортын барааг дахин борлуулах буюу ашигласнаас борлуулагчид хуримтлагдах борлуулалтын орлого, тээвэр, даатгал, холбогдох хураамжийн зардал (СИФ үнийн тохиолдолд) зэргийг оруулахын тулд өөрчлөх ёстой.

Орохгүй зүйлс: импортолсны дараах тээврийн зардал, барилга, угсралтын зардал, импортын татвар (Хэлэлцээрийн 8-р зүйл).

²⁴ ЭТП-ын хэвсралт 4-ийг үзнэ үү: *тамхи, хоолны давс, байгалийн хий, эм, үр тариа, ургамлын тос, бордоо, торгоны хүр хорхойн үүр, хөвөн, ус, цахилгаан, цахилгаан холбооны үйлчилгээ.*

²⁵ „Бизнесийн лавлах“ х.8

Нотлох үүргийг шилжүүлэх тухай шийдвэрийн 1-р заалтын дагуу гаалийн байгууллага нь ажил гүйлгээний үнийг цөөн тохиолдолд л татгалзаж болно. Тухайлбал:

- борлуулалт хийгээгүй бол,
- худалдан авагч барааг байршуулах, ашиглахад хязгаарлалт байгаа бол (хуулиар тогтоосон хязгаарлалт, барааг борлуулж болох газарзүйн бүсийн хязгаарлалт, барааны үнэд нөлөөлөхгүй хязгаарлалтаас бусад),
- борлуулалт буюу үнэ цэнийг нь тодорхойлох боломжгүй зарим нөхцөлөөс хамаарах үед,
- худалдан авагч дамжуулан борлуулснаас олох орлогын хэсэг нь борлуулагчид хуримталж байгаа бол,
- худалдан авагч, борлуулагч нар холбоотой бөгөөд энэхүү харилцаа нь үнэд нөлөөлж байвал (шилжүүлэх үнэ хэмээгч).

Мэдэгдсэн үнийн талаар гааль эргэлзээтэй байгаагаа илэрхийлбэл импортлогч нь тайлбар өгөх эрхтэй бөгөөд хэрэв энэ нь хангалтгүй бол гааль шийдвэрийг гаргана. Импортлогч нь шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй.²⁶

III 2.2.2 Заавал дагаж мөрдөх стандарт, эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн дүрэм журмыг хэрэгжүүлэх нь.

Улс орнууд хүн амынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж, байгаль орчныг хамгаалахын тулд баталсан заавал дагаж мөрдөх стандарттай нийцсэн байх шаардлагыг импортын бүтээгдэхүүнд тавьдаг.

Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрт (ХТСТ) заавал дагаж мөрдөх бүтээгдэхүүний ийм стандартыг хэрэглэхдээ олон улсын худалдаанд хэрэгцээгүй саад тотгор учруулахгүй байх ёстой гэж заасан. Цаашилбал эдгээр стандарт нь шинжлэх ухааны мэдээлэл, нотолгоон дээр суурилсан байх ёстой.²⁷

Хэлэлцээрт зааснаар заавал дагаж мөрдөх бүтээгдэхүүний стандарт нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт дээр үндэслэсэн болхудалдаанд хэрэгцээгүй саад тотгор учруулахгүй. Газарзүй, цаг уурын болон бусад шалтгаанаар гишүүн улс орнууд заавал дагаж мөрдөх дүрэм журмаа олон улсын стандарт дээр суурилан боловсруулах боломжгүй бол тэд дүрэм журмын төслөө нийтэлж бусад орны үйлдвэрлэгчдэд санал бодлыг нь хэлүүлэх боломжийг өгөх үүрэгтэй. Хэлэлцээрийн дагуу гишүүн улс орнууд стандартаа эцэслэн батлахдаа ийм саналуудыг харгалзан үзэх үүрэгтэй.

Улс орнууд хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүнийг өөрийн үндэсний эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн дүрэм журамтай нийцсэн байхыг шаарддаг. Эдгээр дүрэм журмын гол зорилго нь хүн, амьтан, ургамлын амь нас, эрүүл мэндийг импортын хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүнээр зөөгдөн орж ирж болох хортон шавьж, өвчнөөс хамгаалахад оршино. Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ авах тухай хэлэлцээрт (ЭАУЭА) заасан дүрмүүд нь заавал дагаж мөрдөх бүтээгдэхүүний стандарттай холбоотой дүрмүүдтэй төстэй юм.

Гэхдээ зарим чухал ялгаа бий. Үүнд:

ХТСТ-ын дагуу бүтээгдэхүүний стандартыг импортын бараанд хэрэглэхдээ ялгаварлахгүй байхыг шаарддаг. Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн дүрэм журам нь “тодорхой өвчин буюу хортон шавьж байх түвшин”-тэй холбоотой бөгөөд ийм

²⁶ Мөн эх сурвалж. х. 66 f.

²⁷ Мөн эх сурвалж. х. 82 f.

өвчин, хортон шавьж байдаг улс орноос оруулах импортод үүнийг илүү хатуу чанад мөрдөж болно. ЭАУЭА-н дагуу өвчин тархах эрсдэл байгаа боловч "шинжлэх ухааны нотолгоо хангалтгүй" байгаа үед улс орнууд урьдчилан сэргийлэх зорилгоор түр хугацаагаар импортыг хязгаарлах арга хэмжээ авахыг зөвшөөрсөн (ЭАУЭА-н хэлэлцээрийн 5:7).

Олон улсын худалдаанд орж байгаа ихэнх бүтээгдэхүүний хувьд худалдан авагчид нь ерөнхийдөө бүтээгдэхүүн нь стандартад нийцэж байгаа гэсэн үйлдвэрлэгчдийн мэдүүлэгт найддаг. Тодорхой шалтгаанаар ийм баталгаа хангалтгүй бол техникийн дүрэм журам, стандартын холбогдох шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлох ажиллагаа шаардлагатай (ХТСТ-ын тухай хэлэлцээр, Хавсралт 1:3). Ийм тохирлын үнэлгээний ажиллагааг хөндлөнгийн лабораторийн сорилт шинжилгээг хийлгэж, шалгалтын дараа гэрчилгээг олгох зэргээр хэрэгжүүлж болно.

ЭТП-д худалдаан дахь техникийн саад тотгорын асуудлаар нэлээд их заалт орсон. Хятад техникийн дүрэм журам, стандарт, тохирлын үнэлгээний журмын үндэслэл болох бүх шалгуурыг нийтлэх шаардлагатай бөгөөд тэдгээрийг ХТСТ-ын хэлэлцээртэй нийцүүлэх ёстой. Хятад тохирлын үнэлгээ нь техникийн дүрэм журам, стандарттай нийцэж байгаа эсэхийг тодорхойлох цорын ганц зорилгод үйлчлэх явдлыг хангах ёстой. Гэрээний арилжааны нөхцөлтэй нийцэж байгаа эсэхийг тодорхойлох ийм ажиллагаа нь талууд зөвшөөрсөн үед л хэрэгжинэ (ЭТП-ын 13: 1-3). ЭТП-ын 13:4 заалт их ач холбогдолтой. Энэ заалтын дагуу Хятад хэрэглэж ирсэн тусгай дүрэм, стандарт, журам, зөвхөн импортын бараанд ногдуулдаг, холбогдох (тусгай) агентлагуудад төлдөг хураамж зэргийг арилгах ёстой. Импортын болон дотоодын бүтээгдэхүүнд бүх байгууллага, агентлаг нэгэн ижил тэмдэг олгож, ижилхэн хураамж ногдуулна.

Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний хувьд Хятад бүх хууль, дүрэм, бусад арга хэмжээгээ мэдэгдэх ёстой (ЭТП-ын 14).

III 2.2.3 Импортын тусгай зөвшөөрөл олголт

Үндэсний импортын тусгай зөвшөөрөл олгох журам нь импортын урсгалд сөргөөр нөлөөлж болно. Ялангуяа эдгээр журам нь ил тод биш, эсвэл тусгай зөвшөөрөл олгохыг дэмий саатуулж байвал ийм нөлөөлөл үзүүлэх талтай. Импортын тусгай зөвшөөрөл олгох журмын тухай хэлэлцээр-ийн дагуу тусгай зөвшөөрлийг дараах хоёр ангилалд хуваасан: Шууд олгох тусгай зөвшөөрлийг өргөдөл хүлээн авснаас хойш дээд тал нь ажлын арван өдрийн дотор олгох ёстой. Шууд олгодоггүй тусгай зөвшөөрлийг тоон хязгаарлалтыг зохицуулахад ашигладаг бөгөөд түрүүлж ирсэнд нь түрүүлж үйлчлэх зарчмаар олгож байгаа бол өргөдөл хүлээн авсан өдрөөс хойш дээд тал нь 30 хоногийн дотор олгох ёстой, харин бүх өргөдлийг зэрэг хянадаг бол 60 хоногийн дотор олгох ёстой.

Тус хэлэлцээр нь мөн импортын тусгай зөвшөөрөл олгох журмыг зүй бус хэрэгжүүлснээс болж олон улсын худалдааны урсгалд саад учруулахгүй байх, эдгээр журмыг шударга хэрэгжүүлэх зарим зарчим, дүрмийг заасан.

Ийм практикийг нэвтрүүлэхийн тулд тус хэлэлцээрт гишүүн улс орнууд импортын тусгай зөвшөөрөл олгох журмын тухай бүх мэдээллийг нийтлэх үүрэгтэй гэж заасан. Ингэснээр импортлогч, экспортлогч болон тэдний засгийн газрууд дараах зүйлсийн талаар бүрэн мэдээлэлтэй болно. Үүнд:

- Өргөдөл гаргах иргэд, аж ахуйн нэгжүүд, байгууллагуудын шалгуур,
- Тусгай зөвшөөрөл олгох захиргааны байгууллага,
- Тусгай зөвшөөрөлд хамрагдах бүтээгдэхүүнүүд.

Албан ёсны шаардлагыг аль болох бага байлгаж, баримт бичгийн бага зэргийн алдаанд зөөлөн хандах хэрэгтэй.²⁸

Эдгээр зарчмыг ЭТП-ын 8-р заалтад дахин заасан. Ингэхдээ энэ салбарт Хятадын захиргааны практикт түгээмэл байдаг ил тод биш байдлын түвшинг харгалзсан.²⁹ Хятад ДХБ-д элсэн орсны дараа хүчин төгөлдөр хэвээр үлдэх тусгай зөвшөөрөл болон квотын бүх шаардлага, холбогдох журмын талаар ДХБ-д мэдэгдэж, шууд олгох тусгай зөвшөөрлийн журмын талаар жил бүр тайлагнах ёстой. Импортын тусгай зөвшөөрөл нь дор хаяж зургаан сарын хугацаанд хүчинтэй байх ёстой.

III 2.3 Бусад зарим дүрэм

III 2.3.1 Татаасын тухай дүрэм

Засгийн газрууд шинэ салбарын хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалт, ялангуяа хоцрогдсон бүс нутаг дахь хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, салбаруудын экспортын хөгжлийг дэмжих, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэд бүтцийг сайжруулах, фермерүүдийн орлогыг зохих түвшинд байлгах зэрэг бодлогын олон зорилтыг хэрэгжүүлэхийн тулд татаасыг хэрэглэдэг.³⁰

ТХЕХ-ийн дүрмийн дагуу татаасыг хориглодоггүй. ТХЕХ-ийн гол заалтууд нь нарийн төвөгтэй бөгөөд эдгээрийг аж үйлдвэрийн бүтээгдэхүүнтэй холбоотой Татаас, саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр (ТСАХТХ), хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнтэй холбоотой Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр-т дэлгэрэнгүй тайлбарласан.

ТСАХТХ-т зааснаар мөнгөний шууд шилжүүлэг (буцалтгүй тусламж, зээл, өмч гэх мэт) хийх, зээл төлөх баталгаа гаргах, засгийн газар хурааж авах байсан орлогоо авахгүй байх зэргээр ашиг өгч байвал үйлдвэр татаас авч байна гэж үзнэ. Татаас үзүүлж болох гурав дахь хэлбэр нь Засгийн газрын хангах бараа, үйлчилгээ юм. Аль ч тохиолдолд тухайн арга хэмжээ нь татаас мөн эсэхийг тодорхойлоход ашиг өгч байгаа эсэх тухай ойлголтыг өгөхөд чухал (ТСАХТХ-ийн 1-р зүйл). Татаас гэдэг нь ашгийг бүрэн арилжааны үүднээс авч үзээгүй ойлголт юм. Тухайлбал, зээлийн нөхцөл нь арилжааны банкнуудаас илүү таатай, үйлчилгээг зах зээлийн зонхилох үнээс бага үнээр үзүүлдэг.

ТХЕХ нь Засгийн газруудын татаас олгох эрхийг зарчмын хувьд татгалздаггүй боловч бусад орнуудын худалдаанд сөргөөр нөлөөлөх татаас-ыг хэрэглэхийг хориглох буюу сайшаадаггүй. Энэ үүднээс татаасыг хориглосон ба зөвшөөрсөн татаас хэмээн ангилсан.

Хориглосон татаас нь экспортын татаас юм. Тухайлбал, экспортын гүйцэтгэлээс хамаарах татаас, экспортын урамшуулалтай холбоотой валют суутгах хөтөлбөр, экспортын бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэх зүйлд татаас өгөх, шууд татвараас чөлөөлөх (экспорттой холбоотой ашгийн татвар гэх мэт), дотоодын хэрэглээнд зориулан борлуулсан үед эдгээр бүтээгдэхүүнд ногдох байснаас илүү гарсан экспортын бүтээгдэхүүний шууд бус татвараас (НӨАТ гэх мэт) чөлөөлөх, экспортын бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хэрэглэх зүйлсэд ногдуулснаас илүү гарсан импортын төлбөр хураамжийг чөлөөлөх буюу буцаах (тариф болон бусад төлбөр хураамж), хөтөлбөрийн урт хугацааны зардлыг зарцуулахад хүрэхгүй даатгалын хураамжтай экспортын баталгааны хөтөлбөр, экспортын зээлийн нөхцөлд материаллаг давуу талыг хамгаалах зорилготой Засгийн газрын

²⁸ *Ibid.* х. 121/122

²⁹ *Дэлгэрэнгүйг х. 12, 21-ээс үзнэ үү*

³⁰ *Бизнесийн лавлах х. 127 f.*

зээлийн зардлаас доогуур хүүтэй экспортын зээлийг хориглосон. Үүний адил импортын бус дотоодын бараа, бүтээгдэхүүн хэрэглүүлэх зорилготой татаасыг хориглосон (ТСАХТХ-ийн 3-р зүйл).

Эдгээр дүрэм нь мөн хөгжиж буй орнуудад хамаарна.

ТСАХТХ-ийн дагуу Засгийн газрууд дээр дурдсанаас бусад татаас өгөхийг зарчмын хувьд зөвшөөрсөн. Эдгээр нь хоёр ангилалд хуваагдана. Тухайлбал шүүхэд заргалдах, заргалдахгүй татаас гэж ангилна.

Зөвшөөрөгдөх боловч шүүхэд заргалдах татаас нь “тодорхой” байх ёстой, өөрөөр хэлбэл нэг бүлгийн аж ахуйн нэгжүүд, үйлдвэрийн салбар, салбаруудын бүлэг, газарзүйн бүсээр хязгаарлагдах ёстой (ТСАХТХ-ийн 2-р зүйл).

“Бусад гишүүн улс орны эрх ашигт сөрөг нөлөө” (ТСАХТХ-ийн 5-р зүйл) үзүүлж байвал тодорхой татаасын эсрэг шүүхээр заргалдаж болно. Ийм сөрөг нөлөө нь өөр нэг гишүүн улсын эрх ашигт ноцтой хохирол учруулах, импортлогч улсын дотоодын үйлдвэрлэлд хохирол учруулах, заавал баримтлах тарифын ашгийг үгүй болгох буюу багасгах зэрэг хэлбэрээр илэрч болно (ТСАХТХ-ийн 5-р зүйл).

ТСАХТХ-ийн 6-р зүйлд ноцтой хохирол “байна гэж үзэх” эсвэл “гарч болзошгүй” нөхцөлийг тодорхойлох маш өргөн хуулийн шалгуурыг заасан. Аль тал нь нотлох үүрэг хүлээхийг үүнд бас заасан. Эдгээр шалгуур нь нийтлэг нэг зүйлтэй: тухайлбал тогтооход маш хэцүү баримтууд юм.

Дотоодын үйлдвэрлэлд учруулах “материаллаг хохирол” нь шүүхийн зарга үүсгэх өөр нэг үндэслэл юм. ТХЕХ 1994-ийн VI зүйлд заасан “материаллаг хохирол” хэмээх нэр томъёог мөн чухал ач холбогдолтой хамгаалах арга хэмжээтэй холбоотойгоор илүү дэлгэрэнгүй тайлбарлана.³¹

Бусад гишүүн улс орон хориотой буюу шүүхээр заргалдах татаасыг хэрэглэснээр өөрийнх нь эрх ашигт сөргөөр нөлөөлж байна гэж үзсэн тохиолдолд импортлогч орон хэрэглэж болох хоёр төрлийн хамгаалалтын хэрэгсэл бий: Шалгалт хийгдсэний дараа татаас бүхий импорт нь үйлдвэрлэлд материаллаг хохирол учруулж байгааг тогтоовол саармагжуулах татвар ногдуулж болно. Түүнчлэн Маргаан шийдвэрлэх байгууллагаар учирсан гэм хорыг арилгуулахаар хандаж болно.

БНХАУ-ын төрийн удирдлагатай эдийн засаг нь татаасын бүрэн тогтолцооноос бүрддэгийг харгалзан үзвэл, ЭТП энэ асуудлыг бүрэн тусгах ёстой байлаа. 10-р заалтын дагуу Хятад ТСАХТХ-ийн 3-р зүйлд хамрагдах бүх татаасын хөтөлбөрөө устгах ёстой (экспортын ба импортыг орлох бүтээгдэхүүний татаас). Цаашилбал Хятад ТСАХТХ-ийн 1-р зүйлд заасан тодорхой бүтээгдэхүүнээр олгосон, дэмжсэн, зохион байгуулсан аливаа татаас, үүний дотор экспортын татаасын талаар ДХБ-д мэдэгдэх ёстой. Мэдээлэл нь аль болох тодорхой байх ёстой. ЭТП-ын 10:2-т улсын өмчийн үйлдвэрийн газруудад өгдөг татаасын талаар заасан. Тиймээс Хятад ердийн шаарддагаас илүү их амлалт үүрэг авсан юм. Тухайлбал хөдөө, аж ахуйн экспортод татаас өгөхгүй байх, үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний хувьд хөгжиж буй орнуудад ерөнхийдөө зөвшөөрдөг зарим төрлийн экспортын татаасыг хязгаарлахаар заасан.³²

³¹ х. 18

³² Мартин-Бхаттасали-Ли, мөн эх сурвалж. х. 5

III 2.3.2 Дампингийн эсрэг дүрэм

Дампинг нь татаасын адил худалдааны шударга бус практик гэж тооцогддог хэдий ч ТХЕХ үүнийг мөн л хориглоогүй. Цаашилбал бага үнэтэй импорт бүр нь дотоодын ижил төстэй бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд төвөг учруулдаггүй бөгөөд ТХЕХ-ийн VI зүйл болон Дампингийн эсрэг үйл ажиллагааны тухай хэлэлцээрийн (ДЭУАТХ) хатуу шалгуурт “дампинг” нийцэж байвал ерөнхийдөө тоодоггүй.

Энэхүү хэлэлцээрийн 2-р зүйлд заасны дагуу бүтээгдэхүүний экспортын үнэ экспортлогч улсын хэрэглээнд борлуулдаг үнээс бага байвал дампинг хийж байна гэж үзнэ. Гэхдээ экспортлогч улсын дотоодын зах зээл дээрх борлуулалт нь хэвийн биш (тухайлбал борлуулалт нь үйлдвэрлэлийн зардлаас бага байвал) бөгөөд дотоодын зах зээл дээр борлуулах хэмжээ нь бага байвал, дампинг тодорхойлох дээрх арга тохиромжгүй болно. Ийм тохиолдолд тус хэлэлцээрт зааснаар ижил төстэй бүтээгдэхүүнийг гуравдагч оронд экспортлоход нэхэмжилдэг харьцуулж болох үнэ эсвэл импортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зардал дээр борлуулалт ба захиргааны ерөнхий зардал, ашгаа нэмж тооцсон үнийг ашиглах боломжтой. Тухайн бүтээгдэхүүнийг экспортлогч улсын дотоодын зах зээл дээр борлуулсан үнийн дүн нь импортлогч оронд борлуулсан үнийн дүнгийн 5-аас бага хувийг эзэлж байгаа тохиолдолд л сүүлийн аргыг хэрэглэж болно.³³

Хятадын эдийн засгийн ихэнх хэсэг нь одоо ч гэсэн их зохицуулалттай эсвэл засгийн газрын оролцоо ихтэй байдаг тул эдгээр аргыг Хятадад хэрэглэхэд хэцүү байж болно. Тиймээс ЭТП-д үнийг харьцуулах боломжийг тодорхойлох зарим тусгай дүрмийг оруулсан. ЭТП-ын 15-р заалтын дагуу 15 хүртэлх жилийн хугацаанд шалгагдаж байгаа үйлдвэрлэгчид нь ижил төстэй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч салбарт тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын хувьд зах зээлийн эдийн засгийн нөхцөл давамгайлж байгаа гэдгийг тодорхой харуулж чадахгүй бол импортлогч ДХБ-ын гишүүн орнууд нь Хятад дахь дотоодын үнэ, зардал дээр суурилагагүй аргачлалыг хэрэглэж болно.

ЭТП-ын 15-р заалтын дагуу Хятадын худалдааны олон түншүүд дээр тодорхойлсон үнэ харьцуулах ТХЕХ-ийн дүрмээс гажсан аргуудыг хэрэглэж байна. Жишээлбэл, Европын Комисс нь Хятадын экспортлогчдыг зардлын бүтцээ мэдэгдэх талаар шалгагч нартай бүрэн хамтран ажилласан тохиолдолд л ердийн аргыг хэрэглэдэг. Гэхдээ ингэж хамтран ажиллах нь ховор билээ. Ийм тохиолдолд шалгагдаж байгаа Хятадын бүтээгдэхүүний үнийг ижил төстэй хөгжиж буй орнуудаас импортолсон ижил төстэй бүтээгдэхүүний үнэтэй харьцуулах замаар дампинг тогтоож болно. ЕХ нь Хятадын “зах зээлийн эдийн засгийн статус”-ыг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ саяхан мэдэгдсэн. Хэрэв энэхүү статусыг хүлээн зөвшөөрвөл дампингийн эсрэг бүх хэргийг ТХЕХ-ийн ердийн аргачлалаар хянан шийдвэрлэх болно.

ЭТП-ын 106 заалтад татаастай холбоотой төсөөтэй дүрэм бий. ДХБ-ын гишүүн улс орнууд ТСАХТХ-ын 14-р зүйлд заасан зохих журмыг хэрэглэхэд “онцгой” хүндрэлтэй байвал *“Хятадад зонхилогч нөхцөл болзол нь тохиромжтой жишиг биш байж болно гэдгийг харгалзан үзсэний дагуу татаасын ашгийг тодорхойлж, хэмжих аргачлалыг хэрэглэж болно.”*

³³ *Бизнесийн лавлах х. 143 f.*

III 2.3.3 Татаастай буюу дампингтай бараанаас учирсан хохирол, учир шалтгааны холбоосыг тодорхойлох дүрэм

ДЭУАТХ-ийн 3-р зүйл, ТСАХТХ-ийн 15-р зүйлийн дагуу дараах тохиолдолд л дампингийн эсрэг болон саармагжуулах татварыг импортод ногдуулах ёстой. Үүнд:

- туйлын утгаар болон үйлдвэрлэл, хэрэглээтэй харьцуулсан утгаараа дампингтай болон татаастай импорт их өссөн;
- ийм импортын бүтээгдэхүүний үнэ дотоодын ижил төстэй бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулж, ижил төстэй бараа бүтээгдэхүүний үнд шахалт үзүүлсэн буюу тухайн үнийг өсгөхгүй байсан,
- үүний уршгаар импортлогч улсын дотоодын үйлдвэрлэлд хохирол учирсан. Тухайн импорт болон дотоодын үйлдвэрлэлд учирсан хохирлын хоорондох энэхүү учир шалтгааны холбоосыг тогтоохын тулд *“үйлдвэрийн байдалд нөлөөлөх эдийн засгийн зохих хүчин зүйлсийг”* харгалзан үзэх ёстой.

ДЭУАТХ-ийн 3-р зүйл, ТСАХТХ-ийн 15-р зүйлд ийм эдийн засгийн хүчин зүйлс болон татаастай ба дампингтай импортын бүтээгдэхүүнээс бусад тухайн салбарын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж байгаа хүчин зүйлсийн жагсаалт орсон.

III 2.3.4 Хамгаалалтын тухай дүрэм

ТХЕХ-ийн дүрэмд тарифыг үе шаттай бууруулах арга хэмжээ авсан ч гэсэн аж үйлдвэрийн буюу хөдөө аж ахуйн зарим салбар богино хугацаанд өсөн нэмэгдэх өрсөлдөөнд дасан зохицоход бэрхшээл учирч болно. Эдгээр бэрхшээл нь үйлдвэрлэлийн бүтцийг оновчтой болгож чадаагүй буюу бүтээмжийг дээшлүүлэхэд шаардлагатай технологийн шинэчлэлийг хийж чадаагүйгээс үүдэн гарч болно.

Салбаруудад өрсөлдөөнд дасан зохицох цаг өгөхийн тулд, ТХЕХ 1994-ийн XIX зүйл ба Хамгаалах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 2-р зүйлд зааснаар тарифыг бууруулсны үр дүнд улс оронд оруулж байгаа бүтээгдэхүүний импорт *“улам ихсэж, энэ нөхцөл нь дотоодын үйлдвэрлэгчдэд ноцтой хохирол учруулахаар байвал”* тус улс орон ийм бүтээгдэхүүний импортыг түр хугацаагаар хязгаарлах хамгаалах арга хэмжээг авч болно.³⁴

Гэвч хамгаалах арга хэмжээний үндэслэл болгон тогтоох ёстой *“хохирлын”* стандарт нь саармагжуулах буюу дампингийн эсрэг татвар ногдуулахад шаардагдах стандартаас хамаагүй өндөр байдаг. Шударга бус худалдааны практик нь хамгаалах арга хэмжээний үндэслэл болдоггүй тул, үйлдвэрлэлд учирсан хохирол нь *“ноцтой”* байх ёстой, өөрөөр хэлбэл *“дотоодын үйлдвэрлэлийн байдалд мэдээдхүйц хохирол”* учруулсан байх ёстой. Учир шалтгааны үялдааг харуулахад тухайн бүтээгдэхүүний импорт нь *“ижил төстэй бүтээгдэхүүн буюу шууд өрсөлдөх бүтээгдэхүүний үйлдвэрлэгчдэд”* буюу *“ижил төстэй бүтээгдэхүүн буюу шууд өрсөлдөх бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийн хэмжээ эдгээр бүтээгдэхүүний дотоодын нийт үйлдвэрлэлийн томоохон хувийг бүрдүүлдэг үйлдвэрлэгчдэд”* хохирол учруулж байгааг нотолно.

Хамгаалах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 5-р зүйлд заасны дагуу хамгаалах арга хэмжээгээр тарифыг заавал баримтлах түвшнээс дээш өсгөх буюу импортын хязгаарлалтыг тогтоодог тул зөвхөн *“шаардлагатай хэмжээнд”*, *“бүх эх сурвалжийн импортыг үл ялгаварлах”* арга хэмжээг авч болно. Гэхдээ 5:26

³⁴ Мөн эх сурвалж. х. 143 f.

заалтын дагуу онцгой нөхцөл байдалд, тухайлбал нэг буюу түүнээс олон орноос оруулж байгаа импорт нь *“тухайн хугацаанд тухайн бүтээгдэхүүний импортын нийт өсөлттэй харьцуулахад хамаагүй их хувиар өссөн”* тохиолдолд гишүүн улс орнууд үл ялгаварлах дүрмээс хазайж, тэдгээр орны импортод квотын хязгаарлалтыг тогтоож болно.

Хятад ДХБ-ын бусад гишүүн улс оронтой харьцуулшгүй бага өртөгтэй үйлдвэрийн бүтээгдэхүүнээр хангах асар их бололцоотой тул элсэн орохдоо илэрхий ялгаварлах шинжтэй шилжилтийн үеийн тодорхой бүтээгдэхүүнд хамаарах хамгаалах механизмыг эсэргүүцэхээ болих ёстой.

ЭТП-ын 16-р заалтад заасны дагуу Хятадаас гарал үүсэлтэй бүтээгдэхүүн нь дотоодын ижил төстэй буюу шууд өрсөлдөх бүтээгдэхүүний зах зээлийн хэвийн үйл ажиллагааг алдуулахаар буюу ийм аюул учруулахаар их хэмжээгээр буюу ийм нөхцөлөөр ДХБ-ын гишүүн улс орны нутаг дэвсгэрт импортолж байгаа бол, ДХБ-ын гишүүн тухайн улс орон нь харилцан сэтгэл ханамжтай байх шийдэлд хүрэхийн тулд Хятадтай зөвлөлдөхийг хүсэж болно... (16:1 заалт) *“Хэрэв ийнхүү зөвлөлдөөд харилцан тохиролцож чадахгүй бол... ДХБ-ын гишүүн тухайн улс орон нь хөнгөлөлтөө цуцлах буюу ... зах зээлд учирсан энэхүү бэрхшээлээс урьдчилан сэргийлэх буюу засаж залруулахад шаардлагатай хэмжээгээр импортыг хязгаарлах эрхтэй байна...”* (16:1 заалт)

“Дотоодод үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнтэй ижил төстэй буюу шууд өрсөлддөг бүтээгдэхүүний импорт туйлын буюу харьцангуй утгаараа мэдэгдхүйц материаллаг хохирол учруулж байвал эсвэл материаллаг хохирол учруулах аюултай байвал зах зээлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж байна гэж үзнэ... Зах зээлийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж байгаа эсэхийг тодорхойлоход ДХБ-ын гишүүн тухайн улс орон нь бодит хүчин зүйлсийг, үүний дотор ижил төстэй буюу шууд өрсөлдөх бүтээгдэхүүний үнэд импортын үзүүлэх нөлөө, ижил төстэй буюу шууд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрүүдэд импортын үзүүлэх нөлөө зэргийг тооцох ёстой.” (16:4 заалт)

16-р заалт: 5–7-д яаралтай тохиолдолд авах ил тод, шуурхай ажиллагаа, түр арга хэмжээний талаар заасан. Нөгөө талаар хязгаарлалт нь хоёроос дээш жил үргэлжилбэл Хятад хариу арга хэмжээ авах эрхтэй.

III 2.4 Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээний дүрэм Засгийн газрууд үндэсний тодорхой тэргүүлэх чиглэлийн дагуу хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжихийн тулд гадаадын хөрөнгө оруулагчдад тусгай нөхцөлийг өгдөг. Ийм нөхцөлүүд худалдаанд нөлөөлж, Үндэсний нөхцөлийн зарчим³⁵ нь тооны хязгаарлалтыг арилгах зэрэг ТХЕХ-ийн үндсэн дүрмүүдээр хязгаарлагдаж болно.³⁶

Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийн (ХХОАХ) дагуу улс орнууд ТХЕХ-ийн дүрмүүдтэй нийцэхгүй гэж тодорхойлсон нөхцөлүүдийг аажмаар арилгах шаардлагатай.³⁷

Гэрээний 2-р зүйлийн дагуу импорттой харьцуулахад дотоодын бүтээгдэхүүнд илүү таатай нөхцөл өгч байна гэдэг үндэслэлээр хориглосон ХХОАХ-нүүд:

³⁵ Дээрхийг үз х. 10 f.

³⁶ Дээрхийг үз х. 10 f.

³⁷ „Бизнесийн лавлах“ х. 160 f.

- Дотоодын гарал үүсэлтэй буюу дотоодын эх сурвалжаас гаралтай бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгж худалдан авах, ашиглах үүрэг (дотоодод үйлдвэрлэсэн орцын шаардлага),
- Аж ахуйн нэгжийн импортын бүтээгдэхүүн худалдан авч, ашиглах хэмжээ нь түүний экспортолж байгаа дотоодын бүтээгдэхүүний хэмжээ буюу үнэтэй харьцуулсан хэмжээгээр хязгаарлагдах ёстой (худалдаа тэнцвэржүүлэх шаардлага).

Импорт, экспортод тооны хязгаарлалт хэрэглэхийн эсрэг ТХЕХ 1994-ийн XI зүйлийн заалтуудтай нийцэхгүй гэж үзсэн ХХОАХ-нүүд:

- Тухайн аж ахуйн нэгжид тохирох хэмжээгээр гадаад валют эзэмших эрхийг хязгаарласан хязгаарлалт (гадаад валютын шаардлага),
- Дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ, үнийн хувьд экспортыг нарийвчлан заасан заалтууд (тухайлбал экспортод ногдуулсан хязгаарлалт зэрэг дотоодын борлуулалтын шаардлагууд).

ХХОАХ-ний тухай хэлэлцээр нь улс орнуудыг экспортын гүйцэтгэлийн шаардлага зэрэг бусад олон ХХОАХ-үүдийн ядаж заримыг нь хөрөнгө оруулалтын нөхцөл болгон ашиглахыг хориглоогүй. Өмчийн тодорхой хувийг дотоодын хөрөнгө оруулагч эзэмших нь зүйтэй, гадаадын хөрөнгө оруулагч хамгийн сүүлийн үеийн технологи оруулж ирэх ёстой, судалгаа, боловсруулалтын тодорхой түвшин буюу төрлийг дотоодод хийх ёстой зэрэг шаардлага тавихыг мөн хориглоогүй.

Эдгээр ХХОАХ-нүүд болон ХХОАХ-ний тухай хэлэлцээрээр илэрхий хориглоогүй бусад зарим ХХОАХ-үүдийг Хятадын бизнесийн практикт их хэрэглэдэг байсан бөгөөд зарим нь одоо ч хэрэглэгдсээр байна. Тийм учраас ДХБ-ын гишүүн улс орнууд Хятад улс ДХБ-д элсэн орохдоо хөгжиж буй орнуудад ХХОАХ-ний тухай хэлэлцээрийг дагаж мөрдөхөд зарим боломж өгдөг 5-р зүйлийг үл харгалзан ХХОАХ-ний тухай хэлэлцээрийг дагаж мөрдөх ёстой гэж үзсэн.

ЭТП-ын 7:3 заалтад, ялангуяа гадаад валютыг тэнцвэржүүлэх шаардлага, дотоодод үйлдвэрлэсэн орцын шаардлага, экспортын гүйцэтгэлийн шаардлагын талаар заасан. Хятадын бизнесийн түншүүд гадаадын хөрөнгө оруулагчдад ийм нөхцөл тавьдаг учраас Хятад ийм зүйл заалтыг хэрэгжүүлэхгүй байхаар хууль тогтоомжид заах ёстой. Цаашилбал, импортын тусгай зөвшөөрөл, квот, тарифын түвшний квот, импортын зөвшөөрлийн бусад хэлбэр, импортлох эрх, хөрөнгө оруулалтын эрх зэргийг үндэсний болон орон нутгийн эрх барих байгууллагууд олгохдоо дараах зүйлийг шалгуур болгодоггүй. Тухайн бүтээгдэхүүний нийлүүлэгч нь дотоодын өрсөлдөгч байгаа эсэх, дотоодод үйлдвэрлэсэн орцын шаардлага, тэнцвэржүүлэх шаардлага, технологи шилжүүлэх, экспортын гүйцэтгэл, судалгаа, боловсруулалтыг Хятадад хийх зэрэг гүйцэтгэлийн шаардлагууд болно.

III 2.5 Үйлчилгээний худалдааны тухай дүрэм

Үйлчилгээний худалдаа өсөж байгаа бөгөөд одоогоор олон улсын нийт худалдаа эргэлтийн 20 гаруй хувийг эзэлж байна. Уругвайн үе шатаар хэлэлцэж тохиролцсон Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээр (ҮХЕХ) нь энэхүү чиглэлийн худалдааг олон улсын дүрэм журамд оруулах бүтцийг бий болгосон. Үүний заалтууд нь олон улсын үйлчилгээний худалдаа явагддаг бүх хэлбэрт хамаарна.³⁸

ҮХЕХ-ийн I зүйл үйлчилгээ үзүүлдэг дөрвөн хэлбэрийг ялгаж тодорхойлсон. Үүнд:

³⁸ Мөн эх сурвалж. х. 11 f., 191 f.

- Үйлчилгээний бүтээгдэхүүний улс хоорондын хөдөлгөөн;
- Үйлчилгээ үзүүлж байгаа улс орондоо арилжааны төлөөллийг бий болгох;
- Өөр нэг улс оронд үйлчилгээ үзүүлэхийн тулд бие хүнийг түр шилжүүлэх;
- Импортлогч улс орон руу чиглэсэн хэрэглэгчдийн хөдөлгөөн.

ДХБ нь нэг талаар барааны худалдаанд зориулж, нөгөө талаар үйлчилгээний худалдаанд зориулж баталсан үндсэн хандлагад нэг үндсэн ялгаа бий. ТХЕХ-ийн гол үзэл санаа нь зөвхөн тодорхой заасан нөхцөлд л цөөн тооны хэлбэрээр (голдуу тарифаар дамжуулан) нэвтрэх боломжийг хязгаарлах нээлттэй зах зээл байсан бол ҮХЕХ-ийн гол үзэл санаа нь хаалттай зах зээлийн бодит байдал юм. Хөгжиж буй орнуудын үйлчилгээний салбарууд бүрэн хөгжөөгүй, яг одоогоор нэлээд их хамгаалалт шаардлагатай байгаа тул хөгжиж буй орнуудын хэрэгцээнд нийцүүлэхийн тулд энэхүү хандлагыг баримталсан. Тиймээс үйлчилгээний ямар салбарыг, ямар хэмжээнд, ямар нөхцөлийн дор нээж, олон улсын өрсөлдөөнд оруулахыг ДХБ-ын гишүүн улс орнууд өөрсдөө шийдэх эрхтэй. Гэхдээ тухайн салбарыг нээнгүүт, ДХБ-ын зарчим, ялангуяа үл ялгаварлах дүрэмд хамаарах болно.

Улс орнууд зах зээлд нэвтрэх боломжийг сайжруулах, гадаадын нийлүүлэгчдийг дотоодын нийлүүлэгчдээс ялгаварлан гадуурхсан харьцааг устгах буюу багасгах замаар үндэсний нөхцөлийг өргөжүүлэхээр тохиролцохдоо баримталсан нөхцөлүүдийг салбар салбараар, үйлчилгээний худалдаа хийдэг дөрвөн хэлбэр тус бүрээр заадаг. Улс орон бүрийн төлөвлөгөөнд либералчилалын тодорхой амлалт үүргүүдийг заасан байдаг.

Аливаа нэг салбарыг ийнхүү нээхэд ҮХЕХ-ийн дагуу улс орнууд өөр өөр улс орны үйлчилгээний бүтээгдэхүүн болон үйлчилгээ үзүүлэгчдийг ялгаварлан гадуурхахгүйгээр НТҮ-ний нөхцөл хэрэглэх шаардлагатай. Үндэсний нөхцөлийн зарчим нь гадаадын үйлчилгээний бүтээгдэхүүн болон үйлчилгээ үзүүлэгчдэд өөрсдийн үйлчилгээний бүтээгдэхүүн болон үйлчилгээ үзүүлэгчдээс илүү таагүй хандаж болохгүй гэсэн үзэл санаан дээр суурилсан.

Гадаадын үйлчилгээ үзүүлэгчдэд үйлчилгээний худалдаатай холбогдох дүрэм журмыг бүрэн таниулж мэдүүлэхийн тулд улс орнууд холбогдох бүх хууль тогтоомжийг нийтлэх шаардлагатай.³⁹

БНХАУ-ыг ДХБ-д элсүүлэх хэлэлцээ хийсэн нэг гол чиглэл нь үйлчилгээний худалдаа байсан бөгөөд Хятадын амлалт үүрэг нь урьд өмнө хэрэгжүүлж байгаагүй үйлчилгээний худалдааны хамгийн өргөн либералчилал байлаа.⁴⁰ Хэдийгээр зарим амлалт үүрэг нь өмчлөл, бизнесийн цар хүрээ, бүс нутагтай холбоотой байсан боловч амлалт үүргийн хүрээ дэндүү өргөн байлаа. Гэхдээ БНХАУ-ын амлалт үүргийг нарийн хянамгай боловсруулсан: Хил дамнасан худалдаа болон гадаадад хэрэглэх үйлчилгээний хувьд баталгаатай хязгаарлалтгүй нэвтрэх боломжтой салбарын тоо бусад ихэнх улс орныхоос цөөн байсан бөгөөд байгууллагын худалдааны хувьд энэ нь бараг тэгтэй тэнцүү байв.⁴¹

БНХАУ-ын Тусгай амлалт үүргийн төлөвлөгөө нь Төлөвлөгөөнд орсон бүх салбарт хамаатай хэвтээ амлалт үүргийн зэрэгцээ дараах салбаруудыг хамарсан. Үүнд:

- Мэргэжлийн үйлчилгээ (хууль, нягтлан бодох, аудит, татвар, архитектур, инженер, анагаах ухаан, мэдээллийн технологи, үл хөдлөх хөрөнгө, зар сурталчилгаа, баглаа боодол, менежментийн зөвлөх, техникийн туршилт

³⁹ Мөн эх сурвалж. х. 12 f.

⁴⁰ Мартин Б. Бхаттасали-Ли, мөн эх сурвалж. х. 11

⁴¹ Мөн эх сурвалж.

- шинжилгээ, хөдөө аж ахуй, газрын тосны салбартай холбоотой, хурал зөвлөгөөн, орчуулга, засвар үйлчилгээ);
- Харилцаа холбооны үйлчилгээ (буухиа шуудан, цахилгаан холбоо, дуу дүрстэй холбоо)
- Барилга, инженерийн үйлчилгээ;
- Түгээх үйлчилгээ (зуучлал, бөөний болон жижиглэнгийн худалдаа, франчайз);
- Боловсролын үйлчилгээ;
- Байгаль орчны үйлчилгээ;
- Санхүүгийн үйлчилгээ (даатгал, банк, автомашины санхүүжилт, үнэт цаас);
- Аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээ;
- Тээврийн үйлчилгээ (далай, төмөр зам, автозамын тээвэр, агуулах, тээвэр зууч зэрэг дагалдах үйлчилгээ).

Эдгээр салбар нь зарим нөхцөлтэйгөөр гадаадын пүүс компанийн бизнес үйл ажиллагаанд нээлттэй байна. Гэхдээ олон янзын хязгаарлалт бий. Үүнд:

- Өмчлөлийн хэлбэрийн хувьд (ихэвчлэн Хятадын тал ихэнх хувийг эзэмшдэг хамтарсан компаниуд олон салбарт зонхилдог);
- Бизнесийн цар хүрээний хувьд (цахилгаан холбоо, банк, даатгал, жуулчлал, барилгын салбарт их дэлгэрсэн);
- Зарим төрлийн бизнес зөвшөөрөгддөг газарзүйн бүсийн хувьд (тухайлбал эдийн засгийн тусгай бүс, нээлттэй хот, зарим муж буюу тэдгээрийн нийслэлд).

Тусгай амлалт үүргийн төлөвлөгөөнд ДХБ-д элсэн орсноос хойш таван жилийн шилжилтийн хугацаанд арилгах хязгаарлалтуудыг заасан. Тиймээс бүх амлалт үүргээ биелүүлж дуустал либералчилалыг аажмаар хийнэ. Гэсэн хэдий ч тус төлөвлөгөөнд дурдаагүй олон төрлийн үйлчилгээ гадаадынханд хаалттай хэвээр үлдэх бөгөөд ҮХЕХ-ийн цаашдын хэлэлцээний нэг асуудал болж магадгүй.

III 2.6 Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлуудын тухай дүрэм

Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлуудын тухай хэлэлцээр (ОӨЭХХА) нь ТХЕХ ба ҮХЕХ-тэй хамтдаа ДХБ-ын эрх зүйн тогтолцооны тулгын гурван чулууг бүрдүүлдэг.⁴² Энэхүү судалгаанд энэ маш нарийн төвөгтэй дүрмийн тогтолцоог дэлгэрэнгүй авч үзээгүй. Гэхдээ ОӨЭХХА Хятадын ДХБ-ын өмнө авсан амлалт үүргээ биелүүлэх хамгийн чухал чиглэлүүдийн нэг гэж үзэх тул энэхүү хэлэлцээрийн үндсэн зарчмуудыг товчхон дурсах хэрэгтэй байж болно.

Үүний гол зорилго нь эрх эзэмшигчдийн хууль ёсны эрх ашиг, оюуны өмчийг ашиглагчдын эрх ашгийн хооронд тэнцвэрийг хангахад оршино. Сүүлийн жилүүдэд хуурамчаар үйлдсэн буюу хууль бусаар ашигласан бараа, бүтээгдэхүүний худалдаа маш ихэссэн тул олон улсын эдийн засгийн харилцаанд, ялангуяа аж үйлдвэржсэн орнуудын компаниуд хөгжиж буй орнуудад технологи шилжүүлэхэд ноцтой саад бэрхшээл учруулахаар хэмжээнд хүрчээ. Нөгөө талаар сүүлийнх нь эдийн засаг, нийгмийн дэвшлийг дэмжихийн тулд боломжийн нөхцөлөөр техникийн шинэ бүтээлийг ашиглах боломжийг хангасан байх ёстой.

ОӨЭХХА нь оюуны өмчийн эрхийн талаарх олон улсын гол гол конвенцууд дээр үндэслэсэн (ДОӨБ эдгээрийг хамаарсан байгууллага юм) бөгөөд НТҮ, Үндэсний нөхцөлийн үндсэн зарчмыг дахин баталгаажуулсан. Ялангуяа энэхүү хэлэлцээрт оюуны өмчийн эрхийн *“хүртээмж, авах, цар хүрээ, хадгалалт, хэрэгжүүлэлтийн”* хувьд улс орнууд гадаадын иргэдтэй өөрийн улсын иргэдтэй харьцдагаас илүү

⁴² *Бизнесийн лавлах, х. 13, 237 f.*

таагүй байдлаар харьцаж болохгүй гэж заасан. Үүний зэрэгцээ улс орнууд гадаадын иргэдийг хооронд нь ялгаварлан гадуурхахгүйгээр НТҮ-ний нөхцөл үзүүлэх шаардлагатай (ОӨЭХХА-ын 3, 4-р зүйлүүд).

Тус хэлэлцээрт патент, зохиогчийн эрх, холбогдох эрх, худалдааны тэмдэг, үйлдвэрийн дизайн, электрон схем, задраагүй мэдээлэл, үүний дотор худалдааны нууц, газарзүйн заалт, үүний дотор гарал үүсэлтэй холбоотой нэрийг хамгаалах үндсэн элементүүд, олгох эрхүүд, хамгаалах хамгийн бага хугацаа зэргийг тодорхойлсон.

Патентын хувьд тус хэлэлцээрт патентжуулсан бүтээгдэхүүн байдаггүй буюу асар өндөр үнэтэй байдаг олон улс оронд зөвшөөрдөг заавал авах лицензийн зарчмыг оруулсан. Ийм тохиолдолд улсын эрх ашгийн үндсэн дээр Засгийн газар нь сонирхсон үйлдвэрлэгч патент эзэмшигчдэд төлбөр хийсний үндсэн дээр патентыг ашиглах эрх өгч болно.

Цаашилбал тус хэлэлцээрт гэрээт лицензүүдийн өрсөлдөөний эсрэг практикийн асуудлуудыг тусгасан (ОӨЭХХА-ын 40-р зүйл).

ОӨЭХХА-ын III (41–50-р зүйл) бүлэгт хэрэгжүүлэх тухай заалтууд орсон учраас хамгийн чухал бүлэг юм. ОӨЭХХА-д ийм заалт оруулсан нь хэрэгжүүлэх арга замыг нэгдэгч улс орнуудыг өөрсдөө шийдэг гэж үлдээсэн ДОӨБ-ын конвенцуудаас нэг алхам түрүүлсэн хэрэг болжээ.

Энэ ч үүднээс ОӨЭХХА-д улс орнууд хэрэглэвэл зүйтэй байгууллагын механизм, журам, хууль зүйн хамгаалалтын хэрэглүүрийг заасан. Үүнд:

- ОӨЭ эзэмшигчдэд иргэний хуулийн дагуу хохирлоо арилгуулах боломж өгөх,
- Хуурамчаар үйлдсэн болон хууль бусаар ашигласан этгээдүүдийг эрүүгийн хуулиар яллах,
- Урьдчилсан нөхөн төлбөр олгох,
- Хуурамчаар үйлдсэн, хууль бусаар ашигласан болон ОӨЭ-ийг зөрчсөн бусад бүтээгдэхүүнийг гаалийн байгууллага нь нэвтрүүлэхгүй байх.

III 2.7 Шүүхийн хянан шийдвэрлэлт

ЭТП-ын 2Д заалтын дагуу Хятад дараах үүргийг хүлээсэн: *“1994 оны ТХЕХ-ийн X: 1-р зүйл, ҮХЕХ-ийн VI зүйл, ОӨЭХХА-ын тухай хэлэлцээрийн холбогдох заалтуудад заасан хууль, тогтоомж, шүүхийн шийдвэр, захиргааны шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой захиргааны бүхий л арга хэмжээг хурдан шуурхай хянаж үзэх, шүүн таслах байгууллага, холбоо барих цэг, журмыг байгуулж, томилж, байлгах. Эдгээр шүүн таслах байгууллага нь захиргааны хэрэгжүүлэлтийг хангах үүрэгтэй агентлагаас хараат бус, бие даасан, тухайн хэргийн үр дүнд мэдэгдхүйц сонирхолгүй байх ёстой”*. Хянан шийдвэрлэх ажиллагаанд давж заалдах боломж, үүний дотор захиргааны шийдвэрийг шүүн таслах байгууллагад давж заалдах эрх орно.

Өнөөг хүртэл Хятадын эдийн засаг, худалдааны тогтолцоонд байхгүй байсан хуулийг дээдлэх зарчмыг нэвтрүүлж, хамгаалахад энэхүү заалтын зорилго оршино.

III 2.8. Шилжилтийн дахин хянах механизм

ЭТП-ын 18-р заалтын дагуу ОТХТ-ны тодорхой асуудлуудыг шалгаж, үр дүнгээ Ерөнхий зөвлөлд шилжүүлдэг ДХБ-ын харъяа байгууллагуудын явуулах жил бүрийн шалгалтаар БНХАУ-ын ДХБ-ын дүрмийг дагаж мөрдөж байгаа эсэхийг

шалгана. Хятад холбогдох мэдээллийг өгөх ёстой. Ерөнхий зөвлөл дараа нь Хятад ДХБ-ын гэрээ хэлэлцээр, ЭТП-ын заалтуудыг хэрхэн хэрэгжүүлж байгааг хянан үзнэ. Хятад мөн бусад гишүүн улс орны авсан амлалт үүрэгтэй холбоотой асуудлыг дэвшүүлж болно. Ерөнхий зөвлөл шалгалтын үр дүнд зөвлөмжийг гаргаж болно.

Эдгээр дахин хянах ажиллагааг Хятад ДХБ-д элссэнээс хойш 8 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд дахин хянах эцсийн ажиллагааг элссэнээс хойш 10 жилийн дотор хийнэ. Өнөөг хүртэл ШДХМ-ыг хоёр удаа 2002, 2003 онд хийсэн. Маш идэвхтэй маргааны явцад олон амлалт үүргийн талаар маргалдаж хэлэлцсэн. Бид эдгээр зарим асуудал болон холбогдох хэлэлцүүлгийн талаар дараачийн бүлэгт эргэн ярих болно.

IV. Хятад улс сонгосон чиглэлүүдээрээ ДХБ-ын дүрмийг хэрхэн даган биелүүлж байна вэ?

IV 1. Хятад ДХБ-ын дүрмийг хэрхэн ойлгосон нь гадаад худалдааны дэглэмд нь туссан байдал

IV 1.1 Өмнөх үг

2004 оны 4-р сарын 6-нд Үндэсний ардын их хурал нь “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гадаад худалдааны тухай хуулийг” (ГХТХ) баталсан бөгөөд тус хууль 2004 оны 7-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон.⁴³

ГХТХ нь бараа, үйлчилгээний улс хоорондын хөдөлгөөнийг зохицуулсан бүрэн хууль тогтоомж, тухайлбал бүртгэл, гааль, чанарын шалгалт, стандарт, дампингийн эсрэг, татаас, хамгаалах арга хэмжээ, янз бүрийн үйлчилгээ, төрөл бүрийн оюуны өмчийн эрхүүд, шударга худалдааны дүрэм, гадаадын хөрөнгө оруулалтын тухай дүрэм зэрэг олон асуудалтай холбоотой асар олон төрөлжсөн хууль тогтоомжийн толгой хууль юм.

Энэхүү багц хууль тогтоомжийг ДХБ-ын дүрэмтэй нийцэж байгаа эсэхийг судлахын тулд ГХТХ-ийн зүйл заалтуудыг дан дангаар нь тайлбарлахгүй, харин уг тогтолцоог бүхлээр нь харах ёстой. Гэсэн хэдий ч энэхүү судалгаа нь шинэ ГХТХ-ийг голлон авч үзсэн бөгөөд төрөлжсөн хууль тогтоомж болон тэдгээрийн хэрэгжилтийн талаар хөндөж бичсэн.

Цаашилбал, ДХБ-ын дүрэм, үндэсний хууль тогтоомж шинж чанар, зорилгоороо өөр юм. ДХБ-ын дүрэм нь улс орнууд болон тэдгээрийн Засгийн газруудын харилцан хүлээх үүргийг заасан олон улсын хууль (ОӨЭХХА-ын тухай хэлэлцээрийн зарим заалтыг тооцохгүй бол) байдаг бол үндэсний хууль тогтоомж нь Засгийн газрууд болон иргэдийн хоорондох харилцааг зохицуулдаг. Засгийн газар нь үндэсний хууль гаргаж, олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх гэж байвал (жишээлбэл ДХБ-ын хэлэлцээрийн XVI: 4-р зүйлийн дагуу), тус Засгийн газар олон улсын гэрээ, хэлэлцээрийн үг үсгийг хуулах үүрэггүй; гэрээ хэлэлцээрт заасан үүргийн үзэл санааг хууль тогтоомжид тусгаж, дотоодын эрх зүйн орчинд тохируулсан байхад хангалттай.

ГХТХ нь хэд хэдэн төслүүдээс гарсан бөгөөд түүний нэг нь 2004 оны 1-р сард олон улсын бизнесийн хүрээнийхний дунд тараагдсан юм. Зарим саналыг тусгасны дараа нэмж засварласан төслийг 2004 оны 4-р сард олон улсын зарим хүрээнийхний дунд тараасан боловч гадаадын Элчин сайдын яамдад хүргүүлээгүй юм. Хуулийн болхи, чамин үг хэллэгийг ерөнхий нийтлэг үг хэллэгээр сольж, ДХБ-ын дүрэмтэй илэрхий зөрчилдөх заалтуудыг хасах замаар үг хэллэгийн найруулгыг сайжруулж өөрчилсөн.

Үүний үр дүнд гарч ирсэн одоо хэрэгжиж буй ГХТХ нь нэлээд товч тодорхой, амархан уншиж, ойлгохуйц, тус өргөн уудам улс даяар бага тушаалын албан тушаалтнууд хэрэгжүүлж чадах хууль болжээ. ГХТХ-ийг олон улсын бизнесийн хүрээнийхэн таатай хүлээн авч байх шиг санагдаж байна. Дипломатууд, бизнес эрхлэгчид, хуульчид ГХТХ-ийг цэвэр практик талаасаа одоо байгаа нөхцөл байдлыг нэлээд их сайжруулахаар хууль болжээ гэж дүгнэцгээж байна. Гэхдээ тэд хууль олон газраа бүрхэг тодорхойгүй байна гэдгийг цохон тэмдэглэж байна. Тийм учраас энэ хуулийг илүү либерал буюу илүү протекционист хандлагаар

⁴³ 2004 оны 7-р сарын 1-нд хэвлэгдсэн „Бээжингийн Тойм“ сэтгүүлийн 26-рт энэхүү хуулийг нийтэлсэн

тайлбарлахад чөлөөтэй. Энэ хуулийг өөр өөр газар өөр өөр байгууллага нэгэн зэрэг хоёр хандлагаар хэрэгжүүлж болохоор байна. Мужийн болон орон нутгийн түвшний түшмэд хуулийг илүү интервенционист буюу протекционист байдлаар хэрэгжүүлж болох талтай бол төрийн захиргааны төв байгууллагууд илүү реформист, либерал, дэвшилтэт хандлагаар хэрэгжүүлж болно. Гэхдээ төрийн захиргааны төв байгууллагуудын түшмэд ч гэсэн үндсээрээ өөр биш ч, нэлээд өөрөөр хуулийг тайлбарлаж хэрэгжүүлж магадгүй. Дотоодын үйлдвэрлэл Бээжинд, ялангуяа саяхан ҮШХК, ХЯ-д нэгдсэн хуучин Улсын эдийн засаг, худалдааны хорооныхны дунд хүчтэй лоббитой юм. ХЯ нь гадаад худалдааны дэг журам ДХБ-ын дүрэмтэй нийцэж байгаа эсэхийг хянадаг байгууллага тул сая сонгогдсон, либерализмыг хамгаалагч хэмээгддэг Бо Силай сайдын удирдлага дор тус яам Женев дэх ШДХМ-аар сайн үр дүн үзүүлэхийн тулд хичээл зүтгэл гаргаж болно. ХЯ нь гадаад худалдааны асуудалд зохицуулагч болон арбитрчийн (жишээлбэл дампингийн эсрэг хэргүүдэд) хувьд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг тул ГХТХ-ийг хэрэгжүүлэх талаар ХЯ-ны баримталж байгаа байр суурь нь чухал ач холбогдолтой юм.

Хэтдээ эрх барих байгууллагуудын шийдвэрийг давж заалддаг хараат бус шүүх засаглалыг байгуулсан цагт л ГХТХ-ийг нэг мөр хэрэгжүүлж чадна. Ийм шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг ЭТП-ын 2Д-д заасан бөгөөд одоогоор дөнгөж эхлэлийн шатандаа байна.

IV 1.2 Гадаад худалдааны наймаачны тухай ойлголт (худалдаа хийх эрх)

ГХТХ-ийн 8-р зүйлд зааснаар гадаад худалдааны наймаачид нь *“үйлдвэрийн болон худалдааны бүртгэлд бүртгүүлсэн буюу үйл ажиллагаа явуулахад шаарддаг бусад журмын шаардлагыг хангасан, гадаад худалдаа, наймаа эрхэлдэг хуулийн этгээд, бусад байгууллага, хувь хүмүүс юм”*. 4-р сарын төслөөс ялгаатай нь ГХТХ нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниудтай холбоотой, тэднийг ялгаварлан гадуурхсан тусгай заалтыг арилгасан байна. ХЯ-ны олж авсан мэдээллээс үзвэл гадаад худалдааны наймаачид нь Хятадын болон гадаадын, улсын болон хувийн, том болон жижиг компаниуд байж болно. Тэдэнтэй бүгдтэй нь ижил тэнцүү харьцах ёстой.

2004 оны 5-р сард Бээжинд төсөл нь тараагдсан "Гадаад худалдааны операторын бүртгэлийн арга хэмжээ"-нд зааснаар бүртгэл нь цэвэр албан ёсны үйл ажиллагаа ажээ. Өргөдөл гаргагч нь онлайн (электрон) хэлбэрээр байдаг бүртгэлийн маягтыг бөглөж, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл, байгууллагын кодны гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар болон Бүртгэлийн албаны "шаардлагатай гэж үзсэн" бусад материалыг хавсаргасан мэдээллийг өгөх ёстой. "Шаардлагатай гэж үзсэн" материалын тухайд ХЯ-наас орон нутгийн гадаад худалдааны байгууллагад итгэж өгсөн эрх юм. Бүртгэлийн ажиллагаа нь дээр дурдсан материал хүлээн авснаас хойш таван өдрийн дотор хийгдэж дуусах ёстой бөгөөд гадаад худалдааны наймаачин нь бүртгэлээ хүчингүй болгохгүйн тулд орон нутгийн гааль, гадаад валют, татварын газрууд болон "бусад алба"-нд "шаардлагатай бүртгэлийг" хийлгэнэ. Компанийн бизнесийн цар хүрээ зэрэгт гарсан өөрчлөлтийг бүртгүүлэх ёстой. Гадаад худалдааны наймаачнаар бүртгүүлсэн компаниуд нь бизнесийнхээ цар хүрээг өөрчлөөгүй бол дахин бүртгүүлэх шаардлагагүй. Гэхдээ сүүлийн журам нь хуучин дэглэмийн дагуу гадаад худалдааны хязгаарлагдмал эрхтэй байсан, одоо бизнесийн цар хүрээгээ өргөжүүлэхийг хүсэж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай олон компанид хамаарч болно.

"Арга хэмжээнүүд"-ийг цаасан дээр бичихэд амархан ч өргөдөл гаргагч бүх ажиллагааг дахиад бүр эхнээс нь эхлэхгүй байхын тулд маш богино хугацаанд хүнд суртлын зарим саад тотгорыг давах ёстой болдог учраас практикт олон

бэрхшээл гарч болно. Удахгүй бүртгэлийн өргөдөл гаргаж эхлэх тул эрх барих байгууллагууд "арга хэмжээнүүд"-ийг хэрхэн хэрэгжүүлдгийг харах үлдлээ.

ХЯ-наас зохиогчид мэдэгдсэнээр Бүртгэлийн алба нь гадаад худалдааны наймаачны статусыг олгох буюу олгохоос татгалзах бүрэн эрх мэдлийг эдлэхгүй. Өргөдөл гаргагч нь хуулийн шаардлагуудыг биелүүлж байвал бүртгэхийг шаардаж болох бөгөөд хэрэв шаардлагатай бол захиргааны хуулийн дүрмийн дагуу шийдвэрийн талаар гомдол гаргаж болно.

Гадаад худалдааны наймаачны статус нь экспорт, импортын бизнес эрхлэх эрхийг өгдөг. Энэ нь ЭТП-ын 5:1 заалтыг үг үсэгчлэн хэрэгжүүлж байгаа хэрэг мөн (*"Худалдаа хийх ийм эрх нь бараа, бүтээгдэхүүн импортлох, экспортлох эрх юм"*). Гэхдээ үүнд дотоодын зах зээл дээр худалдаа хийх эрх автоматаар орохгүй. Энэ нь бид үйлчилгээний зах зээлийг нээх асуудлыг ярихад эргэн авч үзэх зоосны нөгөө тал юм.⁴⁴

11-р зүйл нь ЭТП-ын 6-р заалтад заасанчлан улсын худалдааг зохицуулна. Улсын худалдаанд хамаарах бараа, бүтээгдэхүүний жагсаалтыг хараахан хэвлээгүй байгаа. Үүний агуулга нь ЭТП-ын 2-р хавсралттай нийцэж байгаа эсэхийг хянах шаардлагатай.

IV 1.3 Худалдаанд тавьсан хязгаарлалт

Улсаас бараа, технологийн импорт, экспорт, үйлчилгээний худалдааг хязгаарлах буюу хориглож болох нөхцөл байдлын урт жагсаалт 16, 26-р зүйлүүдэд орсон.

Эдгээр заалтын зарим нь (16-р зүйлийн 1-3, 8, 11-р заалтууд, 26-р зүйлийн 1, 2, 6-р заалтууд) ТХЕХ 1994-ийн ХХ зүйл, ҮХЕХ-ийн XIV зүйлийн холбогдох зүйл заалттай ямар нэг хэмжээгээр нийцэж байгаа бол үлдсэн заалтууд нь нийцэхгүй байна.

16-р зүйлийн 4-р заалтад *"дотоодын нийлүүлэлтэд хомсдол байгаа учраас мөн түүнчлэн шавхагддаг байгалийн нөөц баялгийг үр дүнтэй хадгалж хамгаалахын тулд"* экспортыг хязгаарлаж болохоор заасан. ТХЕХ 1994-ийн ХХ зүйлд зааснаар ийм хязгаарлалт нь дараах чухал нөхцөлөөс хамаарна: *"хэрэв эдгээр арга хэмжээг дотоодын үйлдвэрлэл буюу хэрэглээнд тавьсан хязгаарлалттай хослуулахад үр дүнтэй байвал"* 16-р зүйлийн 4-р заалт нь Хятадын Засгийн газар нь ТХЕХ-т бүрэн биш боловч баярлаж байгааг заасан хэд хэдэн заалтын нэг юм. Дөнгөж саяхан шийдвэрлэсэн Хятадын коксны экспортод тавьсан хязгаарлалтын талаар ЕХ-той хийсэн худалдааны маргааныг харж байхад ГХТХ нь зөвхөн тохиолдлоор бус харин зорилготойгоор ТХЕХ-ийг "цэгцэлсэн"-ийг тодорхой харуулж байна. Коксны экспортыг байгаль орчныг хамгаалах үүднээс хязгаарласан гэж байгаа боловч цаад учир шалтгаан нь дотоодын үйлдвэрлэл, хэрэглээ дээд цэгтээ тулсанд оршино. Үнэн хэрэгтээ дээрх арга хэмжээг Хятадын хэрэглэгчдийг гадаадын өрсөлдөөнөөс хамгаалахын тулд авсан ажээ.

ГХТХ-ийн 16-р зүйлийн 5, 6-р заалтуудыг ч мөн ТХЕХ-ийн дүрмийн дагуу зөвтгөх аргагүй. Эдгээр заалтын дагуу *"импортлогч улс орон буюу бүс нутгийн зах зээлийн чадавх хязгаарлагдмал учраас..."* эсвэл *"экспортын дэг журам ноцтой алдагдах (!) тохиолдолд"* экспортыг хязгаарлаж болно. ХЯ нь "зах зээлийн хязгаарлагдмал чадавх" гэдэгт урьд өмнө нь амьд мал, шувуу хэт их нийлүүлснээс болж зах зээл нь түр хугацаагаар пиг дүүрч байсан Гонконг, Макао дээрх бүтээгдэхүүнийг борлуулахыг хамааруулж байна. Эдгээр хязгаарлалтын талаар мэдэгдсэн бөгөөд ЭТП-д заасан. ГХТХ-ийн дээрх заалтуудаас үзэхэд

⁴⁴ х. 39 f.

Лаос, Камбож, Монгол зэрэг жижиг зах зээл бүү хэл дэлхийн бусад аливаа зах зээлд гарах экспортыг хязгаарлах боломжийг захиргаанд өгсөн байна. ЭТП-ын дагуу эдгээр заалтыг хэрэглэнэ гэсэн ХЯ-ны баталгааг (Гонконг, Макаогаар хязгаарласан) болгоомжтой авч үзэх хэрэгтэй. Ийм шаардлага байгаа нь ЕХ-той хийсэн коксны маргаанаас тодхон харагдаж байна.

ГХТХ-ийн 16-р зүйлийн 7-р заалтад “дотоодын тодорхой салбарыг хөл дээр нь босгох, энэ явцыг түргэсгэхийн тулд” импортыг хязгаарлах эрхтэй гэж заасан. “Шинэ салбар тутам”-ыг ийнхүү хамгаалахдаа ТХЕХ 1994-ийн XVIII зүйлийн 7а заалтыг үндэслэл болгож болно. Энэ зүйлд хөгжиж буй орнуудад тусгайлан өөрөөр хандах тухай заасан. Гэхдээ ТХЕХ 1994-ийн XVIII зүйлийн 7а заалт “шинэ салбар тутмын давуу эрх”-ийг зөвхөн ТХЕХ 1994-ийн XVIII зүйлийн 4а заалтад дурдсан улс орнуудад тухайлбал, хамгийн буурай хөгжилтэй улс орнуудад л үзүүлэхээр заасан. Гэхдээ Хятад энэхүү бүлэгт хамаардаггүй бөгөөд ДХБ-д хөгжиж буй улсын статустай элсээгүй.

Үйлчилгээний худалдаанд интервенц хийх ижил төстэй хэрэгсэл агуулсан ГХТХ-ийн 26-р зүйлийн 4-р заалтын хувьд мөн дээрхтэй ижил юм. Гэхдээ ҮХЕХ-т ТХЕХ 1994-ийн XVIII зүйлийн 7а заалттай төстэй заалт байхгүй. Учир нь ҮХЕХ-ийн зах зээлийг нээхэд баримтлах зарчим нь ТХЕХ-ийн зарчмаас үндсээрээ ялгаатай.⁴⁵ Хэрэв тухайн улс үйлчилгээний зах зээлээ гадаадын өрсөлдөөнд нээхийг хүсэхгүй байгаа бол ийм амлалт үүрэг авахгүй. Хэрэв амлалт үүрэг авсан бөгөөд холбогдох хуваарьт орсон бол, үүнийг цуцлах цорын ганц арга зам бол ҮХЕХ-ийн XXI зүйлийн дагуу хөнгөлөлтүүдээ цуцлах явдал бөгөөд ингэсэн тохиолдолд сонирхсон бусад гишүүн улс орнуудтай хэлэлцээ хийхэд хүрнэ.

ГХТХ-ийн 16-р зүйлийн 9-р заалт, 26-р зүйлийн 4-р заалтад “улсын санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн тэнцлийг хангаж байхын тулд” барааны импорт, үйлчилгээний худалдааг хязгаарлах тухай заасан. ТХЕХ 1994-ийн XII зүйлийн 2а заалт, ҮХЕХ-ийн XII зүйлийн дагуу ийм хязгаарлалтуудыг онц хүнд нөхцөлд л хэрэглэх ёстой бөгөөд ийм нөхцөлүүдийг ГХТХ-д тусгаагүй байна. ТХЕХ-ийн дүрмийн дагуу ийм зүйл заалт хэрэглэх эсэх нь шийдэгдээгүй.

ГХТХ-ийн 16-р зүйлийн 10-р заалт, 26-р зүйлийн 5-р заалтад “хууль, захиргааны дүрэм журамд заасны дагуу импорт, экспортыг хязгаарлах” эрхийг захиргаанд өгсөн ерөнхий заалтуудад оруулжээ. ХЯ энэхүү ерөнхий зүйл заалтыг оруулсан нь гадаад худалдааны үйл ажиллагаанаас үүдэн гарах нөлөөнөөс дотоодын бодлогын арга хэмжээний үр ашгийг хамгаалах зорилготой гэж тайлбарласан. Дээр өгсөн жишээнүүдээс харахад ийм нөхцөлүүдийг ГХТХ-ийн 16-р зүйлийн 2-р заалтад заасан бөгөөд ХТСТ буюу ЭАУЭА-н дагуу шийдэх хэрэгтэй. Одоо байгаагаараа ГХТХ-ийн 16-р зүйлийн 10-р заалт, 26-р зүйлийн 5-р заалтыг яаж ч урвуулан ашиглаж болохоор байна. Учир нь эдгээр заалт нь ДХБ-ын дүрэмд нийцэхгүй худалдааг хязгаарлах арга хэмжээ бүрийг “зөвтгөх” боломжтой.

IV 1.4 Гаалийн татвар ногдуулах үнийг тодорхойлох, тарифын ангилал

Бичмэл хууль, түүний хэрэгжилтийн хооронд одоо ч гэсэн байгаа зайны ялгааг харуулах нэг сайн жишээ бол гаалийн үнэлгээний практик юм.

2002 оны эхээр Хятад үнэлгээний практикийг ДХБ-ын Гаалийн үнэлгээний хэлэлцээртэй нийцүүлэхийн тулд үнэлгээний шинэ дүрмийг гаргасан билээ.⁴⁶

⁴⁵ Дээрхийг үз х.20 f.

⁴⁶ Дээрхийг үз х. 12/13

Шинэ дүрэм журам гарсан хэдий ч гаалийн олон албан хаагчид үнэлгээндээ гүйлгээний жинхэнэ үнийн оронд хамгийн бага буюу суурь үнийн жагсаалтыг хэрэглэсээр байна хэмээн импортлогчид мэдээлж байна. Энэ нь зарим тансаг хэрэглээний барааны импортын хувьд импортын төлбөр хураамжийг багаар тогтооход хүргэдэг боловч алим жимснээс авахуулаад машин, тоног төхөөрөмж, цахилгаан бараа зэрэг олон бүтээгдэхүүний хувьд төлбөр хураамжийг ихээр тогтооход хүргэдэг. Үүний зэрэгцээ Хятадын шинэ дүрэм журмын дагуу тухайн борлуулалтын нөхцөл болгож экспортлогчдыг лиценз ашиглалтын төлбөр, програм хангамжийн төлбөр төлсөн үед л тэдгээрийг гаалийн татвар ногдуулах үнэд оруулах ёстой гэж зөв заасан боловч гаалийн олон албан хаагчид дээрх төлбөрүүдийг гаалийн татвар ногдуулах үнэд шууд оруулан тооцсоор байна.⁴⁷

Үүнтэй адил Хятад 2003 оны 12-р сарын 11-н гэх болзолтой тооцсон агуулгын үнэ дээр үндэслэн тоон үзүүлэлтээр бүтээгдэхүүнийг үнэлэх аргыг халж, ДХБ-ын мэдээлэл боловсруулах тоног төхөөрөмжид зориулсан зөөгч хэрэгсэл агуулагч програм хангамжийг үнэлэх тухай шийдвэрийг хэрэгжүүлэхээр амлалт үүрэг авсан боловч одоо ч гэсэн уг аргаа хэрэглэсээр байна. Энэ шийдвэрт зөөгч хэрэгслийн үнэ дээр үндэслэн гаалийн татварыг үнэлнэ гэдгийг тодорхой заасан. Хятадын Засгийн газраар ДХБ-ын шийдвэрийг дагаж мөрдүүлэхэд АНУ-ын засаг захиргааны өндөр түвшний оролцоо шаардагдсан.

Тарифын ангилал нь Хятадын гаалийн албан хаагчидтай “хэлэлцээ” хийх нэгэн асуудал байсаар ирлээ. Хилийн өөр өөр боомт дээр өөр өөр арга хэрэглэсээр ирсэн. Эдгээр практик нь ялангуяа химийн бүтээгдэхүүний хувьд 2003 оны турш асуудал болсоор байв. Тарифын ангиллыг импортын татварын хувь багатай тарифын ангилалд оруулах талаар “хэлэлцэж тохирох” боломж нь гадаадын бизнесүүдэд заримдаа ашигтай байж болох ч хууль дүрмийг нэгэн жигд мөрдөхгүй байгаа нь хил дээр ямар хураамж авахыг урьдчилан таахад хэцүү болгож байна.⁴⁸

IV 1.5 Заавал дагаж мөрдөх стандарт, эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн дүрэм журмыг хэрэгжүүлж байгаа нь

Өөр өөр техникийн стандарт, тохирлын үнэлгээний журам хэрэглэх зэргээр импортын бараа, бүтээгдэхүүнийг ялгаварлах явдлыг арилгахын тулд⁴⁹, Хятад хэд хэдэн байгууллагыг нэгтгэн Чанарын хяналт, шалгалт, хорио цээрийн удирдах газрыг (ЧХШХЦУГ) 2001 оны 4-р сард байгуулжээ. Хятад мөн ЧХШХЦУГ-ын харъяанд хагас бие даасан хоёр агентлаг байгуулав. Тухайлбал:

Хятадын үндэсний гэрчилгээжүүлэлт, магадлан итгэмжлэлийн удирдах газар (ХҮГМИУГ) нь тус улсын тохирлын үнэлгээний дэглэмийг нэгтгэх үүрэгтэй бол Хятадын стандартчиллын удирдах газар (СУГ) нь заавал баримтлах стандартыг тогтоож, Хятадын бүтээгдэхүүний стандартын хэрэгжилтийг нэгтгэж, стандарт, техникийн дүрэм журмыг олон улсын практик, ХТСТ-ын дагуу Хятадын хүлээсэн амлалт үүрэгтэй нийцүүлэх үүрэгтэй.⁵⁰

Эдгээр болон бусад агентлагуудын үйл ажиллагааны хоорондох уялдаа холбоо нь асуудалтай байгаагийн зэрэгцээ, гадаадын компаниудад гэрчилгээ олгох ажиллагаа ил тод биш, шаардлагууд нь төвөг ихтэй, тусгай зөвшөөрөл олгох хугацаа урт байдаг талаар гомдоллосоор байна. Зарим компаниуд заавал хийлгэх чанарын шалгалтад зориулж өндөр технологийн бүтээгдэхүүний дээжийг өгөхөд тэдний оюуны өмчийг өрсөлдөгчдөд нь үзүүлж болох талаар санаа зовнидгоо

⁴⁷ АНУ-ын Худалдааны Тойм, х.62

⁴⁸ Мөн эх сурвалж.

⁴⁹ Мөн эх сурвалж.х.67

⁵⁰ Мөн эх сурвалж.

илэрхийлж байсан. Зарим тохиолдолд импортын бүтээгдэхүүнийг шалгах үүрэгтэй лабораториуд нь дотоодын өрсөлдөгчдийн салбар байгууллагууд байх нь бий.⁵¹

ХТСТ-ын дагуу улс орнууд олон улсын сайн тогтсон стандарт дээр үндэслэн техникийн стандартыг боловсруулж, тухайн сэдвийг сонирхогч олон улсын үйлдвэрийн хүрээнийхэнтэй зөвлөлдөх ёстой. Гэвч Хятад заримдаа шинжлэх ухааны үндэслэл багатай өвөрмөц шаардлагыг боловсруулдаг. Үүнээс үүдэн гадаадын компаниуд эдгээр шаардлагыг дагаж мөрдөхөд их зардал зарцуулдаг тул Хятадын зах зээлд нэвтрэхэд мэдэгдхүйц саад тотгор үүсгэдэг. Гадаадаас санал авах хугацааг заримдаа маш богино тавьснаас сонирхогч талууд эдгээр стандартыг хянахад хугацаа хангалтгүй байсан бөгөөд зарим стандартыг ХТСТ-ын дагуу мэдэгдээгүй байсан.⁵²

2001 оны 12-р сард ХҮГМИУГ бүтээгдэхүүнийг гэрчилгээжүүлэх заавал дагаж мөрдөх шинэ системийг тунхагласан. Энэхүү системийн дагуу Хятадын заавал дагаж мөрдөх гэрчилгээжүүлэлтийн тэмдэг (ХЗДМГТ) хэмээх чанарын болон аюулгүй байдлын цорын ганц тэмдэг бий бөгөөд үүнийг Хятадын болон гадаадын бүтээгдэхүүнд аль алинд нь хэрэглэнэ. Энэхүү тэмдгийн систем нь 2003 оны 8-р сарын 1-нд бүрэн хүчин төгөлдөр болох бөгөөд 100 гаруй бүтээгдэхүүний ангилалд шаардагдана.

Эдгээр эерэг өөрчлөлт гарч байгаа хэдий ч гэрчилгээжүүлэлт нь хэцүү, цаг авсан, үнэ өртөг ихтэй үйл явц хэвээр байна. Энэхүү үйл явцад Хятадын гадна орших үйлдвэрийн байгууламжийг газар дээр нь шалгах ажил орно. Үүний зардлыг үйлдвэрлэгчид хариуцдаг.

ХЗДМГТ-ийн дүрэм журмыг нэг мөр хэрэгжүүлэхгүй байгааг мэдээлж байна.⁵³ Тухайлбал, гэрчилгээ огт шаарддаггүй бараа тээвэрлэлтийг гааль оруулахгүй, зарим тохиолдолд шалгалтад шаардагдах дээжийг гаалиар оруулахгүй байна. ХЗДМГТ-ийг импортод саад тотгор учруулах зорилгоор ашиглаж байгаа нь илт байна.

Гадаадын компаниудын шүүмжилдэг нэг гол зүйл бол гадаадын үйлдвэрлэгчдийн Хятадын стандартад тохирсон хэмээн өөрсдийгөө гэрчилсэн гэрчилгээг Хятад хүлээн авдаггүй явдал юм. ЕХ нь Хятадыг Европын автомашин үйлдвэрлэлийн салбарын аюулгүй байдлын стандартын үндэслэл болох ЕЭЗК-ын дүрэм журмын дагуу автомашины гэрчилгээжүүлэлтийг хүлээн зөвшөөрөхийг хүсэж байна.⁵⁴ Эдгээр стандарт нь дэлхийн хамгийн орчин үеийн, хамгийн дээгүүр түвшнийг төлөөлөх нь ойлгомжтой.

Ерөнхийдөө гоо сайхан, эмийн бүтээгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмж, гар утас, харилцаа холбооны бусад бүтээгдэхүүн, хэрэглээний цахилгаан бараа зэрэг чанартай, батлагдсан бүтээгдэхүүнийг дэндүү их шалгаж байна. Тухайлбал, цахилгаан холбооны тоног төхөөрөмж дээр ХҮГМИУГ чанарын болон аюулгүй байдлын шалгалт хийдэг. Гэвч МII-ын явуулдаг ажиллагааны шалгалт нь ХҮГМИУГ-ын шалгалттай давхцадаг.⁵⁵

БНХАУ-ын импортод тавьдаг ургамлын эрүүл ахуй, мал эмнэлгийн стандартыг заримдаа эргэлзээтэй шинжлэх ухааны зарчим дээр үндэслэдэг бөгөөд нэг мөр хэрэгжүүлж чадаагүй. ДХБ-д элсэх боломжоо нэмэгдүүлэхийн тулд Хятад АНУ-ын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний импортод удаан хугацааны турш тавьж байсан

⁵¹ Мөн эх сурвалж.

⁵² Мөн эх сурвалж. х. 68

⁵³ Мөн эх сурвалж. х. 69

⁵⁴ Хятад дахь Европын бизнес, нөхцөл байдлын тухай илтгэл 2002-2003, х.102 f (105/106)

⁵⁵ АНУ-ын Худалдааны Тойм, х.70

саад тотгорыг шийдвэрлэсэн⁵⁶ нь Монголын хувьд сонирхох нэг зүйл юм. Хятад нь мах, шувуу зэрэг бүтээгдэхүүний импортод тавьсан хоригийг цуцлахаар зөвшөөрсөн бөгөөд АНУ-ын махны гэрчилгээжүүлэлтийн тогтолцоог хүлээн зөвшөөрөхөөр болж, АНУ-ын үхэр, гахай, шувууны махыг АНУ-ын гэрчилгээжсэн үйлдвэрүүдээс хүлээн авч байхаар амласан.⁵⁷

IV 1.6 Импортын тусгай зөвшөөрөл олгох ажлын зохион байгуулалт ба тарифын түвшний квот

Импортын тусгай зөвшөөрөл олгох ажлын зохион байгуулалт ба ТТК-ыг ил тод байдал байхгүй гэх нийтлэг шинжээр нь хамтад нь авч үзнэ.

ДХБ-ын өмнө авсан амлалт үүргийнхээ дагуу Хятад импортын тусгай зөвшөөрөлд хамрагдах бүтээгдэхүүнийхээ тоог нэлээд их багасгасан. Хятад мөн тусгай зөвшөөрөл олгох журмыг шударга, үл ялгаварлах зарчмаар хэрэгжүүлнэ гэж амлалт авсан.

2003 оны байдлаар 52 нэр төрлийн бүтээгдэхүүн (8 оронтой тарифын түвшинд 338 зүйлтэй тэнцэх) янз бүрийн экспортын тусгай зөвшөөрөлд хамрагддаг хэвээр байна. Тухайлбал үр тариа, хөвөн, мал, түүхий эд, металл, хортой химийн бодис, хүнсний бүтээгдэхүүн зэргийг дурдаж болно. Хайлуур жонш, коксны хувьд экспортын тусгай зөвшөөрлийн дагуу экспортлогчид захиргааны зардлаас өөр хураамж төлөх шаардлагатай бөгөөд экспортын квот мөн дагалдана. Үүний зэрэгцээ Хятад заримдаа стратегийн чухал бараа, бүтээгдэхүүнд экспортын тусгай зөвшөөрөл олгох шинэ шаардлагыг тавьдаг.

Экспортын тусгай зөвшөөрөл нь гадаад улс орнуудын дампингийн эсрэг татварт хамрагдах бүтээгдэхүүнд шаардлагатай.

Засгийн газар нь тусгай зөвшөөрөл олгох үүргийг төвлөрсөн төлөвлөлтийн эхний үед үйлдвэрлэлийг зохицуулдаг байсан яамдыг орлохоор байгуулагдсан Засгийн газрын байгууллагын шинжийг агуулсан салбарын холбоодод өгсөн. Салбарын холбоод нь компаниудыг холбооны үйл ажиллагаанд оролцуулахаар шахалт үзүүлэхдээ экспортын тусгай зөвшөөрөл олгох эрх мэдлээ ашиглаж байна гэж гадаадын хөрөнгө оруулагчид мэдээлж байна.⁵⁸

Хятад ДХБ-д элсэхдээ тусгай зөвшөөрөл авахын тулд худалдаачны өгөх ёстой мэдээллийг хязгаарлахгүй, тусгай зөвшөөрлийг хэрэгцээгүй дарамт болгохгүй, тусгай зөвшөөрөл олгох ажиллагааны ил тод, урьдчилан мэдэгдэх байдлыг дээшлүүлнэ гэсэн амлалт үүргийг авсан. Хятадыг ДХБ-д элссэний дараахан ХЯ нь тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг хөнгөвчлөх шинэ дүрэм журмыг гаргасан. Гэсэн ч тусгай зөвшөөрөл хүсэгчид нь экспортын энгийн хяналтад шаардлагагүй бизнесийн нарийн эмзэг мэдээллийг өгөх ёстой болдог талаар мэдээлсэн.⁵⁹

Цаашилбал, ДХБ-д элсэн орсноосоо хойш Хятад ТТК-ын тогтолцоогоо нэлээд бэрхшээлтэй байдлаар хэрэгжүүлсэн. Тухайлбал, дүрэм журмыг хожуу гаргасан, шаардлагатай хэмжээнд ил тод байлгаагүй, тусгай журам олгох ажиллагааг төвөг ихтэй болгосон. ТТК-ын хуваарилалтыг үргэлж хойшлуулсаар ирсэн.⁶⁰

Энэ нөхцөл байдал 2003 оны эцэс гэхэд сайжирсан боловч, хамгийн ноцтой асуудал болох ил тод байдал байхгүй, ТТК-ын хэсгүүд, хуваарилалтын хэмжээ

⁵⁶ Мөн эх сурвалж.

⁵⁷ Мөн эх сурвалж.

⁵⁸ Мөн эх сурвалж. х. 67

⁵⁹ Мөн эх сурвалж. х. 66

⁶⁰ Мөн эх сурвалж. х. 65/66

жигжиг, тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа төвөг ихтэй байдаг зэрэг асуудлууд хэвээр байсаар байна.⁶¹

IV 1.7 Хятадын эдийн засаг дахь татаасын үүрэг

Татаас нь Хятадын эдийн засгийн нэгэн түгээмэл үзэгдэл юм. Энэ нь зарим талаар аж ахуйн нэгжүүд улсын төсөвт орлого оруулж, хариуд нь үйл ажиллагааныхаа зардлыг нөхөх улсын төсвөөс хуваарилагдсан мөнгийг авдаг байсан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн олон уламжлалын нэг юм. Эдийн засгийн шинэчлэлийн явцад энэхүү төсвийн хуваарилалтыг зээл хэмээн нэрийдэж өөрчилсөн. Эдгээр зээлийн ихэнх хэсгийг буцаан төлөөгүй бөгөөд улсын банкуудын олгосон найдваргүй зээлийн эхний үе болсон. Бодит байдал дээр аж ахуйн нэгжүүдэд мөнгө хуваарилдаг хуучин заншил хэвээр байсаар байна.

Өнөөдөр янз бүрийн нөхцөл бүхий зээл хуваарилалтыг үйлдвэрийн бодлогын нэг хэрэгсэл болгон ашиглаж байна. Тухайлбал, төрийн хэд хэдэн салбар янз бүрийн учир шалтгаанаар ийм зээл авсаар байна. Тухайлбал, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх (буюу “гол”) салбарууд гэж тооцогддог, тодорхой салбар буюу бүс нутагт ажилгүйдлийн түвшинг боломжийн түвшнээс доош оруулахгүй байх зэрэг нийгмийн зорилтыг биелүүлэх зэрэг шалтгааныг дурдаж болно. Одоогоор хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг сүлжмэл, ган, төмөрлөг бус металл, машин тоног төхөөрөмж, нефть-химийн салбарт өгч байна. Ийм зээлүүд ямар хэмжээнд ДХБ-ын дүрэмтэй нийцэхгүй экспортын татаас гэж тооцогдох, ТСАХТХ-ийн хүрээнд шүүхээр заргалдаж болох татаасын шинжтэй эсэхийг⁶² тодорхойлох боломжгүй. Учир нь ийм зээлийн бодлогыг зохицуулсан дүрэм журмыг ерөөсөө нийтлээгүй. Гэхдээ зарим салбарын гадаадын өрсөлдөгчид Хятадын компаниудын өрсөлдөөний улмаас санхүүгийн хүндрэлд орж байгаа тул ийм зээл нь олон улсын худалдаанд нөлөөлж байна гэсэн сэжиг нэлээд түгжээ. Жишээлбэл, Хятадын худалдаачид ийм төрлийн худалдаанд баймааргүй их хэмжээний бэлэн мөнгө өвөртлөн Монголын ноос ноолуурын зах зээлд орж ирж байгаагаас мөнгө багатай Монголын ноолуурын үйлдвэрүүд арга мухардаж байна.

Татаас гэж үзэх өөр нэг практик бол ЭТП-ын 9:1 заалтын дагуу Хятадын арилгана гэж үүрэг авсан хоёр шаттай үнэ тогтоох тогтолцоо юм. Бодит байдалд хаана, ямар хэмжээгээр гэдгийг нь тогтооход хэцүү ч тус тогтолцоог хэрэглэсээр байна. Тээврийн салбар нь дотоодын болон гадаадын үйлчлүүлэгчдэд өөр өөр ханшаар үйлчилдгээрээ алдартай. Гадаадынханд хүртээлгүй дотоодын нислэгийн зарим хямдралыг Хятадын хотын гудамжаар ил тод сурталчилдаг. Төмөр замын тарифын бүтцэд ч иймэрхүү жишээ олон бий. Импорт, экспортын бараа, бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэхэд их өртөгтэй байдаг нь Монголын эдийн засагт их бэрхшээл учруулж байна.⁶³ Хэдэн жилийн өмнө Хятад төмөр замын ийм тээврийн тарифыг тавин хувиар бууруулсан ч гэсэн ДХБ-ын үл ялгаварлах зарчим, ЮНКТАД-ын Барселоны дүрмийн дагуу далайд гарцгүй орнуудад үзүүлэх ёстой дотоодын тарифаас их хэвээр байна. Бээжин дэх АНУ-ын Элчин сайдын яам нь Хятадыг хөдөө аж ахуй, ялангуяа эрдэнэ шишийн экспортыг дэмжихийн тулд дээрхтэй төстэй хөнгөлөлттэй үнэ тарифыг хэрэглэдэг байж магадгүй гэж сэжиглэж байна.⁶⁴

Орлогын хамгийн чухал эх үүсвэр НӨАТ-ыг бүтээгдэхүүнээс хамааран тэгш бус 13-17%-иар тогтоодог нь эдийн засгийн зарим салбарыг тэтгэх өөр боломжуудыг нээж байна. Янз бүрийн салбарын импортлогчид нь импортын бараанд ногдуулдаг татварыг хил дээр найдвартай хурааж авдаг тул тэд заримдаа

⁶¹ Мөн эх сурвалж.

⁶² Дээрхийг үз х. 15 f. (16)

⁶³ Дээрхийг үз х. 32, х. 60/61

⁶⁴ АНУ-ын Худалдааны Тойм-ыг үз, х. 72

дотоодын өрсөлдөгчид төлдөггүй НӨАТ-ыг төлдөг гэж мэдэгдэж байна.⁶⁵ Химийн бордоо, бичил схемийн салбарт НӨАТ-ыг бууруулах буюу НӨАТ-аас чөлөөлсөн зэрэг томоохон хэргүүд бий. АНУ нь ДХБ-ын зөвлөлийн шийдвэрийг гаргуулахаар хандах гэж байсны дараа АНУ, Хятадын Засгийн газрууд сүүлийн хэргийг саяхан шийдвэрлэсэн.⁶⁶

Хаягдал зэс, зэсийн хүдэр, баяжмал, түүхий зэс импортлогчид үүнтэй төстэй хөтөлбөрийн үр ашгийг хүртдэг. Шилжилтийн дахин хянах механизмын явцад Хятадын төлөөлөгчдийн өгсөн тайлбараар бол зэс хайлуулах үйлдвэрүүд нь зэс материал импортлохдоо НӨАТ-ыг төлөх ёстой. Гэхдээ тухайн үйлдвэр тодорхой нөхцөлийг хангаж байвал Засгийн газар нь тухайн үйлдвэрийн төлсөн НӨАТ-ын 30%-ийг буцаан олгоно. Энэхүү хөнгөлөлтөд хамрагдахын тулд тодорхой үйлдвэрлэлийн түвшинд хүрч, үйлдвэртээ технологийн шинэчлэл (ямар гэдгийг нь тодорхой заагаагүй) хийсэн байх ёстой бөгөөд зэс хаягдлын тухайд эцсийн буюу хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортоос хамаарна.

Энэхүү НӨАТ-ын буцаан олгох хөтөлбөрийг БНХАУ-ын худалдааны гол түншүүд (АНУ, ЕХ, Япон) шүүмжилж байгаа бол,⁶⁷ энэ хөтөлбөр нь Хятадын хайлуулах үйлдвэрүүдэд зэсийн баяжмал борлуулах явцыг дэмжих учир Монгол улсад түр хугацаанд үр ашгаа өгч болно. Цэвэршүүлсэн зэс экспортлох хүчин чадал багатай Монгол улсад Хятадын зэс үйлдвэрлэгчдийн татаас бүхий экспорт ямар ч байсан өнөө маргаашдаа сөргөөр нөлөөлөхгүй.

Үүнтэй ижил дэглэм (эцсийн бүтээгдэхүүний экспортоос хамаардаг импортын түүхий эдэд төлсөн НӨАТ-ын буцаан олголт) ноолуур, ноос, арьс, ширийг мөн хамардаг. Энэ нь тухайн үйлдвэр төвлөрсөн бүс нутгуудад мужаас доод түвшинд хэрэгждэг.

НӨАТ-ын буцаан олголтыг хийхдээ ихэвчлэн хугацаа алддаг боловч НӨАТ-ын буцаан олгох хөтөлбөр нь экспортын олон төрлийн бүтээгдэхүүнийг хамардаг. 2003 онд Хятад дутуу үнэлсэн юанийн талаар гадаадаас гаргасан гомдлуудын хариуд экспортын НӨАТ-ын буцаан олголтыг 3 хувиар бууруулахаар зарласан.⁶⁸

Зарим салбарт хэрэглэдэг НӨАТ-ыг бууруулах, НӨАТ-аас чөлөөлөх хөтөлбөрүүд нь импортыг орлуулах хөтөлбөртэй зэрэгцэн хэрэгжих нь олонтаа, тиймээс ч ТСАХТХ-ийн 3:1б заалттай илэрхий зөрчилддөг.

ДХБ-ын гишүүн улс орнуудын ихэнхэд биш юмаа гэхэд олон улс оронд экспортын бүтээгдэхүүнд ногдох НӨАТ-ыг тэглэсэн нь ТСАХТХ-ийн 2:2 заалттай бүрэн нийцэж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ Хятадад экспортод НӨАТ-ыг хөнгөлөлттэй хувиар ногдуулдаг. Асуудлын гол нь НӨАТ-ыг бууруулах хөтөлбөрүүдийг зарим салбарыг сонгож, тэгшбүс хэрэгжүүлдэгт оршино. Ингэснээр зарим үйлдвэр, бүлгүүдэд давуу тал олгож, өрсөлдөөнийг ноцтой алдагдуулна. Аль ч тохиолдолд энэ асуудлыг ДХБ-ын хэм хэмжээний дагуу цаашид судалж, шалгаж, үнэлэх хэрэгтэй бөгөөд уг асуудлаас үүдэн ДХБ-ын Татаас, саармагжуулах татварын хороон дээр хурц маргаан өрнөх болно.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд болон Эдийн засгийн тусгай бүсүүд болон татварын өөр дэглэмтэй бусад бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг компаниудад хэрэглэдэг татварын зарим дүрэм журмын дагуу татварын хөнгөлөлт

⁶⁵ Мөн эх сурвалж. х.60, 63

⁶⁶ Мөн эх сурвалж. х.60

⁶⁷ ДХБ-ын Татаас, саармагжуулах арга хэмжээний хороо; Баримт бичиг G/SCM/111 (2003 оны 11-р сарын 18); ДХБ-ын Барааны худалдааны зөвлөл; Баримт бичиг G/L/ 664 (2003 оны 12-р сарын 4) х.3, 6

⁶⁸ АНУ-ын Худалдааны Тойм, х. 63

нь экспортын гүйцэтгэлээс шууд хамаардаг тул ТСАХТХ-ийн дүрэмтэй нийцдэггүй. Энэ асуудлыг Шилжилтийн дахин хянах механизмын явцад хэлэлцсэн.⁶⁹ Энд Хятадын төлөөлөгчид эдгээр заалтуудыг ТСАХТХ-тэй хэрхэн нийцэж байгаа болон дахин хянаж байгаа болохыг мэдэгдсэн. Гэхдээ Хятадын хэвлэл мэдээллээр гарч байгаа хамгийн сүүлийн үеийн мэдээ сурвалжлагаас харж байхад энэхүү маргаантай байгаа татварын давуу эрхийг агуулга талаас нь бус харин зөвхөн хэлбэр төдий өөрчлөх төлөвтэй. “Бүс-боомтын харилцах хэсэг” буюу ББХХ хэмээх шинэ хөтөлбөрт “татварын буцаалт хийх шинэчилсэн механизм”-ын талаар заасан. Хятадаас бараа гарсны дараа буцаалт хийдэг одоогийн практикийг үргэлжлүүлэхийн оронд бүс-боомтын харилцах бүс рүү дотоодын барааг орж ирэнгүүт буцаан олголт хийдэг болно.⁷⁰

Дүгнэж хэлэхэд Хятадын эдийн засгийн хэрэгт төр нь оролцдог он удаан жилийн уламжлалтай тул ДХБ-ын дүрмээр үнэлэхэд хэцүү татаастай төстэй буюу бараг татаас гэхээр маш олон янзын арга хэмжээг авсаар байгаа гэж хэлэхэд хилсдэхгүй. Хятадын ДХБ-д элсэн орохдоо авсан амлалт үүргийг биелүүлж байгаа байдлын хувьд татаас хамгийн эмзэг цэгүүдийн нэг юм. Хятад өнөөг хүртэл татаасын хөтөлбөрийн талаараа мэдэгдээгүй байгаа тул дараачийн ШДХМ-ын үеэр илүү урам хугалсан маргаан дэгдэж болзошгүй.⁷¹

IV 1.8 Гадаад худалдааны шалгалт, худалдааны эрх зүйн хамгаалалтын хэрэглүүр

ГХТХ-ийн 37-39-р зүйлүүдийн дагуу ХЯ нь барааны импорт, экспорт, технологийн импорт, экспорт, үйлчилгээний олон улсын худалдаа, бусад улс орон, бүс нутгийн худалдааны саад тотгор нь дотоодын салбарууд болон тэдгээрийн өрсөлдөх чадварт хэрхэн нөлөөлж байгааг судалж, худалдааны эрх зүйн хамгаалалтын хэрэглүүрт шаардлагатай эсэхийг тогтоох эрхтэй.

ГХТХ-ийн 40-50-р зүйлүүд нь татаас, дампингийн эсрэг болон саармагжуулах татвар болон хамгаалах арга хэмжээний тухай дүрмүүдийг хамарсан.

ГХТХ-ийн 43-р зүйлд экспортлогч улс орон буюу бүс нутаг нь импортын бүтээгдэхүүнд шууд буюу шууд бусаар ямар нэг хэлбэрээр татаас өгсний улмаас дотоодын салбарт материаллаг хохирол учрах буюу дотоодын салбар бий болгоход материаллаг бэрхшээл учирсан буюу учрах аюул заналхийлбэл улс ийм хохирол, хохирлын аюул, хоцрогдлыг арилгах буюу хязгаарлахын тулд саармагжуулах арга хэмжээ авч болно гэсэн зарчмыг тусгасан. Татаасын эсрэг шалгалтын тухай сайдын нарийн дүрэм, холбогдох эсрэг арга хэмжээнүүд нь 2002 оны эхээр хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.⁷²

Үүнтэй адил ГХТХ-ийн 41-р зүйлд дампингийн эсрэг арга хэмжээний талаар заахдаа бусад улс орон, бүс нутгаас дотоодын зах зээлд ердийн үнээс бага үнээр бүтээгдэхүүн оруулж ирсний улмаас дотоодын салбарт материаллаг хохирол учрах буюу дотоодын салбар бий болгоход материаллаг бэрхшээл учирсан буюу учрах аюул заналхийлбэл улс ийм хохирол, хохирлын аюул, хоцрогдлыг арилгах буюу хязгаарлахын тулд дампингийн эсрэг арга хэмжээг авч болно гэж заасан.

⁶⁹ ДХБ-ын Татаас, саармагжуулах арга хэмжээний хороо; Баримт бичиг G/SCM/ 111 (2003 оны 11-р сарын 18) х. 5

⁷⁰ Хятад өнөөдөр, 2004 оны 8-р сарын 26

⁷¹ ДХБ-ын Татаас, саармагжуулах арга хэмжээний хороо; Баримт бичиг G/SCM/ 111 (2003 оны 11-р сарын 18)

⁷² К.Алмстэдт, П.М.Нортон нар Хятадын татаасын эсрэг дүрэм журмын талаар сонирхолтой судалгаа хийсэн (Хятадын хууль, туршлага, 2002 оны 12-р сар/2003 оны 1-р сар 16(10) О'Мэлвэни ба Майэрсын судалгааны тайлан "Хятадын хуулийн асуудал"-д дахин хэвлэгдсэн, 2003 оны 4-р сар

Үүний адил ГХТХ-ийн 42-р зүйлд гуравдагч орноор дамжин Хятадад хямд үнээр орж ирсэн бүтээгдэхүүний талаар ямар арга хэмжээ авахыг заасан.

Хятадыг ДХБ-д элсэж, ГХТХ-ийг тунхаглахаас өмнө эдгээрийг 2001 оны 10-р сарын 31-ний өдрийн Төрийн зөвлөлийн 328 тоот тогтоолоор (2001) зохицуулж байлаа.

ГХТХ-ийн 44-р зүйлд дотоодын үйлдвэрлэгчдэд (дотоодын үйлдвэрлэгчдэд гэвэл илүү зохино) ноцтой хохирол учруулан эсвэл учруулахаар заналхийлэхээр их тоо хэмжээгээр бүтээгдэхүүн импортлохын эсрэг хамгаалах зүйл заалтуудыг оруулсан.

Ийнхүү Хятад ДХБ-ын дүрмээр хэрэглэх боломжтой худалдааны эрх зүйн хамгаалалтын бүхий л хэрэглүүрийг хэрэглэжээ. Хуулийн маш олон зүйл заалттай холбоотой учраас нэг бүрчлэн, зүйл зүйлээр ДХБ-ын холбогдох хэлэлцээрүүдтэй нийцэж байгаа эсэхийг нь шалгаж судлахад энэхүү судалгаа хүрэлцэхгүй.⁷⁵ Ерөнхийдөө ГХТХ-ийн янз бүрийн зүйл заалтад хялбаршуулсан буюу товчилсон хувилбарууд байгаа боловч Хятадын хууль тогтоомж ямар нэг хэмжээгээр ДХБ-ын хэлэлцээрүүдтэй нийцэж байна гэж хэлэхэд болно. Алмстэдт, Нортон хоёр Хятадын татаасын эсрэг дүрэм нь зарим газраа бүрхэг тодорхойгүй гэж зөв дүгнэсэн. Тухайлбал, “хохирол учруулах аюул занал”, импорт ба хохирлын хоорондох учир шалтгааны холбоос, татаас, үр ашгийн ойлголтууд тодорхой бус байна. ДХБ-ын дүрэм журмын талаар БНХАУ туршлагагүй байгаа тул эдгээрийг ТХЕХ 1994, ТСАХТХ, ДЭУАТХ-ийн дагуу илүү дэлгэрэнгүй боловсруулах хэрэгтэй. Алмстэдт, Нортон нар Хятадын худалдааны шалгалт нь практикт хууль тогтоомж тодорхой бус байгаа яг тэр цэгүүдэд ДХБ-ын стандартаас хоцорч байна хэмээн цохон тэмдэглэсэн.⁷³

Үүнээс ч илүү анхаарал татсан асуудал бол Хятадын эрх баригчдын процессын практик юм. 2002 оноос хойш хорин дөрвөн дампингийн эсрэг шалгалт, нэг хамгаалах шалгалт (ган) хийгдээд байна. Тиймээс зарим дүгнэлтийг хийхэд хангалттай туршлагыг хуримталжээ.

ТСАХТХ-ийн 12-р зүйлийн дагуу олж илрүүлсэн зүйлс нь “үнэн зөв мэдээлэл” дээр үндэслэсэн байх ёстой бөгөөд ТСАХТХ-ийн 22:2-6 заалтуудын дагуу баримт, амладаг, түдгэлзүүлдэг, урьдчилсан ба эцсийн шийдвэр гаргадаг үндэслэл болох хуулийн хувьд “хангалттай мэдээлэл” шаардагддаг.

Хятадын дампингийн эсрэг болон татаасын эсрэг журмуудад эдгээр шаардлагыг орхигдуулсан нь бэрхшээл учруулж байна. Тухайлбал, эрх баригчид үйл баримтыг тогтоохдоо сонирхогч талуудын (эсвэл ДХБ-ын шалгах бүрэлдэхүүн) үйл баримтыг тогтоосон үндэс болон процессын явцад гаргаж тавьсан нотолгоог хүлээн авах, авахгүй шалтгаануудыг тодорхойлж болох хангалттай мэдээлэлгүй байдаг.

Процессын хувьд ижил төстэй дампингийн эсрэг болон хамгаалах шалгалтуудын туршлагаас харахад дараах хоёр чиглэлээр асуудал, бэрхшээл гарч болохоор байна. Үүнд:

Нэгдүгээрт, зохистой дүрэм байсан ч гэсэн практикт худалдааны шалгалтын явцад хэлэлцэх ажиллагаа нь хэлбэрийн төдий байх хандлагатай. Талууд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх хангалттай хугацаагүй байдаг бөгөөд эрх зүйн болон нотлох баримтыг танилцуулах ажиллагаа бараг ямар ч асуулт байхгүй албан ёсны шинжтэй байдаг.

⁷³ Мөн эх сурвалж. х. 2,3,5,6

Гол нь Хятадын худалдааны шалгалтуудад ил тод байдлын асуудал байнга байсаар ирсэн. Талууд хоорондоо бичгээр харилцах тухай ердийн журам байхгүй бөгөөд агентлагийн хавтаст хэргийг үзэх боломж цагтаа олддоггүй. Ямар ч тохиолдолд Хятадын талууд асар их мэдээллийг нууц хэмээн гаргадаггүй бөгөөд эрх баригчид үүнийг нь маргалгүй хүлээн зөвшөөрдөг тул нэвтрэх боломж нэг их тус болохгүй. Талуудын шалгагч байгууллагатай албан бусаар харьцах нь онцгой тохиолдол бус харин дүрэм болчихжээ. Нэхэмжлэгч нь ерөнхийдөө улсын өмчийн буюу засгийн газрын өмчийн үйлдвэрийн газрууд байдаг бөгөөд заримдаа шалгалт хийж байгаа агентлаг нь тэдэнд чиглэл өгдөг тогтолцоонд энэ нь илүү бэрхшээл учруулж байна.⁷⁴ Тэгэхээр эдгээр практик нь ШДХМ-ын явцад шүүмжлэгдсэнд гайхах юм алга.⁷⁵

IV 2 Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээ

ДХБ-д элсэн орохоосоо өмнө Хятад гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн тухай хууль тогтоомж, ялангуяа 2001 оны 3-р сарын 15-нд нэмж өөрчлөгдөн батлагдсан Хамтарсан компанийн тухай хуулийг хянаж, нэмэлт өөрчлөлт оруулсан. Экспортын гүйцэтгэл, дотоодод үйлдвэрлэсэн орц, гадаад валютын тэнцвэржүүлэлт болон технологи шилжүүлэх зэрэгтэй холбоотой ДХБ-тай үл нийцэх шаардлагуудыг устгасан.

Хятад мөн түүхий эд, шатахуун худалдан авахтай холбоотой харилцааг зохицуулдаг "Хятадын худалдан авах" бодлогыг хянаж засварлан, хамтарсан компани, ГДХОААН-ууд Хятадын эрх баригчдад үйлдвэрлэл/үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг гаргаж өгдөг шаардлагыг устгасан. Гэхдээ зарим арга хэмжээг албан ёсоор шаардахгүй ч гэсэн технологи шилжүүлэхийг хөхиүлэн дэмжсээр байна. Засгийн газрын албан тушаалтнуудад хөрөнгө оруулалтын өргөдлийг хянан үзэхэд их эрх мэдэл өгсөн тул практикт ийнхүү "хөхиүлэн дэмжих" нь олон тохиолдолд "шаардлага" болон хувирдаг хэмээн гадаадын компаниуд санаа зовнин ярьцгааж байна. Үүний зэрэгцээ, АНУ-ын компаниудын хэлж байснаар Хятадын Засгийн газрын албан тушаалтнууд хөрөнгө оруулалтыг батлах буюу хөрөнгө оруулалтын төслийн амжилтад зайлшгүй чухал Хятадын бодлогын банкнаас зээл авахад тодорхойлолт өгөхдөө экспортын гүйцэтгэл, дотоодод үйлдвэрлэсэн орц зэрэг хүчин зүйлийг харгалзан үзсэн хэвээр байна.⁷⁶

ХХОАХ-ний тухай хэлэлцээр болон Хятадын ЭТП-ын дагуу хориглогдсон ХХОАХ-үүдээс гадна ДХБ-ын дүрмүүд аливаа улс орныг хөрөнгө оруулалтын орж ирэх урсгалыг зохицуулахад саад болдоггүй. Тиймээс хөрөнгө оруулалтын удирдамж нь чиглэлээ сүүлийн таван жилийн хугацаанд хэд хэдэн удаа өөрчилсөн. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь хөрөнгө оруулахыг хүссэн хүмүүсийг төөрөгдүүлж, хөрөнгө оруулалтын удирдамжийн чиглэл нь бизнес төлөвлөлтийн тогтвортой үндэслэл болдоггүй гэсэн ойлголтыг улам бэхжүүлж байна. АНУ-ын Худалдааны төлөөлөгч нь аль салбарт хэдий хугацаагаар хөрөнгө оруулалтыг чиглүүлэх нь тодорхойгүй байгаа явдал нь хөрөнгө оруулалтын орчинд муугаар нөлөөлж байна гэж зөв тэмдэглэн хэлжээ.⁷⁷ Бүр муу нь 2004 оны 4-р сараас хүчин төгөлдөр болсон эдийн засгийн өсөлтийг хязгаарлах зорилготой үйлдвэрийн шинэ бодлого нь эрх барих байгууллагууд батлагдаад, хэрэгжилтийн шатандаа байгаа төслүүдэд хөндлөнгөөс оролцох шалтаг болох вий гэж Германы зарим хөрөнгө оруулагчид санаа зовниж байна.

⁷⁴ Мөн эх сурвалж. х. 8

⁷⁵ ДХБ-ын Дампингийн эсрэг үйл ажиллагааны хороо; Баримт бичиг G/ADP/ 12 (2003 оны 11-р сарын 11)

⁷⁶ ДХБ-ын Худалдааны Тойм, х. 87

⁷⁷ Мөн эх сурвалж.

Гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хязгаарлах, хориглох салбаруудыг жагсаасан шинэ каталог 2002 оны 4-р сарын 1–нд хүчин төгөлдөр болсон. Хятад ҮХЕХ-ийн хуваарьтай банк, даатгал, газрын тос олборлолт, нэмүү өртөг бүхий цахилгаан холбоо, түгээлт зэрэг зарим салбарыг нээхээр амлалт үүрэг авснаа хэрэгжүүлэх зорилгоор энэхүү шинэ каталогийг гаргасан. Дагалдах дүрмийн дагуу “хөхиүлэн дэмжих” салбаруудын төслүүдийн шугамаар капитал тоног төхөөрөмж импортолбол гаалийн татваргүй бөгөөд орцуудад ногдох НӨАТ-ын буцаан олголтыг хийх ажээ.

Хятад гадаадаас тусламж буюу технологи авч болох салбаруудыг, тухайлбал барилга, дэд бүтцийн байгууламжийн ажил, өндөр технологийн салбаруудын хөрөнгө оруулалтыг “хөхиүлэн дэмжиж” байна. Эдгээр салбаруудын хувьд зөвшөөрөл өгөх ажиллагаа нь төвлөрөөгүй, хөнгөрүүлсэн байдаг. Үүний зэрэгцээ өндөр технологийн төслүүд татварын урамшуулал хүртдэг.

Хятадын Засгийн газар “Хятадын үндэсний эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ”-нд нийцэхгүй салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарладаг. Хятадын эдгээр салбарт хөрөнгө оруулахын тулд гадаадын компаниуд Хятадын компаниудтай хамтарсан компани байгуулж, цөөнх хувьцаагаар эзэмшлээ хязгаарлах ёстой.

Зарим хөрөнгө оруулалтыг янз бүрийн шалтгаанаар “хориглодог”. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевиз, радиогийн салбаруудад гадаадын хөрөнгө оруулалт хийхийг хориглосон. Зарим ашигт малтмалын олборлолт, боловсруулалт нь хориотой салбарууд бөгөөд ийшээ хөрөнгө оруулалт хийх боломжгүй.⁷⁸

IV 3 Үйлчилгээний зах зээлийг нээх

IV 3.1 Ерөнхий хандлага

БНХАУ дахь үйлчилгээний зах зээлүүд үндэсний эдийн засгийн хамгийн их зохицуулалт, хамгаалалттай салбаруудын нэг юм. БНХАУ ДХБ-д элсэх хүртэл гадаадын үйлчилгээ үзүүлэгчид нь гадаадын Засгийн газруудыг зарим зөвшөөрөл хүсэгчдийн өмнөөс хүчтэй лоббидсоны хүчинд олгодог байсан зарим “туршилтын” тусгай зөвшөөрлийн нөхцөлийн дагуу үйл ажиллагаагаа хязгаарладаг байсан.

Хятадын ЭТП-д үйлчилгээний хэд хэдэн зах зээлийг нэлээд сайн нээхээр заасан. Хятадын Засгийн газрын улс төрийн зорилго нь хоёр талтай: Нэг талаар, одоогоор буурай хөгжилтэй үйлчилгээний салбаруудад гадаадын ноу-хаугийн их нөөцийг оруулснаар хөгжүүлэх, нөгөө талаар, уламжлалт үйлчилгээний салбаруудыг гадаадын илүү үр ашигтай компаниудаас хамгаалах ёстой. Энэхүү хандлагыг “хяналттай хамтын ажиллагаа” гэж тодорхойлж болох бөгөөд тус санаа ГХТХ болон ДХБ-д мэдэгдсэн маш олон янзын үйлчилгээг зохицуулсан хэдэн зуун дүрэм журамд туссан.⁷⁹

Хятадын тусгай амлалт үүргийн хуваарьт бүх салбарт хамаарах “хэвтээ” амлалт үүрэг болон үйлчилгээний өөр өөр зах зээлд үйлчлэх олон дүрэм журмыг хамарсан тул Хятадын үйлчилгээний салбар дахь Монголын сонирхол хязгаарлагдмал байдгийг харгалзвал үүнийг дэлгэрэнгүй авч үзэх боломжгүй бөгөөд шаардлагагүй юм. Тийм учраас “хяналттай хамтын ажиллагаа”-ны зарчим, үйлчилгээний салбар дахь гадаадын бизнесийн үйл ажиллагааны талаар Хятадын баримталдаг хоёр үзүүртэй бодлогыг тодотгон харуулах зарим жишээгээр тус

⁷⁸ Мөн эх сурвалж. х. 88

⁷⁹ ДХБ-ын Үйлчилгээний худалдааны хороо; Баримт бичиг S/C/W 218 (2002 оны 10-р сарын 22)

судалгааг хязгаарлана. Үүний дараа худалдаа, түгээлт, мөн тээвэрлэлт, материал техникийн хангамжийн үйлчилгээний нөхцөл байдлыг илүү дэлгэрэнгүй тодорхойлно. Монголын аж ахуйн нэгжүүд нь эдгээр салбарыг ирээдүйд сонирхож болно.

Хятадын тусгай амлалт үүргийн хуваарьт гадаадын компаниудын банк, үнэт цаасны үйлчилгээг газарзүйн бүс болон дотоодын хэрэглэгчдэд хүрэх боломжийн хувьд нэлээд их хязгаарлах талаар заасан боловч Засгийн газар нь гадаадын санхүүгийн том байгууллагууд л давж чадах нэмэлт саад тотгорыг түргэн бий болгожээ. 2003 оны 12-р сард нийтлэгдсэн банкны дүрэм, журмуудад Хятадад байгуулах салбар бүрийн эргэлтийн хөрөнгө 600 сая юаниас доошгүй байхаар заасан бөгөөд салбар бүр бусад салбараас тусдаа янз бүрийн итгэлцүүрийг (төлбөрийн чадвар, их эрсдэлтэй учрах гэх мэт) хангасан байх ёстой. Цаашилбал, ямар ч үед эргэлтийн хөрөнгийн 25%-ийг Төв банкнаас томилсон орон нутгийн нэгэн банканд хийх ёстой. Дээрх мөнгийг хүлээн авах эрхтэй банкны жагсаалтыг Хятадын банкаар хязгаарласан нь ҮХЕХ-ийн үндэсний нөхцөлийн дүрмийг зөрчиж байгаа мэт санагдана. Гадаадын банк нэгэнт салбар нээсэн бол дахин нэг салбар нээхээсээ өмнө дор хаяж нэг жил хүлээх ёстой. Ийм хязгаарлалт хийнэ гэж төлөвлөөгүй байсан тул энэ нь Хятадын авсан амлалт үүрэгтэй илэрхий зөрчилдөж байна. Цаашилбал, Хятад орон нутгийн валютын үйл ажиллагаанд гадаадын банкнуудын оролцох оролцоог хатуу хязгаарласаар байна. Эдгээр байгууллага нь орон нутгийн үйлчлүүлэгчдээс юанийн хадгаламж авах эрхгүй байгаа цагт банк хоорондын зах зээлээс юань цуглуулах эрхийг хязгаарласан нь гадаадын банкнууд юанийн багц бий болгоход саад тотгор учруулах болно. Энэ дүрэм гадаадын банкнуудад л хамаарах учраас Үндэсний нөхцөлийн дүрмийг зөрчсөн бас нэг зүйл болсон.⁸⁰

Ижил төстэй саад тотгор нь даатгалын салбарын үйл ажиллагаанд саад учруулдаг.⁸¹ Хятад амь насны болон амь насны бус даатгалын салбаруудаа аажмаар нээх үүрэг амлалт авсан боловч капиталын шаардлага хэтэрхий өндөр байна. Нэг төв байр, гурван салбар бүхий үндэсний тусгай зөвшөөрөл авахад 500 сая юанийн хөрөнгө оруулахыг шаарддаг бол нэг төв байр, хоёр салбар бүхий бүсийн тусгай зөвшөөрөл авахад 200 сая юанийн хөрөнгө оруулахыг шаарддаг. Компани нэгэнт үндэсний тусгай зөвшөөрөл авсан бол нэмэлт салбаруудад 50 сая юанийн нэмэлт хөрөнгө шаардагдана. Олон улсын шүүмжлэлийн үр дүнд Хятадын даатгалын зохицуулах хороо үндэсний тусгай зөвшөөрлийн хөрөнгийн шаардлагыг 200 сая юань, салбар байгуулахад шаардах хөрөнгийн хэмжээг 20 сая юань болгон бууруулах шинэ журмын төсөл боловсруулснаа зарласан.⁸²

Хятадын Засгийн газар нь гадаадын өрсөлдөгчдийг зайтай байлгахад ДХБ-ын дүрэм болон амлалт үүргийг үзэл санааных нь эсрэг хэрхэн хэрэглэж байгаагийн нэг жишээ бол барилгын салбар юм. Өнөөг хүртэл гадаад улс орны барилгын компаниуд "гадаадын гүйцэтгэгч"-ээр бүртгүүлж, шаардлагатай үед нэлээд боловсронгуй ноу-хау шаарддаг барилгын нарийн төрөлжсөн томоохон төслүүдэд оролцох боломжтой байлаа. ДХБ-д элсэн орсны дараа Хятадын Барилгын болон Худалдааны яамд "гадаадын гүйцэтгэгч"-ийн статусыг устгаж, Хятадын ДХБ/ҮХЕХ-ийн амлалт үүргийн байрыг нь сольж, гадаадын барилгын компаниудад Хятадад гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж (ГДХОААН) байгуулах боломжийг нээхийн сацуу тус зах зээлийг гадаадын ихэнх компанийн хувьд үр дүнтэй хаасан "зэрэг тогтоох тогтолцоо"-г нэвтрүүлсэн шинэ журам (113, 114 тоот захирамжууд) гаргасан. ГДХОААН байгуулах цорын ганц зам бол хамгийн доод зэрэглэлтэйгээр, маш жижиг төслөөр эхлэх явдал бөгөөд ийм

⁸⁰ ЕХ-Комисс, ЕХ-ны Төвч Тойм (хэвлэгдээгүй) х. 12/13; АНУ-ын Худалдааны Тойм, мөн эх сурвалж. х. 77/78 Мөн „Хятад дахь Европын Бизнес“-ийг үзнэ үү, мөн эх сурвалж. х.44- 48

⁸¹ Хятад дахь Европын Бизнес, х.90 - 96.; АНУХТ, мөн эх сурвалж. х.76

⁸² АНУ-ын Худалдааны Тойм, мөн эх сурвалж. х. 76

хэмжээний төсөлд гадаадын компаниуд өрсөлдөх боломжгүй учраас тэдний зорилгод нийцдэггүй. Гэрээний хэмжээ нь Хятадад бүртгүүлсэн хөрөнгөөс тав дахин их байхаар хязгаарлагдана. Энэхүү дэглэм нь үндэслэлгүй хөрөнгө, хүн хүч шаардсанаар гадаадын компаниудыг олон тусгай зөвшөөрөл хүсэх сонирхолгүй болгодог тул тэднийг Хятадын зах зээлд нэвтрүүлэхгүй байх нэг хэрэгсэл болжээ. Тэдний бизнесийн цар хүрээ БНХАУ-ын ҮХЕХ-ийн амлалт үүргийн дагуу ГДХОААН-үүдэд нээсэн дөрвөн төрлийн төслөөр л хязгаарлагдана. Энэ нь Хятадын барилгын зах зээлийн хэдхэн хувийг л эзэлнэ (үндсэндээ олон улсын санхүүжилттэй, өндөр технологийн төслүүд). Хамтарсан компаниудын хувьд хамгийн доод зэрэглэлийн түншийн зэрэглэл нь зарим төслийн тендерт оролцох эрхийн хэмжүүр болдог бөгөөд энд учир шалтгаан, логикийг хэрэгсдэггүй. Энэ нь Хятадын хамтарсан компанийн түншийг сонгоход дэ-факто хязгаарлалт тавьж байгаа мэт санагдаж байна. Ийнхүү түншээ сонгох нь ДХБ-д элссэн тухай АХТ-д заасан Хятадын үүргийн дагуу чөлөөтэй байх ёстой.⁸³

ДХБ-ын өмнө авсан төлөвлөгөөт амлалт үүргээ зөрчин гадаадын компаниудыг ялгаварласан буюу зах зээлд нэвтрэх боломжийг хязгаарласан дээрхтэй төстэй дүрмүүд цахилгаан холбоо, автомашины санхүүжилт, мэргэжлийн үйлчилгээ зэрэг бусад салбарт байдаг.⁸⁴

IV 3.2 Худалдаа ба түгээлт

Дотоодын худалдааг зохицуулдаг журам ГХТХ-ийн гадаад худалдааны наймаачны статустай холбоотой заалтуудыг нөхөн гүйцээдэг тул дэлгэрэнгүй авч үзнэ.⁸⁵ Шилжилтийн дахин хянах механизмын явцад Хятадын төлөөлөгчид худалдааны эрхэд (тухайлбал экспорт, импортын эрх) Хятад дотор түгээх эрх багтахгүй гэдгийг тод ойлгуулсан.⁸⁶ Гэхдээ дотоодын зах зээл дээр борлуулах эрхгүйгээр бараа импортлох эрх, Хятадаас худалдаж авах боломжгүй байж бусад оронд бараа экспортлох эрх гэдэг нь дамаргүй хонхтой адил санагдаж байна. Үнэн хэрэгтээ энэхүү дүрэм нь олон жил оршсоор ирсэн зарчим дээр үндэслэсэн. Энэ зарчмын дагуу гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд өөрийнхөө үйлдвэрлэлд л зориулж түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, техник тоног төхөөрөмж авчирч, зөвхөн өөрийнхөө бүтээгдэхүүнийг л экспортлох боломжтой байсан. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын худалдааны үйл ажиллагаа эрхлэх эрхийг де-факто хассан хязгаарлалт нь ГХТХ-ийн төслийн нэг хэсэг байсан бөгөөд ДХБ-ын хэд хэдэн дүрэм, тухайлбал Үндэсний нөхцөлийн зарчим, худалдааны эрхийн талаар авсан амлалт үүрэг (ЭТП-ын 5-р заалт), бөөний болон түгээлтийн үйлчилгээний салбарыг нээхээр ҮХЕХ-ийн дагуу авсан тусгай амлалтуудыг улайм цайм зөрчсөн тул гадаадын бизнесийн хүрээнийхэн үүнийг ширүүн шүүмжилсний дараа л үүнийг төслөөс хассан.

ЭТП-д Хятад ДХБ-д элсэн орсноосоо хойш 3 жилийн дотор (буюу 2004 оны 12-р сарын 11 гэхэд) үндэсний нөхцөл, бөөний худалдаа эрхэлж, засвар үйлчилгээ зэрэг зуучлал төлөөлөгчийн үйлчилгээг тухайн нутаг дахь салбараараа дамжуулан үзүүлэх гэсэн гадаадын аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэх боломжийг хязгаарласан дүрэм журмаа арилгана гэсэн амлалт үүрэг авсан. Үүний зэрэгцээ Хятадын Засгийн газар эдгээр салбарыг либералчилах хэд хэдэн арга хэмжээг авсан нь банк, даатгал, барилга гэх мэт салбарт ажиглагдаж болно. Худалдааны хэмжээ, бүртгэлтэй хөрөнгө, урьд өмнөх бизнесийн туршлага зэрэгтэй холбоотой янз бүрийн хязгаарлалтууд бий. Энэ нь гадаадын олон компанийг, ялангуяа ЖДҮ-үүдийг бизнесийн тусгай зөвшөөрөл хүсэх сонирхолгүй

⁸³ ЕХ-Комисс, мөн эх сурвалж. х 5/6

⁸⁴ АНУ-ын Худалдааны Тойм, х. 75 f.

⁸⁵ Дээрхийг үз х. 26/27

⁸⁶ ДХБ-ын Барааны худалдааны зөвлөл; Баримт бичиг G/L/ 664 (2003 оны 12-р сарын 4); мөн „Хятад дахь Европын Бизнес“-г үзнэ үү, мөн эх сурвалж. х. 194 - 206

болгож, бүр боломжгүй болгож байна.⁸⁷ ШДХМ-ын явцад худалдааны гол түншүүдээс эсэргүүцсэний үр дүнд, Үндэсний ардын их хурлын Байнгын хороо ГХТХ-ийн дагуу “Худалдааны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай захиргааны дүрэм”-ийг баталсан бөгөөд 2004 оны 6-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болно.

Захиргааны дүрмүүдийн хорин есөн зүйл дараах асуудлыг тусгасан.⁸⁸ Үүнд:

- “Гадаадын хөрөнгө оруулалттай арилжааны аж ахуйн нэгж байгууллагын” бизнесийн цар хүрээ (3-р зүйл);
- Арилжааны аж ахуйн нэгж, дэлгүүр байгуулахад биелүүлэх ёстой нөхцөлүүд (7, 8-р зүйл);
- Арилжааны аж ахуйн нэгжүүдийн явуулж болох үйл ажиллагаанууд (9-р зүйл)
- Шалгалт, зөвшөөрлийн ажиллагаа (10-15-р зүйл);
- Зарим бүтээгдэхүүнтэй холбоотой арилжааны үйл ажиллагааны хязгаарлалтууд (16-18-р зүйл);
- Хамтарсан компани болон гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах цагийн хуваарь (21, 22-р зүйл);
- Гонконг, Макао, Тайваны хөрөнгө оруулагчид арилжааны аж ахуйн нэгж байгуулах.

Гадаадын хөрөнгө оруулалттай арилжааны аж ахуйн нэгжээр зөвшөөрөгдөж, бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд л (хамтарсан компани буюу ГДХОААН-ийн аль ч хэлбэрээр) дараах бизнесийн үйл ажиллагааг эрхэлж болно. Үүнд:

- Гэрээний үндсэн дээр урамшууллын хувь авч, бараа таваар борлуулалтын агентлаг, брокер, үнэ хаялцуулагч, бусад бөөний худалдаачдаар дамжуулан урамшууллын хувь бүхий зуучлал, бараа таваарыг бусдад борлуулах, холбогдох үйлчилгээг үзүүлэх,
- Бөөний худалдаа: Жижиглэн худалдаачдад, үүний дотор үйлдвэр, арилжаа, байгууллагын хэрэглэгчид, бусад бөөний худалдаачдад бараа таваар борлуулах, холбогдох үйлчилгээг үзүүлэх,
(Зөвшөөрөх үйл ажиллагаанд дараах үйлчилгээ орж болно: Барааны бөөний худалдаа, урамшууллын хувь бүхий зуучлал, үнэ хаялцах оруулахгүй – барааны импорт, экспорт, бусад туслах бизнес),
- Жижиглэн худалдаа: Хувь хүмүүс болон бүлгүүдийн хэрэглээнд зориулж телевиз, утас, шуудангийн захиалга, интернэт, борлуулалтын автомат машин зэргээр дамжуулан эсвэл тогтмол байршлуудад бараа таваар борлуулах, холбогдох үйлчилгээ үзүүлэх,
(Зөвшөөрөгдөх үйл ажиллагаанд дараах үйлчилгээ орж болно: Барааны жижиглэн худалдаа, импорт, дотоодын барааг экспортлох зорилгоор худалдан авах, бусад туслах бизнес)
- Франчайз: Лиценз ашиглалтын төлбөр, урамшуулал авахын тулд гэрээний үндсэн дээр бусдад лиценз эзэмшигчийн худалдааны тэмдэг, дэлгүүрийн нэр, үйл ажиллагааны загвар зэрэг бусад зүйлийг ашиглуулах франчайз олгох.

Цаашилбал, урьд өмнө нь шаарддаг байсан хөрөнгө болон худалдааны хамгийн доод хэмжээг Захиргааны дүрмээс хассан бөгөөд БНХАУ-ын Компанийн тухай хуулийн дагуу (23-р зүйл) Хятадын болон гадаадын хөрөнгө оруулалттай

⁸⁷ АНУ-ын Худалдааны Тойм, мөн эх сурвалж. х. 78

⁸⁸ Ванг Жинг ХХК (Гонконг)-ийн нийтэлсэн дүгнэлтийн дагуу, Хуулийн сонин, Дугаар 4, 2004 оны 4-р сар

компаниудад тавьдаг бүртгэлтэй капиталын хамгийн доод хэмжээ онолын хувьд дараах байдалтай байна: Үүнд:

- хэрэв компани барааны бөөний худалдаа голлон эрхэлдэг бол 500,000 юань;
- хэрэв компани барааны жижиглэн худалдаа голлон эрхэлдэг бол 300,000 юань;
- хэрэв компани шинжлэх ухаан, техникийн хөгжил, зөвлөх болон үйлчилгээ голлон эрхэлдэг бол 100,000 юань

Гэхдээ практикт капиталын шаардлага нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад нэгэн ижил өндөр байна. Хамтарсан компанийн тухай хуулиар бүртгэлтэй капитал, нийт хөрөнгө оруулалтын тодорхой харьцаануудыг шаардана. Энэ нь улмаар Компанийн тухай хуульд заасан хамгийн бага хэмжээний хөрөнгө хангалтгүй байх үр дүнд хүргэж болно.

Бусад шаардлагууд гол төлөв журмын шинжтэй. Эдгээрээс үүдэн аж ахуйн нэгж нь хамтарсан компанийн гэрээндээ буюу арилжааны аж ахуйн нэгж байгуулсан дүрэмдээ борлуулах бараа таваарын жагсаалтыг оруулах хэрэгцээг цохон хэлмээр байна. Цаашилбал, зарим төрлийн бараа, тухайлбал ном, сонин, сэтгүүл, шатахуун түгээгүүрийн жижиглэнгээр зарсан шатахуун, эм, машин, хөдөө аж ахуй, холбогдох бүтээгдэхүүн зэрэг нь бусад дэлгэрэнгүй дүрэм, журамд хамрагдсаар байна. ЭТП-д заасны дагуу тусгай бодлого хэрэгжих чиглэлээр (тухайлбал автомашин) эдгээр нөхцөл нь улсын худалдаа, тусгай эрх олгосон худалдаанд хамаарах бүтээгдэхүүнтэй холбоотой.

Явуулах гэж байгаа бизнесийн үйл ажиллагааны хэмжээ, газарзүйн байршлаас хамааран зөвшөөрөл өгөх байгууллага нь ХЯ буюу мужийн гадаад худалдааны комиссууд байна. Том их дэлгүүр буюу супер маркетын сүлжээ зэрэг том бизнес болон нэгээс олон мужид явуулах бүх үйл ажиллагаанд ХЯ-ны зөвшөөрөл шаардлагатай. Бүх томоохон төслийн хувьд ХЯ хариуцаж байх шиг байна.⁸⁹

Захиргааны дүрэм нь гадаад худалдаа, дотоод худалдааны бүтцийн хооронд өнөөг хүртэл байхгүй байсан холбоосыг бий болгож байна. Хятадын зах зээл дээр импортын бараа борлуулж, экспортлох зорилгоор Хятадын барааг худалдан авдаг зэрэг бүрэн үйл ажиллагаа явуулдаг гадаад худалдааны компанид дараах зүйл шаардагдана. Үүнд:

- ГХТХ-ийн 8-13-р зүйлийн дагуу бүртгүүлэх,
- “Арилжааны салбарууд дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай захиргааны дүрэм”-ийн 10-15-р зүйлүүдийн дагуу арилжааны аж ахуйн нэгжийн хувьд зөвшөөрөл авах.

Гадаад худалдааны хязгаарлагдмал эрхтэй (өөрийн хэрэгцээнд зориулан импортлох, өөрийн бүтээгдэхүүнээ экспортлох), одоо өөрийн түгээх сувгийг байгуулахыг зорьж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрлэлийн компаниуд бизнесийн цар хүрээгээ өргөжүүлэхийн тулд давхар процессоор дахин явахаас өөр аргагүй. Үүнтэй адил хэрвээ компани нь зөвшөөрөлтэй, бизнесийн тодорхой зүйлсийг өөрчлөхөөр шийдвэл бизнесийн цар хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа удирдах байгууллагуудаас зөвшөөрөл авах шаардлагатай. Ийнхүү худалдаа, түгээх үйлчилгээний салбарын либералчилал нь бичиг цаас, хүнд суртлын ажиллагаа, бизнесийн шийдвэрийн уян хатан байдал алдагдах зэргийн хувьд жаахан зардалтай тусна.

⁸⁹ Ванг Жинг ХХК-ийн мөн эх сурвалж.

ГХТХ-ийн нэгэн адил Захиргааны дүрэм цаасан дээр бичсэнээрээ бол дажгүй боловч түүнийг эрх бүхий байгууллагууд хэрхэн хэрэгжүүлэхийг харах л үлдлээ. Гадаадын хөрөнгө оруулалтын комиссын авсан мэдээллээс үзэхэд өргөдлийг 10 хоногийн дотор шийдэх бөгөөд хэрэв Захиргааны дүрмийн нөхцөлүүдийг хангаж байвал зөвшөөрлийг шууд олгоно. Энэ дүрэмд агуулагдсан зүйлсийн цаад учир шалтгааныг харгалзан үзсэн бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр байхгүй байна. Тэгэхээр ажиллагаа нь ГХТХ-ийн 8-р зүйлийн дагуу компанийн гадаад худалдааны наймаачнаар бүртгүүлэх процесстой ижил төстэй.⁹⁰

IV 3.3 Тээвэрлэлт ба материал техникийн хангамжийн үйлчилгээ

Урьд өмнө нь тээвэрлэлт ба материал техникийн хангамжийн салбарууд хатуу зохицуулах хязгаарлалт, өндөр өртөгтэй байж, Засгийн газрын хөрөнгө оруулалттай зуучлагчид давамгайлж, зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг хязгаарлаж байсан. Энэхүү салбарыг хариуцсан Засгийн газрын олон байгууллагуудаас дурдвал: Харилцаа холбооны яам, Төмөр замын яам, ХЯ, ҮШХК, Хятадын Иргэний агаарын тээврийг удирдах газар болно. Давхацсан харьяалал, зөвшөөрөл авахад тавих олон багц шаардлага, тодорхойгүй журам зэрэг нь зах зээлд нэвтрэх боломжид саад учруулж байна. Дотоодын компаниуд тухайн салбаруудад дангаар ноёрхохын тулд Засгийн газрын хэлхээ холбоо, хөрөнгө оруулалтыг ашиглаж ирсэн. Гадаадын тээврийн компаниуд хуурай газрын боомтуудад салбараа нээх боломжгүй байсан.⁹¹

Гэхдээ БНХАУ-ын ДХБ-ын өмнө авсан амлалт үүрэг нь тээвэрлэлт, материал техникийн хангамжийн үйлчилгээний салбарыг гадаадын үйлчилгээ үзүүлэгчдэд өргөн нээхийг дэмжиж байна. Хятадын өөрийн шинэчлэлийн бодлого ч мөн ийм чиглэлтэй байгаа. ДХБ-д элссэнээс хойш 3-6 жилийн дараа гадаадын компаниуд нь агуулах, автозам, төмөр замын ачаа тээвэр, тээвэр зуучийн компаниудад чөлөөтэй хөрөнгө оруулах боломжтой болно. Үүний зэрэгцээ зарим хязгаарлалт байлаа. Тухайлбал, автозам, төмөр замын тээврийн компаниудын хувьд 49%-ийн гадаадын хөрөнгө оруулалттай, тээвэр зуучийн агентлагуудын хувьд 50%-ийн гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан компаниуд байгуулахыг зөвшөөрч байв. Сүүлийнх нь нэг саяас багагүй америк долларын бүртгэлтэй хөрөнгийг нэмж шаарддаг бөгөөд үйл ажиллагаа явуулах хугацаа нь 20 жилээс хэтрэхгүй байна.

2002 оны 11-р сард Хятад автозамын тээвэрлэлтэд гадаадын эзэмших хувийг 50%-иас дээш байхыг зөвшөөрсөн журмыг гаргасан. Хятад мөн элсэн орсноосоо хойш нэгж жилийн дотор 50%-иас дээш гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан компаниудыг сав, баглаа боодлын үйлчилгээ, агуулах, хадгалах, тээвэр зуучийн үйлчилгээний салбарт оруулахыг зөвшөөрсөн журмыг гаргах үүрэг авсан. Үүний дагуу эдгээр салбарт 75%-ийн гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан компаниудыг оруулах цагаа олсон журмуудыг гаргажээ.

2002 оны 1-р сарын 1-нд БНХАУ-ын олон улсын далайн тээвэрлэлтийн журам хүчин төгөлдөр болжээ. 2002 оны 6-р сард гарсан хэрэгжүүлэх дүрмүүдэд олон янзын асуудал хөндсөн. Тухайлбал, хөлөг онгоцгүй усан замын тээврийн компани нь Хятадын банканд 800,000 юанийн бэлэн мөнгө хийх шаардлага тавьсан боловч энэ мөнгөө яаж хэрэглэж ашиглах тодорхой дүрэм байхгүй байсан.

2002 оны 7-р сард ХЯ-ны өмнө байсан ХЭЗХАЯ нь Гадаадын хөрөнгө оруулалттай материал техникийн хангамжийн компанийг туршилтын бүсүүдэд байгуулах тухай мэдэгдэл гаргасан. Энэхүү мэдэгдлээр гадаадын хөрөнгө оруулалттай материал-

⁹⁰ 2004 оны 9-р сарын 9-нд Франкфурт/М-д болсон уулзалтын үеэр мэдээлэл өгсөн.

⁹¹ АНУ-ын Худалдааны Тойм, мөн эх сурвалж. х.80 Дэлгэрэнгүй мэдээлэл үзье гэвэл Хятад дахь Европын Бизнес, х. 210 f.

техникийн хангамжийн компаниудыг (50 хүртэл хувь нь гадаадын эзэмшилд байх, 5 сая ам.долларын бүртгэлтэй капиталтай байх) хэд хэдэн оноосон хотод байгуулах боломжийг өгсөн.⁹²

IV 4 Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлуудын тухай дүрэм

ДХБ-д элсэхээсээ өмнө Хятад ОӨЭХХА-ын тухай хэлэлцээрийг дагаж мөрдөхийн тулд ОӨЭ-ийн тухай хууль тогтоомж, хэрэгжүүлэх дүрэм, үүний дотор патент, худалдааны тэмдэг, зохиогчийн эрхтэй холбоотой хууль тогтоомж, дүрмээ өөрчилж эхэлсэн.⁹³

Гэхдээ ГХТХ-ийн 29-31-р зүйлүүд энэхүү эмзэг сэдвийг сонин байдлаар тусгасан бөгөөд уншигч дараах стандарт нөхцөл байдал, асуудал бэрхшээлийг үүсгэж байна гэсэн бодолтой үлдэж байна. Үүнд:

- оюуны өмчийн эрхийг зөрчсөн “импортын (!) бараа” (29-р зүйл),
- (Хятадын) лиценз эзэмшигчдийн эсрэг хязгаарлагдмал практик хэрэгжүүлэгч (гадаадын) ОӨЭ эзэмшигчид (30-р зүйл),
- БНХАУ-ын хуулийн этгээд, байгууллагуудыг ОӨЭ-ийн зөрчлөөс хангалттай хамгаалж чадахгүй гадаад улс орон буюу бүс нутгууд (31-р зүйл)

Хятадад бараа, бүтээгдэхүүнийг хуурамчаар их хэмжээгээр үйлдвэрлэж, бусад оронд гаргадаг нь асуудал, бэрхшээл учруулж байгаа юм биш үү гэсэн асуулт тавихад ХЯ нь ГХТХ-ийн 29-р зүйлийн текстийг найруулгын алдаа гэж хэлсэн тайлбараар амархан засварлах боломжтой гэж тайлбарласан.⁹⁴ 29-р зүйлийг үнэхээр “импорт, экспортын” бүтээгдэхүүний тухай ярьж байна гэж ойлгох хэрэгтэй. Гэхдээ хилийн цэг дээр хууль хэрэгжүүлж байгаа доод тушаалын түшмэд хуулийг үг үсэгчлэн хэрэгжүүлэхийн оронд ийм үзлийг дэмжиж болох юм.

Бүхэлдээ хэрэгжилт их хангалтгүй хэвээр байна. 2003 онд Хятад дахь ОӨЭ-ийн зөрчил нь олон салбар, үүний дотор кино, хөгжим, хэвлэн нийтлэл, програм хангамж, эм, химийн бодис, мэдээллийн технологи, хэрэглээний бараа, цахилгаан тоног төхөөрөмж, автомашины сэлбэг ба үйлдвэрийн бусад бүтээгдэхүүнд нөлөөлсөөр ирсэн. Төрийн Зөвлөлийн Боловсруулалт Судалгааны Төвийн 2003 оны 7-р сарын тайланг үзэхэд Хятадын хуурамчаар үйлдсэн барааны зах зээлийн үнэ 19 сая ам.доллараас 24 сая ам.доллар хүртэл өсжээ.⁹⁵

БНХАУ-ын ОӨЭ-ийн тухай хуулиудад захиргааны байгууллагын хэрэгжилт, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, мөнгөн хохирлыг нэхэмжилсэн иргэний нэхэмжлэл зэргийн талаар заасан. Гэхдээ Хятадын яам, агентлагуудын хооронд ажлын уялдаа холбоо байхгүй, орон нутгийн протекционизм, авилгал, хэрэг үүсгэж, мөрдөн шалгаж, яллахад босго өндөр, сургалт байхгүй, захиргааны шийтгэл хангалтгүй байгаагаас хэрэгжилтийн ажилд саад тотгор учруулж байна.

Хэрэгжилтийн явцад гарсан томоохон дутагдлууд. Үүнд:

- ОӨЭ-ийн зөрчилтэй тэмцэх дүрэм болох Захиргааны хэрэгжилтийн хууль нь зөрчигчдийг айлгахгүй байна. Учир нь ийм зөрчил ихэнхдээ хэтэрхий бага торгууль төлснөөр л дуусдаг. Эрх барих байгууллагууд торгуулийг жинхэнэ бүтээгдэхүүний үнэ цэнээр бус хуурамчаар үйлдсэн буюу хууль бусаар ашигласан барааг зарж байсан үнэ дээр үндэслэн тогтоодог. Цаашилбал,

⁹² Мөн эх сурвалж.

⁹³ АНУ-ын Худалдааны Тойм, мөн эх сурвалж. х.72 f.(73)

⁹⁴ Энэхүү мэдээллийг 2004 оны 8-р сарын 26-нд зохиогчтой ярилцлага хийсэнтэй холбогдуулан өгсөн

⁹⁵ АНУ-ын Худалдааны Тойм, мөн эх сурвалж. х. 73

хууль бус бараа бүтээгдэхүүнийг хадгалж байсныг харуулсан нотлох баримт нь тухайн хүн эдгээр барааг борлуулах санаатай байсан гэдгийг нотлоход хангалтгүй ажээ. Торгуулийг яг зарсан барааны үндсэн дээр л тооцоолдог. Захиргааны эрх барих байгууллагууд нь хэргийг эрүүгийн мөрдөн байцаалтад шилжүүлэх нь ховор. Үүний улмаас хууль зөрчигчид бараагаа хураалгах, торгууль төлөх зэргийг бизнес эрхлэх зардал гэж тооцдог ажээ.

- Худалдааны тэмдгийг бизнесийн цар хүрээтэйгээр санаатай хуурамчаар үйлдэж, хууль бусаар ашиглах тохиолдолд ОӨЭХХА эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, гэм хор арилгах хэрэглүүрийг шаарддаг. Гэвч БНХАУ-ын эрх баригчид хариуцлагын өндөр босгыг давсан үед л (компаниудын хувьд 200,000 юань, хувь хүмүүсийн хувьд 50,000 юань) цөөн тооны хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулсан. Энэхүү шаардлагыг хангах нь ховор. Учир нь агуулахад байх бүтээгдэхүүнийг тооцдоггүй. Бүтээгдэхүүнийг гудамжинд ихэвчлэн бага багаар нь зардаг бөгөөд борлуулагч нарт мэдээж хэрэг ийм борлуулалтын бүртгэл ерөөсөө байдаггүй. Хуурамчаар үйлдсэн болон хууль бусаар ашигласан бараа, бүтээгдэхүүнийг санаатай үйлдвэрлэх, хадгалах, түгээх, хэрэглэх нь одоо хүртэл Хятадад эрүүгийн хуулиар шийтгэгддэггүй.
- Захиргааны болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дутагдлыг мэдсэн Хятадын болон гадаадын оюуны өмчийн эрх эзэмшигчдийн иргэний нэхэмжлэл гаргах нь нэмэгдсэн. Гэхдээ гадаадын компаниуд Хятадын хууль тогтоомжийг шүүхүүд нь нэг мөр, шударга хэрэгжүүлж чадахгүй байна гэж голлолдог билээ. Шүүгчид шаардлагатай сургалтад суугаагүй байдаг бөгөөд нотлох баримт, шинжээч-гэрч, нууц мэдээллийг хамгаалахтай холбоотой шүүхийн дүрмүүд тодорхой бус, үр дүнгүй байдаг. Патенттай холбоотой хэргүүд шийдэгдтэл 4-7 жил болох нь энүүхэнд.⁹⁶

IV 5 Хятад дүрэм журмыг хэрхэн дагаж мөрдөж байгаа тухай товчхон

ДХБ-д элссэн эхний жилийн турш Хятад олон бүтээгдэхүүний тарифын түвшин, импортын квотод хамаарах барааны тоог маш их бууруулж, Хятадын аж ахуйн нэгжүүдийн худалдааны эрхийг өргөжүүлж, тусгай зөвшөөрөл олгох ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэв.

Гэхдээ хоёр дахь жилийн турш (2003) Хятад төлөвлөгөөний дагуу тарифын түвшинг улам бууруулж, бусад хэрэгжилтэд дэвшил гаргасан боловч хүнд суртлын инерц, эмзэг салбаруудыг хамгаалах хүсэл ДХБ-ын гишүүн байсан эхний жилд авсан хүчийг алдагдуулахад хүргэж байна.⁹⁷

Дүрэм журмыг дагаж мөрдөхтэй холбоотой асуудлуудыг дараах байдалтай хураангуйлж болно. Үүнд:

Гадаад худалдааны дэг журмыг бүрдүүлэгч хангалтгүй хууль тогтоомж: ГХТХ-ийн зарим заалт болон дампингийн эсрэг, татаасын эсрэг шалгалтын тухай дүрмүүд нь ДХБ-ын хэлэлцээрүүдтэй илэрхий зөрчилдөхгүй, бусад нь хуулийг хэрхэн зүй зохистой хэрэгжүүлэх талаар эрх баригчдад хангалттай чиглэл өгч чаддаггүй. Энэхүү хандлагыг санаатайгаар баримталдаг эсэх нь одоогоор сэжиг таавар төдий юм.

Ил тод байдал байхгүй: Тодорхой бус, жигд бус хэрэгждэг хуулийн заалтууд, ялангуяа техникийн стандарт, импортын тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах, тарифын түвшний квот зэрэг чиглэлийн хуулийн заалтуудыг нухацтай анхаарахад хүргэж байна. Хятадын татаас, олон шатлалт үнийн тогтолцоог

⁹⁶ Мөн эх сурвалж. х. 74/75 Мөн „Хятад дахь Европын Бизнес“-г үзнэ үү, мөн эх сурвалж. х. 98 - 118

⁹⁷ АНУ-ын Худалдааны Тойм, мөн эх сурвалж. х. 57 f.

арилгах талаар ДХБ-ын дүрэм журам, өөрийн амлалт үүргээ биелүүлж ирсэн байдал нь муу байна. Тодруулга, мэдэгдэл яаралтай хэрэгтэй байна.

Олон салбарт ХЗДМГТ, тохирлын үнэлгээний төвөгтэй журам, Хятадын тусгай амлалт үүргийн хуваарьт ороогүй янз бүрийн үйлчилгээний зах зээлд оруулах гадаадын хөрөнгө оруулалтад тогтоосон хязгаарлалт зэрэг импортын шинэ саад тотгорууд олон салбарт гарч ирснээр гадаадын компаниудад Хятадын зах зээлд ажиллахад хүндрэл учруулж байна.⁹⁸ Улсын мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэд хэдэн үндэсний албан тушаалтнууд Хятад импортыг хязгаарлахын тулд техникийн стандартаа ашиглах ёстой гэж ил тод мэдэгдсэн нь санаа зовоож байна.⁹⁹

IV 6 Дүрэм журмыг цаашид дагаж мөрдөх шаардлагатай урьдчилсан нөхцөл болох улс төрийн хүсэл зориг, практик чадавх

ДХБ-ын дүрмийг дагаж мөрдөхийн тулд Хятад шиг ийм их зүйлийг өөрчлөхөөр сайн дурын үндсэн дээр амласан улс дэлхийн түүхэнд гарч байгаагүй.¹⁰⁰ ДХБ-ын гишүүнээр элссэнээс хойш хоёр жил хагас болсны дараа Хятад ЭТП-д заасан том зорилгуудаа хэрэгжүүлэх хүсэлтэй бөгөөд боломжтой эсэх тухай асуулт одоо ч гэсэн сэжиг таамаг төдий байна.

ДХБ-д БНХАУ элссэн нь Хятадын “хуучинсаг үзэлтнүүд” болон “шинэчлэгчдийн” хооронд маргаан дэгдээсээр байна. “Шинэчлэгчид” ДХБ-д гишүүнээр элссэний ач холбогдол, үүнээс гарч ирэх улс төрийн болоод эдийн засгийн үр ашгийг цохон тэмдэглэж байгаа бол “хуучинсагууд” БНХАУ-ын эдийн засаг ширүүн өрсөлдөөн, дотоодын задрал, гадаадын хяналт зэрэг бэрхшээлтэй тулгарна гэж сануулж байна. Гарч болох сөрөг нөлөөнүүд гэвэл хямд импортын бараанаас болж ажилгүйдэл өсөх, ялангуяа хөдөөд ажилгүйдэл өсөх, олон УӨҮГ задарч гадаадын өрсөлдөгчидтэй өрсөлдөх чадваргүй жижиг үйлдвэрүүд болох, үр ашиггүй үйлчилгээний салбарууд гадаадынхны давамгайлалд автах зэрэг болно. “Шинэчлэгчид” Хятадын бүтээгдэхүүнд олон улсын илүү нээлттэй зах зээлийн өгч болох ашиг болон гадаадын хөрөнгө оруулалт, төрийн сайн санаа зэрэг бусад боломжуудаас гарч ирэх ашигтай талуудыг хэлдэг.¹⁰¹

Хятад ДХБ-д элсэн орохоор шийдсэн нь тус улс тухайн байгууллагын дүрмийг дагаж мөрдөх сорилыг давахад бэлэн байгааг харуулж байна. Гэхдээ дүрэм дагаж мөрдөж байгааг үнэлж дүгнэнэ гэдэг хэцүү ажил. Дүрэм нь тийм их тодорхой бус, өөр өөр тайлбар гаргах боломжтой нөхцөлд дагаж мөрдөх гэж юуг хэлээд байгаа болох талаар улс хоорондоо маргалддаг.¹⁰²

Цаашилбал ДХБ-ын дүрмийг Хятад дагаж мөрдөхөд бэлэн байгаа боловч ийнхүү дагаж мөрдөх чадавхтай юу?

Энэхүү нөхцөл байдлыг шийдвэрлэх хамгийн ирээдүйтэй арга зам нь гурав байж болно: Дүрэм дагаж мөрдөж байгаа эсэхийг аль болох ойроос хянах, шаардлагатай үед дарамт шахалт үзүүлэх, Хятадад ДХБ-ын дүрмийг улс орон даяар хэрэгжүүлэх чадавхыг бий болгоход нь туслах юм.

Энэхүү арга барилыг БНХАУ-ын бүх томоохон худалдааны түншүүд хэрэглэсний дотор үүнийг хамгийн ил шулуун дэмжигч нь АНУ юм.

⁹⁸ Мөн эх сурвалж. х. 58

⁹⁹ Мөн эх сурвалж. х. 64

¹⁰⁰ Чан, мөн эх сурвалж. х. 2

¹⁰¹ Мөн Чан-ыг үз, мөн эх сурвалж. х. 6 (зүүлт 10)

¹⁰² Мөн эх сурвалж. х. 10

Хяналт нь Шилжилтийн дахин хянах механизмаар хэрэгжиж байгаа бөгөөд үүнээс улбаалан олон хэлэлцүүлэг болдог, зарим тохиолдолд сайжирсан байдаг.

Маргаантай асуудлуудыг маргаан шийдвэрлэх байгууллагуудад аваачих шахалтын үр дүнд хэд хэдэн хэрэг дээр нааштай үр дүнд хүрсэн. Тухайлбал, бичил схемийн НӨАТ, дижитал бүтээгдэхүүний гаалийн үнэлгээ, кокс, хайлуур жоншны экспортын хязгаарлалт зэрэг асуудлаар үр дүнд хүрсэн.

Хятадад байгууллагын чадавхыг бий болгоход нь туслахын тулд Хятадын худалдааны гол түншүүд өнгөрсөн хэдэн жилд Хятадын томоохон хотуудад бизнесийн хэвшил, олон талт байгууллагууд, Хятадын Засгийн газрын янз бүрийн түвшний байгууллагуудтай хамтран олон семинар, уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.¹⁰³

Хэтдээ бид нар хоёр томоохон өөрчлөлт гарна гэж бодож байна. Үүнд:

Нэг талаар, Хуучин социалист лагерийн орнууд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хуралд нэгдсэний дараа (ЕАБХАБХ-ын зарим дүрмийг биелүүлэхээс цааргалж байсан ч) тэдэнд түлхэц өгсөнтэй адил ДХБ-ын дүрмийг төгс бус хэдий ч хэрэгжүүлэх нь Хятадын эдийн засаг, нийгмийн тогтолцоог илүү нээлттэй, либерал дэг журам тийш чиглүүлнэ.

Нөгөө талаар, БНХАУ-ын ДХБ-д элссэн явдал нь тус байгууллагын доторх хүчний тэнцвэрийг их өөрчилсөн. Хятадын гишүүнчлэл нь хөгжиж буй орнуудын хэлэлцээ хийх хүчийг сайжруулж, АНУ, ЕХ, бусад аж үйлдвэржсэн орнуудын нөлөөг бууруулна. Хятад энэхүү байдлаа ашиглан элсэн орохдоо тохиролцсон зарим нөхцөлөө өөрчлөхөөр цаашид ДХБ-тай дахин хэлэлцэн тохиролцохыг хичээж болно.

¹⁰³ Мөн эх сурвалж. х. 15 f.

V Хятад ДХБ-д элсэн орохдоо авсан амлалт үүргийн үзүүлж болох нөлөө

V 1 БНХАУ-ын эдийн засагт үзүүлэх нөлөө

V 1.1 Цаашид хийгдэх бүтцийн өөрчлөлтүүд

Нэг тэрбум гаруй хэрэглэгчтэй Хятад улс нь эрт цагаас хойш гадаадын бизнес эрхлэгчдийн сэтгэлийг татсаар ирсэн.

Гэхдээ Хятадыг “том зах зээл” гэж ойлгох нь ерөнхийдөө төөрөгдүүлсэн ойлголт юм. Учир нь эрт цагаас хойш хятадууд гадаадынхны худалдаа хийх сонирхлыг төрүүлсэн арилжааны практикийг чадварлаг хөгжүүлж ирсний зэрэгцээ гадаадынхныг зайтай байлгасаар ирсэн. Гадаадын бизнесийн түншүүддээ зах зээлийнхээ хамгийн өчүүхэн хэлтэрхийг аль болох өндөр үнээр зардаг нь Хятад түншүүдийн арилжааны хэвшсэн зан байдал билээ. Гадаадынхан тохиролцох сүүлийн шатанд л мэддэг энэхүү зорилгыг энгийн арилжааны нөхцөлийг уран чадварлаг тохиролцон, сүүлд нь их боловсронгуй эдийн засгийн орчин болгох замаар биелүүлдэг.

ДХБ-д БНХАУ элссэн нь энэ хандлага тэр чигээрээ алга болно гэсэн баталгаа биш, харин Хятадын зах зээлийн нөөц бололцоо гадаадынханд шударга нөхцөлөөр илүү хүртээмжтэй болох боломжийг өгнө. Ийм явдал болбол Хятадын эдийн засагт томоохон өөрчлөлт хийгдэх болно.

III бүлэгт бичсэнчлэн ДХБ-ын гишүүнээр элссэнээр Хятад тарифаа бууруулж, тусгай зөвшөөрөл олгох шаардлага, квотын хязгаарлалт зэрэг төрөл бүрийн ТБСТ-оо арилгаж, улсын худалдаа болон тусгай эрх олгосон худалдааг багасган худалдааны эрхийг өргөжүүлж, олон шатлалт үнэ тогтоох тогтолцоог устгаж, хууль тогтоомжийг нийтэлж, нэгэн жигд хэрэгжүүлэн, эцэст нь НТҮ болон Үндэсний нөхцөлийн дүрмийн шаардлагын дагуу ялгаварлах түгээмэл хэлбэрийг хориглох замаар зах зээлээ нээнэ гэсэн үг. Хэзээ, хэр их гэдгийг нь яг мэдэхгүй ч Хятадын ОӨЭ-ийн байдал аажмаар сайжирна. Гадаадын хөрөнгө оруулагчид илүү чөлөөтэй амьсгалах бөгөөд үйлчилгээний худалдааны либералчилал одоо бараг байхгүй шинэ бизнесүүдийн хөгжилд түлхэц өгнө.

Энэ бүхэн нийлээд Хятадын иргэд болон гадаадынхны хоорондох өрсөлдөөн төдийгүй, Хятадын иргэдийн хоорондох өрсөлдөөнийг нэмэгдүүлэх нь эргэлзээгүй.

Ингэснээр Хятадын эдийн засаг шинэ технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлж, мэргэжлийн сургалтыг сайжруулж, хэрэгцээгүй ажиллах хүчнээсээ салах замаар бүтээмжээ нэмэгдүүлэх их дарамт шахалтад орно. Үйлдвэрлэлийн цар хэмжээнээс үүдсэн арвилан хэмнэлтээ сайжруулахын тулд Хятадын аж үйлдвэр, ялангуяа автомашин, электроник, сүлжмэл эдлэл, хувцасны үйлдвэрийн салбарууд болон бусад хөнгөн үйлдвэрийн салбаруудад нэгдэх ба худалдан авах (НБХА) замаар төвлөрөх шаардлагатай болно. ОӨЭ-ийн хамгаалалтыг сайжруулснаар техникийн шинэчлэлийг дэмжинэ.

Бүтээмжийг ингэж огцом нэмэгдүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдана. Бэлэн мөнгөөр хомс улсын өмчийн олон компанийн хувьд энэ нь хүнд дарамт болох тул шууд болон багц хэлбэрээр гадаадын хөрөнгө оруулалт шаардагдана. УӨҮГ-ууд гадаадын санхүүжилтийг авахын тулд Хятадын болон гадаадын хөрөнгийн биржүүдэд бүртгүүлэх ёстой. Хөрөнгө оруулалтыг шаардлагатай хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхийн тулд Хятад ялангуяа цөөн хувьцаа эзэмшигчдийн эрхийн хувьд корпорацийн удирдлагын дүрмээ эрс сайжруулах ёстой болно. Хувьчлал – энэ нэр томъёо БНХАУ-ын улс төрийн толь бичигт хараахан ороогүй байна. Жижиг болон дунд оврын компаниудын

хувьчлалыг хурдасгах ёстой. Өнөөдөр Хятадын эдийн засагт гүйцэтгэж байгаа хувийн бизнесийн тэргүүлэх үүрэг хувийн хэвшлийн талаарх Хятадын эдийн засгийн бодлогод том өөрчлөлт хийхийг шаардаж байна.

Дунд оврын олон компаниуд гадаад худалдааны талбарт хэзээ нэгэн цагт гарч ирнэ. Учир нь ДХБ-ын дүрмээр тэдэнд худалдаа хийх эрх өгч байна. 2003 онд 500-хан компани Хятадын нийт гадаад худалдааны 42%-ийг эзэлж байсан бол¹⁰⁴ олон шинэ компаниуд гадаад худалдаагаа өөрсдөө явуулах тул энэ хувь хэмжээ буурах болно.

Үүний үр дүнд ДХБ-д элссэнээр Хятад 1979 онд эхлүүлсэн эдийн засгийн шинэчлэлээ бэхжүүлж, түргэсгэнэ.

Хэрэгжүүлэхэд нэлээд уян хатан байх боломжтой ДХБ-ын дүрмийг Хятад хэрхэн биелүүлэхээс их зүйл хамаарах нь мэдээж. Тарифыг заавал баримтлах түвшнээс доош тогтоож ч болно, тогтоохгүй байсан ч болно. ОӨЭХХА-ыг мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийг дэмжих байдлаар эсвэл аж үйлдвэржсэн улс орон руу шилжүүлэх байдлаар хэрэглэж болно.¹⁰⁵ Одоо ДХБ-ын дүрэм нь Хятадын эдийн засгийн зарим салбарт үзүүлж болох нөлөөг авч үзье.

V 1.2 Хөдөө аж ахуй

ДХБ-д элссэнээр Хятадын хөдөө аж ахуйд үзүүлэх нөлөөг хэмжихэд хэцүү. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд ногдуулах тарифын дундаж түвшинг 18.9%-иас 15% хүртэл бууруулна. Амьд мал, амьтан болон холбогдох бүтээгдэхүүнд ногдох тарифыг 15.7%-иас 9.9% хүртэл буурна. Нөгөө талаар, Хятадын хөдөө аж ахуйн худалдаанд улсын худалдаа, тусгай эрх олгосон худалдаа, квот, тариф, тарифын түвшний квот зэрэг маш олон бодлого нөлөөлсөөр ирсэн тул хуулиар тогтоосон тарифын түвшин хамгаалалтын бодит түвшинд багахан нөлөөтэй гэдгийг янз бүрийн судалгаагаар тогтоосон.¹⁰⁶ Эрдэнэ шиш, хөвөнгийн экспортын татаас нь эдгээр бүтээгдэхүүнийг хамгаалах түвшнийг нэмэгдүүлж байна. Уул нь эдгээр татаасыг устгах ёстой.

Олон эрдэмтдийн хийсэн судалгааны үр дүнг харгалзан үзсэний үндсэн дээр Мартин-Бхаттасали-Ли хөдөө аж ахуйн хамгийн гол бүтээгдэхүүний хамгаалалтын түвшний өөрчлөлтийг дараах байдлаар тооцсон. Үүнд:

Хятадын хөдөө аж ахуй дахь импорт хамгаалах зарим арга хэмжээ (хувиар)

	1998 оны хуулиар тогтоосон тариф	2001 оны бодит хамгаалалт	Элссэний дараах хамгаалалт
Цагаан будаа	127	-3.3	-3.3
Улаан буудай	133	12.0	12.0
Эрдэнэ шиш	130	32.0	32.0
Хүнсний ногоо, жимс	15	-4.0	-4.0
Тосны үр тариа	132	20.0	20.0
Элсэн чихэр	30	40.0	20.0
Хөвөн	3	17.0	20.0
Мал, мах	35	-15.0	-15.0
Сүү	46	30.0	11.0

Тайлбар: Хуулиар тогтоосон дундаж түвшинг Шмидхубэр (2001) ба www.chinavista.com–аас авсан
Эх сурвалж: Мартин-Бхаттасали-Ли, Хятад ДХБ-д элссэн нь – Хятадад үзүүлэх нөлөө, х. 10

¹⁰⁴ ХЯ-ны өгсөн мэдээллээр (Гадаад худалдааны мэдээлэл 2004 оны 7-р сарын 1)

¹⁰⁵ Мартин-Бхаттасали-Ли, мөн эх сурвалж. х. 18 (сүүлийн зүүлт 2)

¹⁰⁶ Мөн эх сурвалж. х.7

Гонконг зэрэг зах зээлд гаргах экспортыг хязгаарласны уршгаар мал, махны хувьд зах зээлийн хамгаалалт сөрөг хэвээр байгаа нь Монголд чухал байж болно. БНХАУ заавал баримтлах тарифын амлалт үүргээ биелүүлэхийн тулд сүүн бүтээгдэхүүний хамгаалалтыг бууруулж магадгүй.

Энэхүү судалгаа нь хөдөө аж ахуй нь урьд өмнөх зарим судалгаагаар анх дүгнэж байснаас бага либералчилагдаж байгааг харуулж байна. Гэхдээ эрдэнэ шиш, хөвөн, элсэн чихэр зэрэг чиглэлээр нэлээд либералчилагдсан нь эдгээр бүтээгдэхүүнд нэлээд шахалт үзүүлнэ.

V 1.3 Аж үйлдвэр

V 1.3.1 Хүнс, ундаа

ДХБ-д элссэний гол нөлөө нь тариф ба тарифын бус саад тотгор багасах явдал юм. Боловсруулсан хүнсэнд ногдох дундаж тарифыг ДХБ-д элсэхээс өмнөх 31%-иас 22% хүртэл бууруулна. Ингэснээр хүнс, ундааны импорт өсөж, өрсөлдөөн нэмэгдэнэ. 2000 онд Хятадын хүнс, ундааны салбар жилд 5 сая юаниас дээш борлуулалт хийдэг, хөдөлмөр их зарцуулдаг, хоцрогдсон технологитой 10,842 үйлдвэрлэгчээс бүрдэж байсан тул шаардлагатай шинэчлэлийг хийхэд их хэмжээний хөрөнгө оруулалт, илүү төвлөрөл шаардагдаж байна. Энэ хөрөнгө оруулалтын их хэсэг нь гадаадаас ирнэ. Сүүлийн жилүүдэд угаасаа гадаадын хөрөнгө оруулалт их хувийг эзэлж байгаа билээ. Ялангуяа сүүний салбар Danone, Palamart, Nestle, Kraft зэрэг дэлхийд нэртэй үндэстэн дамнасан зарим компанийг татаж чадсан. Гадаадын компаниуд Хятадын түншүүдтэйгээ нэгдэх ба тэднийг худалдан авах талаарх Засгийн газрын бодлого нь либерал байсан бөгөөд ДХБ-д элссэнээр энэ хандлагад нэг их өөрчлөлт гарахгүй.

Хүнсний салбар нь Хятадын анх зах зээлийн хандлагатай шинэчлэл хийж, төрийн зүгээс эдийн засагт оролцохыг багасгаж эхэлсэн салбаруудын нэг юм. Ерөнхийдөө хүнсний үйлдвэрлэгчдийн дийлэнх нь үйлдвэрлэл, үнэ тогтоолт, борлуулалттай холбоотой шийдвэрийг гаргахдаа бүрэн өөрөө шийдэх эрхтэй бөгөөд хүнсний салбарт ороход нэлээд чөлөөтэй. Өрсөлдөөн ба зохицуулах бодлого нь хүнсний аюулгүй байдлын стандарт, үйлдвэрлэл, чанарын стандарт, худалдааны тэмдэгт голлон анхаардаг. Ирээдүйн хандлагыг харахад одоо байгаа аюулгүй байдал, чанарын стандарт аажмаар олон улсын практикт илүү ойр, илүү хатуу стандартаар солигдоно.¹⁰⁷

Хүн амын өсөлт, хүн ам зүйн хандлага, орлогын өсөлт, өөрчлөгдөж буй хэрэглээний шинжийг харгалзан үзсэний эцэст Дойчэ Банкны Дэлхийн Судалгааны Хүрээлэн нь хүнс, ундааны салбарын өсөлтийн хувь нь эдийн засгийн дундаж өсөлтийн хувиас илүү байна гэж тооцсон (нийт өсөлт 7.0%-7.5% бол энэ салбарын өсөлт 8%-9% байна). Дэд салбаруудын хувьд зарим хэлбэлзэл бий. Мах, өндөгний бүтээгдэхүүн, тэжээл боловсруулах салбар харьцангуй хурдан өсөлттэй буюу жилд дунджаар 7.8% өсөж байна. Харин сүүний салбар 10%-иар өссөн.¹⁰⁸

V 1.3.2 Түүхий эд

ДХБ-ын өмнө авсан амлалт үүргийн дагуу, ган бүтээгдэхүүнд ногдох тарифын дундаж түвшин 2004 онд 10.6%-иас 8.1% хүртэл, хөнгөн цагаан бүтээгдэхүүнд ногдох тарифын дундаж түвшин 2004 онд 7.8%-иас 4.6% хүртэл унана. Зэс,

¹⁰⁷ Дойчэ Банкны Дэлхийн зах зээлийн судалгааны хүрээлэн, Хятадын байр суурь: ДХБ-ын үйлдвэрийн өөрчлөн байгуулалт, х 23

¹⁰⁸ Мөн эх сурвалж.

молибдены баяжмалд ногдох заавал баримтлах тарифын хувь тэг байна. Түүхий эдийн салбарт түгээмэл байсан улсын худалдаа болон бусад ТБСТ-ууд 2004 он гэхэд байхгүй болно.

Үүний үр дүнд олон түүхий эдийн импорт их өснө. Учир нь барилгын салбар, эрчим хүч, автомашин, электроникийн салбарын эрэлт хүчтэй хэвээр байна. Импортын саад тотгорыг арилгавал түүхий эдийн үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй ойртуулах болно.

Өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд Засгийн газар нийт үйлдвэрлэлийг хянах, түүхий эдийн салбарын хоцрогдсон үйлдвэрлэлийн чадавхыг устгах арга хэмжээг авсан. Эдгээр бодлого нь нийлүүлэлт, эрэлтийг дахин тэнцвэржүүлж, УӨҮГ-уудын санхүүгийн байдлыг сайжруулахад чиглэсэн. Хэдэн зуун жижиг ган хайлуулах үйлдвэр, нүүрсний уурхайнууд хаагдаж магадгүй байна. Электролизын зэс, зэс боловсруулалтын үйлдвэрлэл, чадавхыг нэмэгдүүлэх нь хатуу хяналтан дор байна. Их бохирдол үүсгэдэг, зэс гарган авах хувь бага зэс хайлуулах жижиг үйлдвэрүүд удахгүй хаагдана. Хятадын аж ахуйн нэгжүүд нь гадаадын зэсийн ордын эрэл хайгуул, олборлолтод хөрөнгө оруулалт хийж, гадаадаас зэс нийлүүлэх суваг бий болгохыг хөхиүлэн дэмждэг.

ДХБ-д элссэнээр гадаадын өрсөлдөөн нэмэгдсэний улмаас дотоодын зэс, хөнгөн цагааны салбарт хүнд бэрхшээл учирна. Дотоодын зэсийн ордын доогуур чанараас болж электролизын зэс гаргалт 6.0-7 орчим хувиар удаан өсөж байгаа нь импорт огцом өсөхөд хүргэж байна.¹⁰⁹

V 1.3.3 Сүлжмэл эдлэл, хувцас

1998-2000 онд сүлжмэл эдлэл, хувцасны үйлдвэрийн салбар бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бүрэн үйл ажиллагааг туулсан. ДХБ-д элсэх үеэр тус салбар амлалт үүргээ аль хэдийн биелүүлсэн тул, шинэ нөхцөлд хамгийн сайн бэлтгэгдсэн бөгөөд тэргүүлэх эрдэмтдийн санал нэгтэй дүгнэснээр¹¹⁰ Хятад ДХБ-д элсэхэд үр шимийг нь хамгийн их хүртэх болно.

1997 онд сүлжмэл эдлэл ба хувцасны салбар 10 сая хүмүүс ажиллуулдаг, 45.6 тэрбум америк долларын бүтээгдэхүүн экспортолдог 45,600-аас цөөнгүй үйлдвэрээс бүрдсэн. Ихэнх компани алдагдалтай ажиллаж байсан бөгөөд их өртэй, хоцрогдсон технологи, тоног төхөөрөмж хэрэглэдэг байв. Азийн хямралын үеэр түүхий эдийн үнэ өсөж, эрэлт буурснаар тус салбар хүнд бэрхшээлтэй учирсан. Тиймээс тус салбар ЖДҮ-ийн бүтцийг өөрчлөх Засгийн газрын хүчин чармайлтын нэг гол чиглэл болсон. 2000 он гэхэд компанийн тоо 12,000,¹¹¹ бусад эх сурвалжийн мэдээлснээр 18,600 болж буурсан бол,¹¹² энэ үед экспорт 53 тэрбум америк доллар хүртэл өсжээ. Бүтцийн өөрчлөлтийн явцад 300 гаруй томоохон УӨҮГ хаагдаж, 1,000 гаруй УӨҮГ-ыг бусад компаниуд худалдаж авах буюу нэгтгэсэн бөгөөд хэдэн сая сүлжмэл эдлэлийн ажилчид ажилгүй болсон. Гурван жилийн туршид нийт 9.4 сая хөвөн утасны зэрүүл, 280,000 ноосны зэрүүл хаягдсан.¹¹³ Эрчимжүүлсэн хувьчлал болон өсөн нэмэгдэх ГШХО-ын үр дүнд УӨҮГ-ын зах зээлд хувийн жин 49%-иас 35.8% болтлоо унасан.¹¹⁴ Засгийн газар сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэлийг тусгай зөвшөөрлийн шаардлагаар хатуу

¹⁰⁹ Мөн эх сурвалж. х. 34 f. (35)

¹¹⁰ Мартин-Бхаттасали-Ли, х. 10; Янчовичина-Мартин Хятад улс ДХБ-д элссэний эдийн засгийн нөлөө х. 10 f.; Дойчэ Банкны Дэлхийн зах зээлийн судалгааны хүрээлэн, мөн эх сурвалж. х. 31 f.; Шлэзингэр ба бусад. Хятад улс ДХБ-д элссэний эдийн засаг, шинэчлэлтийн үйл явцын нөлөө болон Ази дахь эдийн засгийн өсөлтийн хандлага х. 90 f.

¹¹¹ Шлэзингэр ба бусад. х. 91

¹¹² Дойчэ Банкны Дэлхийн зах зээлийн судалгааны хүрээлэн, мөн эх сурвалж. х.31

¹¹³ *Иг үб һооооооо.*

¹¹⁴ Шлэзингэр ба бусад, мөн эх сурвалж. х.93

хязгаарласан бөгөөд аж ахуйн нэгжүүд ээрмэлийн хүрээг худалдан авахад нь тусгай зөвшөөрөл өгөх тул ирэх жилүүдэд энэ байдал үргэлжилнэ. Энэ бодлогын зорилго нь том, үр ашигтай аж ахуйн нэгжүүдийг экспортын квот, хөнгөлөлттэй зээлээр дэмжихийн зэрэгцээ төлбөрийн чадваргүй УӨҮГ-уудыг зах зээлээс шахан гаргах замаар “чадалтай нь үлддэг” зарчмыг дэмжихэд оршино.

Өөр нэг чиглэлээр Засгийн газар хөвөнгийн зах зээлд тавих хяналтаа сулруулах гэж байна. Өнөөг хүртэл хөвөн худалдан авах, борлуулахад Засгийн газар дангаараа ноёрхдог байсан бөгөөд худалдан авах, борлуулах үнийг фермерүүдэд татаас өгөх байдлаар тодорхойлдог байлаа. Үүний улмаас дотоодын үнэ дэлхийн зах зээлийн үнээс 20%-иар илүү гарч, сүлжмэл эдлэлийн үйлдвэрүүдийн ашигт ажиллагаанд хохирол учруулж, Хятадын сүлжмэл эдлэл экспортлогчдын өрсөлдөх чадварыг бууруулдаг байв. БНХАУ ДХБ-д элссэний дараа улсын худалдааны монополи эрх аажмаар алга болж, дотоодын үнэ олон улсын түвшинд хүртэл бууна.¹¹⁵

БНХАУ ДХБ-д элссэн нь сүлжмэл эдлэл, хувцасны экспортод маш их нөлөөлж байна. Бусад ихэнх хөгжиж буй улс орны экспортлогчтой адилгүй Хятадыг Сүлжмэл эдлэл, хувцасны тухай Уругвайн үе шатны хэлэлцээрээс хассан. Өөрөөр хэлбэл, ДХБ-д элсэхээсээ өмнө Хятад сүлжмэл эдлэл, хувцасны бүтээгдэхүүнийг ТХЕХ-т нэгтгэж, энэхүү хэлэлцээрийн дагуу квотын өсөлтийн хувь нэмэгдсэн зэргээс үр шим хүртээгүй. Энэ нь харьцуулах хэмжээний экспортын татвартай адилтгах эдгээр квотын гүйлгээний үнийг өсгөх шахалтыг үзүүлсэн.¹¹⁶ ЭТП-ын дагуу Хятад сүлжмэл эдлэл, хувцасны бүтээгдэхүүнийг ТХЕХ-т нэгтгэж, улмаар квотыг арилгаж, 1994 оноос хойш квотын өсөлтийн хувь нэмэгдсэнээс үр шимийг нь шууд хүртсэн. Бүх байгаа квотыг 2005 он гэхэд байхгүй болгоно.

Дэлхийн худалдааны ерөнхий тэнцвэрийн тооцож болох загвар дахь хийсвэр нөхцөл дээр үндэслэн *Дойчэ Банкны Дэлхийн зах зээлийн судалгааны хүрээлэн*¹¹⁷ нь БНХАУ-ын хувцасны үйлдвэрлэл нь Хятад ДХБ-д элсээгүй бол байх байсан хэмжээнээс 60%-иар их болно гэж тооцсон.

Сүлжмэлийн салбар нь Хятад ДХБ-д элссэний үр шимийг хүртэж, 2006 онд үйлдвэрлэл нь ДХБ-д элсээгүй байх үеийнхээс 13%-иар илүү болж өснө. Сүлжмэлийн салбарт үзүүлэх ашиг тус нь хувцасны салбарт үзүүлэх ашиг тусыг бодвол тодорхой бус байна. Учир нь хувцасны бүтээгдэхүүнд хөдөлмөр их зарцуулдаг байхад (тухайлбал Хятадын хамгийн их харьцуулсан давуу талтай салбар) сүлжмэлийн салбарт илүү их хөрөнгө зарцуулсан үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмжийг шаардагдана.

Сүлжмэл эдлэл, хувцасны дотоодын эрэлт өнгөрсөн үеийг бодвол удаан тухайлбал 4.0%-5.0% өсөх төлөвтэй байна. *Дойчэ Банкны Дэлхийн зах зээлийн судалгааны хүрээлэн* нь 2005 он хүртэл экспорт жил бүр 14%-15% өсөж, сүлжмэл эдлэл, хувцасны үйлдвэрлэл жилд 6%-13% өсөх боломжтой болно гэж тооцоолжээ.¹¹⁸

Гэхдээ Хятадын сүлжмэл эдлэл, хувцасны экспорт нь протекционист арга хэмжээний тоогоор илэрхийлэх боломжгүй эрсдэлд учирсан хэвээр байна. Импортлогч улс орнууд Хятадын экспортын, ялангуяа сүлжмэл эдлэл, хувцасны экспортын асар их нөөц бололцооноос айсны улмаас ЭТП-д орсон дампингийн эсрэг болон хамгаалах арга хэмжээний заалтуудыг ашиглана.

¹¹⁵ *Дойчэ Банкны Дэлхийн зах зээлийн судалгааны хүрээлэн, мөн эх сурвалж. х.32*

¹¹⁶ *Янчовичина-Мартин, мөн эх сурвалж. х. 10; Мартин-Бхаттасали-Ли, мөн эх сурвалж. х.11 бараг татварын нөлөө нь хувцасны хувьд 15 %, сүлжмэл эдлэлд 10 % байна.*

¹¹⁷ *Мөн эх сурвалж. х. 32*

¹¹⁸ *Мөн эх сурвалж. х. 33*

V 1.3.4 Электроник, мэдээллийн технологи, цахилгаан холбоо

Сүүлийн жилүүдэд жилийн дундаж өсөлт 20 орчим хувьтай байсан электроник, мэдээллийн технологийн салбар нь Хятадын нийт эдийн засгийн өсөлтөөс хоёр дахин их хурдтайгаар өсжээ. Цөөхөн жилийн хугацаанд Хятад компьютер, утас, холбогдох бүтээгдэхүүний томоохон үйлдвэрлэгчдийн нэг болжээ. 10-р таван жилийн төлөвлөгөөний дагуу тус салбар нь 2005 он хүртэл 20 хувийн өсөлтийн хурдаа алдахгүй бөгөөд дараах зорилтуудыг биелүүлсэн байх ажээ: 20 тэрбум бичил схем, 100 сая гар утас, 20 сая км шилэн кабель, 18 сая компьютер, 40 сая өнгөт зурагт, 20 сая VCD тоглуулагч, 500 тэрбум электроникийн эд анги, 250 тэрбум долларын програм хангамжийн борлуулалт.

Үйлдвэрийн бодлого дижиталжсан цахилгаан бараа, шинэ дэлгэцийн эд анги, фото-цахилгаан материал, бүрэлдэхүүн хэсгүүдийн судалгаа, боловсруулалт, бичил-электроник, компьютер, сүлжээний технологийг үйлдвэрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа, менежментэд хэрэглэхийг дэмжихэд голлон анхаарч байна.

2000 онд Засгийн газар хөрөнгө оруулалт, татвар, (НӨАТ-ын хувийг бууруулсан), экспорт (хөнгөлөлттэй худалдааны санхүүжилт), хүний нөөцөд нөлөөлөх “Програм хангамж, бичил схемийн үйлдвэрийн хөгжлийг дэмжих бодлого” гаргалаа.

2005 он гэхэд бүх гишүүн улс орон нь хагас дамжуулагч, компьютер, цахилгаан холбооны тоног төхөөрөмжид ногдуулах тарифаа ёстой Мэдээллийн технологийн хэлэлцээрт (МТХ) Хятад нэгдсэнээр импортын татварыг бууруулах буюу аажмаар арилгах нь хөдөлмөрийн багтаамж ихтэй электроникийн үйлдвэрлэл, угсрах үйлдвэр дэх БНХАУ-ын харьцангуй давуу талыг бэхжүүлнэ. Эцсийн бүтээгдэхүүний бага үнэ нь дотоодын эрэлтийг нэмэгдүүлнэ. Эдгээр хүчин зүйлүүд тус салбарт орох ГШХО-ыг цаашид нэмэгдүүлэх урамшуулал болж болно.

Нөгөө талаар, Хятад 2005 он гэхэд хагас дамжуулагч, компьютер, харилцаа холбооны тоног төхөөрөмжид ногдох ихэнх тарифаа устгах ёстой. Ингэснээр Хятадын үйлдвэрлэгчид гадаадын эрчимтэй өрсөлдөөнтэй тулгарна. Техникийн хувьд давуу гадаадын бүтээгдэхүүний учруулсан сорилыг давахын тулд судалгаа, боловсруулалтын ажлыг сайжруулах ёстой. Үүний улмаас тус салбар НБХА үйл ажиллагаагаар дамжуулан илүү төвлөрөх хандлагатай байж болно.¹¹⁹

Цахилгаан холбооны салбарт, ерөнхий бодлогын чиглэл нь гадаадын хөрөнгө оруулагчдыг чөлөөтэй орохыг зөвшөөрөхөөс өмнө салбарын бүх хэсэгт дотоодын өрсөлдөөн бий болгоход оршино.

Хятад хэдийгээр цахилгаан холбооны салбарт бүтцийн өөрчлөлт хийхэд ахиц гаргаж, суурин утасны оператор нь хойд ба өмнөд жигүүр хэмээн хуваагдаж, гар утасны зарим жижиг компаниуд өрсөлдөөнийг улам сонирхолтой болгосон боловч одоо ч гэсэн олигополь бүтэцтэй хэвээр байна. Огцом өсөлт (2001 онд 169 сая суурин утас хэрэглэгч, 126 сая гар утас хэрэглэгч) гарсан боловч цахилгаан холбооны үйлчилгээ нь үйл ажиллагааны үр ашиг багатай байсаар байна. Нэг ажилтанд ногдох бизнесийн орлого дөнгөж 54,000 америк доллар буюу дэлхийн дунджийн 30 гаруйхан хувьтай л тэнцэж байна. Гадаадын хөрөнгө оруулагчаас их хэрэгцээтэй байгаа хөрөнгө, технологи, менежментийн чадвар авчрахыг хүсэн хүлээдэг. Гэхдээ Засгийн газар нь ДХБ-д элсэн орсноосоо хойш таван жил өнгөрсний дараа ч гэсэн цахилгаан холбооны ямар ч үйлчилгээний 50-иас дээш хувийг гадаадын эзэмшилд байхыг зөвшөөрөхгүй. Ингэснээр гадаадын хөрөнгө

¹¹⁹ Дойчэ Банкны Дэлхийн зах зээлийн судалгааны хүрээлэн, мөн эх сурвалж. х. 14; мөн Шлэзингэр бусдыг үзнэ үү., мөн эх сурвалж. х. 40 f.

оруулагчид нь дотоодын компаниудын өрсөлдөгчид биш харин (хяналтан дор байдаг) түншүүд байх болно.¹²⁰

V 1.3.5 Тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийн салбар

ДХБ-д элсээгүй ч гэсэн тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийн салбар бүтцийн өөрчлөлтийн хэцүү явцыг туулах байсан. Учир нь 2000 оны эцэс гэхэд энэ салбарт 2500 компани, үүний дотор 130 бүрэн угсрах компаниуд байлаа. Тэд 100% ба түүнээс дээш “Хятадын тарифын хэрэмний” цаана ажиллаж байсан. 2006 он гэхэд гаалийн татварыг 25% хүртэл бууруулж, импортын квотыг арилгахын зэрэгцээ гадаадын автомашин сонирхдог баян чинээлэг хэрэглэгчдийн тоо улам өссөнөөр өрсөлдөөн маш их ширүүснэ. Дотоодын үйлдвэрлэгчид үйлдвэрлэлийн цар хэмжээнээс үүдсэн арвилан хэмнэлтээ сайжруулах замаар үр ашиг, ашигтай ажиллагаагаа нэмэгдүүлэх хүчтэй дарамт шахалтад байна. Засгийн газрын шинэчлэлийн төлөвлөгөөний дагуу автомашины салбарын бүтцийн өөрчлөлт ихэнх автомашины компанийг гурав буюу дөрвөн том үйлдвэрийн бүлэг болгон нэгтгэхэд чиглэж байна.

Одоогоор автомашин үйлдвэрлэгч хамтарсан компаниуд нь импортын хамгаалалт, судалгаа, боловсруулалтын бага зардлын улмаас 7-15%-ийн ашгийн маш өндөр цэвэр ашигтай байдаг. ДХБ-тай холбоотой худалдааны либералчилал нь салбар дахь том хэмжээний нэгдэл, үр ашгийн өсөлт, үйлдвэрлэлийн зардлын бууралт, бүтээгдэхүүний үнийн огцом бууралтад хүргэнэ. Цэвэр ашиг магадгүй 50-70 хүртэл хувиар их буурна.

Хятадын автомашины зах зээл сүүлийн жилүүдэд асар хурдан өсөн нэмэгдэж байна. Орлого өсөж, автомашины үнэ навс унаж, дэд бүтэц сайжирч байгаа учраас дунд хугацаанд жилийн өсөлт 10-15% байх нь бодитой болов уу. Дунд ангийнхан өсөн нэмэгдэж байгаатай холбоотой жижиг, хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй автомашинуудын эрэлт онцгой их болно.¹²¹

V 1.3.6 Материал техникийн хангамж ба контейнерын тээвэрлэлт

Материал техникийн хангамжийн өртөг нь Хятадын эдийн засагт харьцангуй өндөр байдаг бөгөөд үйлчилгээний чанар муу байдаг нь төлөвлөгөөт эдийн засгийн амь бөх уламжлалтай зарим талаар холбоотой.¹²² Хятадад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний бөөний үнийн 30%-40%-ийг материал техникийн хангамжийн өртөг эзэлдэг бол АНУ-д 5-20%-ийг л эзэлдэг. Материал техникийн хангамжийн их өртөг нь Хятадын ядуу хэсгийн хүмүүс, тухайлбал энэхүү их нэмэлт өртгөөс болж худалдан авах чадвар, улмаар бодит орлого нь их хэмжээгээр багасах хүмүүсийн хувьд том асуудал болж байна.¹²³

Хятад автозамын тээвэр, төмөр замын тээвэр, агуулах, тээвэр зуучийн зэрэг гол хэдэн салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлэхээр үүрэг амлалтыг авсан. Эдгээр үүрэг амлалт нь нэгдсэн хөндлөнгийн материал техникийн хангамжийн компаниуд буюу бараа илгээгч, хүлээн авагчаас хараат бус үйлчилгээ үзүүлэгчдэд хөгжих суурь болох бөгөөд ингэснээр материал техникийн хангамжийн үйлчилгээний өртгийг бууруулж, чанарыг сайжруулахад түлхэц өгнө.

Хятад дахь материал техникийн хангамжийн нөөц бололцоог бүрэн ашиглахад худалдааг илүү чөлөөтэй болгоод зогсохгүй тодорхой төрлийн аж ахуйн нэгжүүдийг ялгаварлахыг болиулж, орон нутгийн протекционизмыг устгах

¹²⁰ Мөн эх сурвалж. х. 7

¹²¹ Мөн эх сурвалж. х. 19 f.; Шлэзингэр ба бусад., мөн эх сурвалж. х. 75 f.

¹²² Мартин-Бхаттасали-Ли, мөн эх сурвалж. х. 12

¹²³ Мөн эх сурвалж.

зохицуулалтын шинэчлэлийг хийх шаардлагатай байна. Үүний зэрэгцээ материал техникийн хангамжийнүйлчилгээ үзүүлэх зардлыг багасгаж, хугацаандаа гүйцэтгэх боломжийг сайжруулахынтулд дэд бүтцэд их хөрөнгө оруулах шаардлагатай болно.¹²⁴

Контейнерын тээвэрлэлт нь сүүлийн жилүүдэд ямар зүйлийг амжуулав, юу хийх шаардлагатай байгааг харуулах жишээ юм.

90-ээд оны сүүлийн хагаст контейнерын тээвэрлэлт асар их өссөн. 1980-2000 онд Хятадын ДНБ жилд дунджаар 9.7%-иар өссөн бол энэ хугацаанд гадаад худалдаа 13.4%-иар өсжээ. Гэхдээ контейнерын тээвэрлэлт маш бага түвшнээс эхлэн 1990-2000 онд жилд дунджаар 31%-иар өсжээ. Контейнерын ачаа эргэлт 1.3 сая ХФАН-ээс 20 сая ХФАН болтлоо буюу 15 дахин өссөн.

Арван боомт 18 сая ХФАН ачсан нь нийт контейнерын 82%-тай тэнцэж байна. Үүнд: Шанхай (2000: 5.6 сая ХФАН; + 1999 оныхоос 33.1%-иар илүү), Шэнжэн (3.9 сая ХФАН; + 41.3 %), Цингдао (2.1 сая ХФАН; + 37.4 %) Тяньжин (1.7 сая ХФАН; + 30.6 %).¹²⁹

Энэхүү их өсөлт гарсан ч гэсэн Хятадын контейнерын боомтуудын одоо байгаа хүчин чадал нь эрэлтээсээ хамаагүй бага байна. Гүн усны контейнерын боомтууд, үүний дотор дээр дурьдсан боомтууд маш хангалтгүй байна. Засгийн газрын төлөвлөгөөний дагуу 2010 гэхэд далайн эргийн боомтуудын контейнер эргэлтийн нийт хэмжээ 75 сая ХФАН болно. Тэр үед контейнерын төв боомтууд олон улсын ачаа тээврийн маршрутын стандартад нийцэж, контейнерын шууд тээвэрлэлтийн хувьд 80%-иас илүү байх болно.

Уламжлал ёсоор боомтуудыг Харилцаа холбооны яамнаас гаргасан дүрэм журмын дагуу орон нутгийн засаг захиргаа удирддаг. Зохицуулах ба аж ахуйн менежментийн чиг үүргийг боомтын удирдлага нь орон нутгийн засаг захиргааны удирдлага дор гүйцэтгэдэг. Засгийн газар нь зохицуулагчдыг (харилцаа холбооны орон нутгийн товчоо) зохицуулдаг байгууллагаас нь (боомтын удирдлага) салгахаар төлөвлөж байна. Боомт хот бүрт энэ зорилгыг хэр хэмжээнд хийж гүйцэтгэхийг хэмжихэд хэцүү.

ГШХО нь контейнер тээвэрлэх бизнест нэг гол үүргийг гүйцэтгэдэг. Одоогоор контейнерын тээвэрлэлт хийдэг 20 хамтарсан компани, олон улсын карго тээвэрлэлт эрхэлдэг 300 гаруй хамтарсан компани бий. Хятад дахь гадаадын хөрөнгө оруулалттай боомтын төслүүдийн тоо 200-д хүрсэн.¹²⁵ Үүнээс хамгийн тод жишээ нь "Hutchinson Whampoa ХХК" (Гонконг) юм.

Хятадын гадаад худалдаа ирэх жилүүдэд хурдан өсөх хандлагатай (жилд 11-12%) байгаа тул контейнерын тээвэрлэлт нь жилд 15-20% өснө. Шангайд гүн усны боомт шинээр барихаар төлөвлөж байгаа нь Азид ийм төрлийн байгууламж дотроо хамгийн томд орох болно. Шэнжэн, Нингбо-гийн боомтын хүчин чадлыг дээрхийн адил нэмэгдүүлснээр Гонконгын өндөр өртөгтэй контейнерын тээврийн үйлчилгээтэй өрсөлдөх болно.

V 2 Бүсийн эдийн засгийн харилцаанд үзүүлэх нөлөө

БНХАУ ДХБ-д элссэнээр 1979 оноос хойш хийгдэж байгаа Хятадын эдийн засгийн шинэчлэлд хүчтэй түлхэц болсон. Хятадын эдийн засаг олон улсын өрсөлдөөнд нээлттэй болохын хэрээр түүний бүтэц, бүтээгдэхүүн, худалдааны шинж, капитал,

¹²⁴ Дойчэ Банкны Дэлхийн зах зээлийн судалгааны хүрээлэн, х.29

¹²⁵ Мөн эх сурвалж

чадварын багтаамж ихтэй үйлдвэрлэл, өөрөөр хэлбэл нэмүү өртөг ихтэй бүтээгдэхүүн рүү хөгжинө.

*Янчовичина-Мартин*¹²⁶ ДХБ-д элссэнтэй холбоотой либералчилал нь гадаад худалдааны хувьд хөдөө аж ахуй, үйлдвэр, үйлчилгээний салбарт хэрхэн нөлөөлөхийг судалсан.

ДХБ-д элссэнээр түргэссэн либералчилал нь БНХАУ-ын эдийн засгийн гадаад харилцааны өсөлтийг бүтээгдэхүүнтэй харьцуулахад илүү хурдасгана. 2001 оноос хойш либералчилалын арга хэмжээний үр дүнд экспортын нийт хэмжээ 17%-иар өсөх төлөвтэй байна.

ДХБ-д элсэхэд шаардсаны дагуу хамгаалалтыг багасгасны нөлөө
(2001 оны тарифын түвшнээс)

	Бүтээгдэхүүн %	Ажил эрхлэлт %	Экспорт %	Импорт %	Худалдааны тэнцэл сая ам.долл.
Цагаан будаа	-2.1	-2.3	6.1	-7.1	64
Улааны буудай	-2.0	-2.3	18.9	-10.1	174
Тэжээлийн үр тариа	-2.3	-2.6	-77.8	-2.4	-596
Хүнсний ногоо, жимс	-3.4	-3.7	14.6	-6.3	214
Тосны үр	-7.9	-8.4	29.8	20.9	-789
Элсэн чихэр	-6.5	-7.4	13.9	24.1	-73
Ургамлын гаралтай утас	15.8	16.4	-51.8	7.7	-189
Мал, мах	1.3	1.1	15.5	-8.9	837
Сүү, сүүн бүтээгдэхүүн	-2.0	2.4	13.5	23.8	-143
Бусад хүнс	-5.9	-6.4	11.4	62.6	-3,460
Ундаа, тамхи	-33.0	-33.1	9.7	112.4	-14,222
Олборлох салбарууд	-1.0	-1.3	7.5	-4.4	2,088
Сүлжмэл эдлэл	15.6	15.5	32.7	38.5	-10,366
Хувцас	57.3	56.1	105.8	30.9	49,690
Хөнгөн үйлдвэр	3.7	3.7	5.9	6.8	1,786
Нефть-химийн	-2.3	-2.3	3.1	11.8	-8,810
Металл	-2.1	-2.1	3.7	6.8	-1,893
Автомашин	1.4	-2.2	27.7	24.0	516
Электроник	0.6	0.4	6.7	6.8	453
Бусад үйлдвэр	-2.1	-2.2	4.1	18.9	-11,291
Нийт	1.0	0	16.8	17.3	717

Эх сурвалж: Дэлхийн банк, *Янчовичина-Мартин*, мөн эх сурвалж. х. 11

Хамгийн хурдан өсөж байгаа экспорт бол хувцасны экспорт бөгөөд квотын дэглэм арилсантай холбоотой 2001 оноос хойш хоёр дахин өсөх төлөвтэй. Хөдөө аж ахуйн ихэнх бүтээгдэхүүний экспорт хөвөн зэрэг ургамлын гаралтай утаснаас бусад нь өснө. Ургамлын гаралтай утасны экспорт сүлжмэл эдлэл, хувцасны экспортын үйлдвэрлэлийн өсөж буй эрэлттэй холбоотой буурч байна. Тэжээлийн үр тарианы экспорт мөн буурна. Учир нь эрдэнэ шишийн экспортод өгөх татаасыг арилгана гэж мэдэгдсэн. Хэдэн жилийн дараа Хятад автомашины нэг том экспортлогч болох магадлалтай.

¹²⁶ *Хятад ДХБ-д элссэний эдийн засагт үзүүлэх нөлөө, Дэлхийн Банкны бодлого судлалын ажлын илтгэл*

Худалдааны их саад тотгорыг арилгах олон салбарт импорт өсөхөөр байна (ундаа, тамхи, боловсруулсан хүнс, сүлжмэл эдлэл, хувцас, тосны үр, сүүн бүтээгдэхүүн, элсэн чихэр). Хятадын экспортын салбаруудад түүхий эд болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн, тухайлбал газрын тос, резин, мод, төмрийн хүдэр, ган, төмөрлөг бус хүдэр, металл, байгалийн болон хиймэл утас, нефть-химийн бүтээгдэхүүн, электроникийн эд анги, машин, тоног төхөөрөмж улам их шаардагдана. Хөдөө аж ахуйд мөн Хятадын импорт нэлээд өснө. Гэхдээ дээр дурдсанчлан арай бага хэмжээгээр өснө.

Хятадын зах зээлийг улам нээснээр үүсэх худалдааны ихэнх хэсгийг хөрш зэргэлдээ орнуудтай хийнэ. Эдгээр улс орон нь БНХАУ-ыг ДХБ-д элсэхээс өмнө Хятадын гадаад худалдааны асар их өсөлтийн үр шимийг хамгийн их хүртсэн улс орон билээ. Жишээ нь дээрх хугацаанд АСЕАН-ын орнууд Хятад руу гаргах экспортоо 390%-иар өсгөж, Хятадын нийт импортод эзлэх хувийн жингээ 6 хувиас 9 хувь хүртэл өсгөсөн.

Дэлхийн банкны хэвлүүлсэн хэд хэдэн судалгаанаас харахад¹²⁷ Зүүн Азийн улс орнууд Хятадын ДХБ-д элссэний нөлөөг дөрвөн сувгаар мэдэрнэ. Үүнд:

- БНХАУ-ын том зах зээлд нэвтрэх боломж өснө,
- Хятадаас тэдний дотоод зах зээл рүү оруулах импорт өснө,
- Гуравдагч орны зах зээл дээр Хятадтай өрсөлдөх,
- ГШХО-ын шинж чанар өөрчлөгдөх.

Шинээр аж үйлдвэржсэн, дунд зэргийн орлоготой, бага орлоготой гурван бүлгийн улс орнуудад эдгээр сувгаар өөр өөр хэмжээнд нөлөөлнө.

V 2.1 Хятадын дотоодын зах зээлд нэвтрэх боломж өсөх

Хятадын импортын хэрэгцээ өсөн нэмэгдэхэд Зүүн Азийн бүс нутаг тэр чигээрээ үр шимийг нь ямар нэг байдлаар хүртэнэ. Индонез, Лаос, Камбож, Монгол зэрэг түүхий эд нийлүүлэгчид газрын тос, мод, ноос, хөвөн, каучук, хүдэр, металлын борлуулалтаа өсгөх боломжтой байна. Гэхдээ Япон болон шинээр аж үйлдвэржсэн орнууд, тухайлбал Солонгос, Тайвань, Малайз, Сингапур үр шимийг хүртэгч гол улсууд байх болно. Учир нь эдгээр улс орон Хятадын экспортын салбаруудад илүү өндөр нэмүүөртөгтэй орц, тухайлбал нефть-хими, электроникийн бүтээгдэхүүн, сүлжмэл эдлэл, автомашины эд анги, машин тоног төхөөрөмжийг нийлүүлдэг.¹²⁸

V 2.2 Хятадаас оруулж байгаа импорт өсөх

БНХАУ нь ДХБ-д элссэнээр экспортын үнээ багасгаж, хагас боловсруулсан бүтээгдэхүүн нийлүүлэгчийн хувьд гадаад улс орнуудын сонирхлыг улам их татах болно. ДХБ-д элсэн орохоос өмнөх эдийн засгийн шинэчлэлүүд нь Хятадын экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хамгийн ойрын худалдааны түншүүдэд үр шимээ өгсөн.

Хятадаас оруулах импортын өсөн нэмэгдэх нэг хэсэг нь зөвхөн эцсийн хэрэглэгчийн бүтээгдэхүүн төдийгүй үйлдвэрлэлд ашиглах орцын бүтээгдэхүүн байх болно. Ингэснээр Хятад үйлдвэрлэлийн сүлжээнд гол үүрэг гүйцэтгэнэ. Нэг

¹²⁷ Янчовичина-Сутхиварт-Нареупут-Жао, Хятад ДХБ-д элссэнээр бүс нутагтаа үзүүлэх нөлөө, Зүүн Азийн интеграци - Хамтын өсөлтөд чиглэсэн худалдааны бодлогын асуудлууд х. 21; Янчовичина-Валмслий, Хятад ДХБ-д элссэний Зүүн Азид үзүүлэх нөлөө, Дэлхийн Банкны Бодлого судлалын ажлын илтгэл, Твэстэн, Хятад ДХБ-д элссэнээр хөрш хөгжиж буй орнууддаа хэрхэн нөлөөлөх вэ? Улаанбаатар 2002

¹²⁸ Янчовичина-Сутхиварт-Нареупут-Жао, мөн эх сурвалж. х. 22 f., 26 f.

хэсэг хугацаанд Япон нь Зүүн Азийн үйлдвэрлэлийг хуваах үйл ажиллагааны нэг чухал төв хэвээр байх ч, Хятад яваандаа тэргүүлэх байр суурьтай болно. Хятадын эд ангийн экспорт 1996 оноос 2001 онд 20 тэрбум ам.доллараар өсжээ. 2001 он гэхэд Хятад Зүүн Азийн бусад орнуудад 20 тэрбум ам.долларын эд анги, голдуу цахилгаан болон конторын тоног төхөөрөмж, цахилгаан холбооны тоног төхөөрөмжийг экспортолж байлаа. Дахиад л Япон ба шинээр аж үйлдвэржсэн орнууд Хятадаас хямдхан эд ангийг нийлүүлэхэд үр шимийг хамгийн их хүртэнэ.¹²⁹

V 2.3 Гуравдагч орны зах зээлийн өрсөлдөөн нэмэгдэх

Хятад ДХБ-д элссэнээр гуравдагч орны зах зээл дээр Хятадтай өрсөлдөх өрсөлдөөн улам ширүүснэ. Энэ өрсөлдөөн олон оронд, ялангуяа хөдөлмөр их шаарддаг бүтээгдэхүүнээр харьцангуй давуу талтай улс орнуудад бэрхшээл учруулна.

Зүүн Өмнөд Ази дэлхийн зах зээлд Хятадтай үйлдвэрийн бүтээгдэхүүн, ялангуяа хөдөлмөр их шаарддаг бүтээгдэхүүнээр өрсөлддөг бөгөөд сүүлийн үед нэмүү өртөг өндөртэй хагас дамжуулагч, бичил схем, бусад өндөр технологийн бүтээгдэхүүнээр өрсөлдөх нь ихсэж байна. Хятадтай өрсөлдсөнөөр нэгжийн үнэ аль хэдийн буусан.

Хятадын өрсөлдөх хамгийн гол салбар нь хувцасны салбар юм.¹³⁰ БНХАУ ДХБ-д элссэнээр томоохон хоёр үр дагавар гарсан. Тарифыг багасгаж, ХБСТ-ыг арилгаснаар өндөр чанартай сүлжмэл эдлэл зэрэг үйлдвэрлэлийн орцыг Хятад руу бага үнээр оруулах боломжтой болно. Цаашилбал, Хятадын худалдааны гол түншүүд нь (АНУ, ЕХ) 2005 он гэхэд Хятадын сүлжмэл эдлэл, хувцасны импортод тавьсан квотын хязгаарлалтыг байхгүй болгоно. Дээр тодорхойлсончлон,¹³¹ квотын хязгаарлалтыг арилгах нь Хятадын экспортлогчдод экспортын татварыг хөнгөлж байгаа мэт нөлөө үзүүлнэ. ДХБ-ын дээрх хоёр заалт нь эцсийн бүтээгдэхүүний үнийг хямдруулахад хүргэнэ.

Квотын хязгаарлалтаас чөлөөлөгдсөн Хятадын хувцасны экспорт нь импортлогч улс л дампингийн эсрэг буюу хамгаалах арга хэмжээ авахгүй бол чөлөөтэй өснө. Үүний улмаас Азийн бусад нийлүүлэгч, тухайлбал Индонез, Малайз, Филиппин, Тайланд, Камбож, Тайвань зэрэг улс орнуудад хохирол учрах магадлалтай. Удаан хугацааны турш импортлогч зарим улсын (тухайлбал ЕХ) хувцасны зах зээлд тэдгээр улсын эзэлж байсан хувь хэмжээ нь өрсөлдөөнтэй гэхээсээ илүү квоттой холбоотой байлаа. Квотын хамгаалалт байхгүй болж, Хятад хүчирхэг өрсөлдөгч болсноор Азийн бусад улс орон үйлдвэрлэлийнхээ бүтцийг өөрчилж, өөр боломжуудыг ашиглахаас өөр аргагүй болно.

Арьс ширний бүтээгдэхүүн, спортын бараа, тоглоом зэрэг хөнгөн үйлдвэрийн бусад салбарт ч иймэрхүү байдал бий болно.

V 2.4 ГШХО-ын шинж чанарын өөрчлөлт

нь үйлдвэрлэлийн зардлыг багасгаж, капиталын ашгийг нэмэгдүүлдэг тул БНХАУ ДХБ-д элссэнээр гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улам нэмэгдүүлнэ. Үүний зэрэгцээ хөрөнгө оруулалтын дүрмийг либералчилж, урьд нь хаалттай байсан автомашин үйлдвэрлэлийн салбар буюу хэд хэдэн үйлчилгээний салбарыг нээвэл гадаадын хөрөнгө оруулагчид Хятад руу уралдан орж ирэх хүчтэй урамшуулал

¹²⁹ Мөн эх сурвалж. х. 23/24, 26 f.

¹³⁰ Мөн эх сурвалж. х. 24

¹³¹ Дээрхийг үз х. 50

болно. ГШХО нь Хятадын үйлдвэрийн бүтээмжийг их дээшлүүлнэ. Тухайлбал, сүлжмэл эдлэл, гутлын үйлдвэрийн бүтээмжийг 30%-62%-иар нэмэгдүүлнэ.¹³²

ГШХО-ын урсгал нь Хятад руу чиглээд эхлэхээр Зүүн Азийн бусад улс орон алдагдал хүлээх үү үгүй юү, алдагдал хүлээх бол хэр их алдагдал хүлээх зэрэг асуултад хариулахад хэцүү юм. Учир нь олон зүйл тухайн улс орны бодлогын хариу арга хэмжээнээс хамаарна.

Зүүн Азид ГШХО-ыг авахын төлөө "бие биенээ шахан гаргах" өрсөлдөөний эсрэг зарим нөлөөг үзүүлж болно.

Дээр дурдсанчлан¹³³ БНХАУ ДХБ-д элссэнээр бүтээмжийг дээшлүүлэх арга хэмжээ авах нь Азийн бусад орноос оруулах импортыг нэмэгдүүлнэ. Хятадын илүү нээлттэй зах зээлд экспорт хийх боломж сайжрах нь гадаадын аж ахуйн нэгжүүд Хятадад хөрөнгө оруулахаасаа илүү Хятадтай хөрш зэргэлдээ улс орнуудад хөрөнгө оруулах хөшүүрэг болж болно.

ХХХОАХ-ийн дагуу дотоодод үйлдвэрлэсэн орцын хэмжээнд тавьдаг шаардлагыг хөнгөлснөөр Хятадад одоо үйлдвэрлэл явуулж байгаа компаниуд нь үйлдвэрлэлийнхээ зарим хэсгийг Хятадаас хөрш зэргэлдээ орнууд руу шилжүүлэхэд түлхэц өгч болно. Учир нь эдгээр байршил нь өрсөлдөөний илүү давуу байдал, тухайлбал үйлдвэрлэлийн цархэмжээнээс үүдсэн арвилан хэмнэлт, өндөр мэргэшилтэй ажиллах хүч, илүү үр дүнтэй судалгаа, боловсруулалтын үндэс гэх мэт давуу талтай.

Цаашилбал, салбар доторх төрөлжилтын цар хүрээ, ялангуяа технологийн хувьд илүү дэвшилтэт бүтээгдэхүүний төрөлжилт өссөнөөр Хятадын хөрш зэргэлдээ улс орнууд "Дундад Улс" руу орж байгаа хөрөнгө оруулалтыг нөхөн ГШХО-ыг хүлээн авч болно.

Хятад өндөр технологийн буюу бага цалин хөлстэй үйлдвэрлэлийн хувьд харьцангуй давуу талтай гэсэн тодорхойлолтыг эсэргүүцдэг. Сувдан мөрөн, Хөх мөрний сав газар, Бээжин-Тяньжин-Далян-Гурвалжингийн үйлдвэрийн нэгтгэл нь технологийн хувьд түргэн хөгжиж байгаа бөгөөд хөдөлмөрийн өртгийн хувьд хямд гэгдэхээ больж байна. Жишээлбэл, Volkswagen-ийн Шанхайн чадвартай ажилчдад өгдөг цалин хөлс нь Братиславт өгдөгтэй нь адил байна. Хятадын төв болон баруун талын мужуудын дэд бүтэц муу хөгжсөн тул бага цалин хөлстэй ажиллах хүч гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг одоохондоо татахгүй байна. Зарим тохиолдолд Хятадын хөрш зэргэлдээ орнууд илүү таатай байршилтай байж болно.

Харьцангуй давуу талууд цагийн аясаар өөрчлөгддөг бөгөөд хөрөнгө оруулагчид ийм өөрчлөлтөд түргэн шуурхай зохицон ажилладаг. Тухайлбал, Тайванийн компаниуд хэдхэн жилийн дотор үйлдвэрлэлийн байраа хямд газрууд руу хэд хэдэн удаа шилжүүлж маш шуурхай ажилладаг. Хөдөлмөрийн өртөг эх нутагт нь өсөхөд хөдөлмөр их зарцуулдаг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид эх газрын Хятад руу шилжсэн бөгөөд дараа нь тэндээсээ Вьетнам, Индонез руу шилжсэн. Хятадын далайн эрэг хавийн бүс нутгууд нь газар болон хөдөлмөрийн өртгийн хувьд Тайванийн түвшинд хүрэхийн хирээр энэ явц үргэлжлэх болно. БНХАУ-ын хөрш зэргэлдээ улс орнууд Хятадын далайгаас хол мужуудыг бодвол "зэрлэг галуу мэт" авирлах хөрөнгө оруулагчдад өндгөө дарах илүү тохилог орчинг бий болгоход илүү бэлтгэсэн байж болно.

¹³² Янчовичина-Сутхиварт-Нареупут-Жао, мөн эх сурвалж. х.24/25

¹³³ Дээрхийг үз х. 46 f.

VI. Дүгнэлт, зөвлөмж

ДХБ-д элссэний үр дүнд Хятадын эдийн засгийн өсөлт хүчтэй хэвээр байх тул хөрш зэргэлдээ орнууд энэхүү үйл явцаас үр шим хүртэх сайхан төлөв харагдаж байна. Одоогийн нөхцөлд ч гэсэн, Банзе¹³⁴-гийн тооцоолсноор Хятад ДХБ-д элссэнээс Монголын нийт баялаг 7.4%-иар өсөж ашгаа өгнө. Гэхдээ эдгээр нөхцөлийг бүр илүү сайжруулах ч боломж бий.

Монгол түүхий эд, ялангуяа зэс, молибдены баяжмал, ноолуур, ноосны нэг гол нийлүүлэгч юм. Эдгээр нь Хятадын цэцэглэн хөгжиж буй үйлдвэрүүдийн гол түүхий эд болно.¹³⁵

Эдгээр бүтээгдэхүүний хувьд Хятадын зах зээлд нэвтрэх боломж таатай. Тухайлбал, металлын баяжмалын импортод ногдох гаалийн татвар тэг, ноос ноолуурынх бага байдаг. Гэхдээ Хятад АСЕАН-ын орнуудтай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах гэж байгаа тул Монголын экспортын бусад бүтээгдэхүүнд муугаар нөлөөлөх эсэхийг судлах хэрэгтэй. Жишээлбэл, Хятад-АСЕАН-ын эдийн засгийн бүрэн хамтын ажиллагааны тухай багц хэлэлцээрийн "Эрт ургац" хэмээх зүйлийн дагуу Зүүн Өмнөд Азийн экспортод бусад орны экспортод ногдуулдагас бага тариф ногдуулна. Гэхдээ АСЕАН-ын бүс нутгийн бүтээгдэхүүн Монголын экспорттой өнөөдөр эсвэл ирээдүйд шууд буюу шууд бусаар өрсөлдөх үү үгүй юү, өрсөлдвөл ямар хэмжээнд өрсөлдөхийг дүгнэхэд хэцүү байна. Хэрэв ийм байдал үүсвэл Монгол Улс дээрх Чөлөөт худалдааны бүсэд нэгдэн орох буюу БНХАУ-тай хоёр талын хэлэлцээр байгуулах замаар ижил нөхцөл олж авахыг чармайн ажиллах ёстой. Гэхдээ үүний тулд Хятадад тарифын хариу хөнгөлөлт үзүүлж, дампингийн эсрэг шалгалтад Хятадыг "зах зээлийн эдийн засгийн статус"-тай гэх ёстой болно. Монгол Улс цөөхөн нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээс бусад бүх бараа, бүтээгдэхүүний импортын татварыг тэглэсэн тул энэ тал дээр санал болгочих юм бараг байхгүй. Худалдааны бодлогын үүднээс авч үзвэл Монгол Улс бүтэцтэй тарифын тогтолцоотой байх хэрэгтэй юү үгүй гэдгийг бодож үзэх нь зүйтэй.¹³⁶

Монгол, Хятадын дунд борлуулалтын байгууллагатай болбол зэс, молибдены баяжмалын экспортын нөхцөл байдал сайжирч болно. Эрдэнэтээс авсан мэдээллээс үзэж байхад Хятадын хил дээр байх нэгэн салбарт худалдан авагч нар цугларч үнэ нөхцөлөө тохирсны үндсэн дээр борлуулалтын гэрээ байгуулдаг ажээ. Хэлэлцээрийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн металлын зах зээлийн үнийг "дэлхийн зах зээлийн үнэ" хэмээн тооцон түүний үндсэн дээр байгуулдаг. Энэ нь бүтээгдэхүүнээ борлуулах хамгийн үр ашигтай арга зам биш байж болно. Зэс, молибдены баяжмал харьцангуй ховор учир заримдаа богино хугацааны нийлүүлэлт дээр ч гэсэн Хятадын зэс хайлуулах үйлдвэрүүдтэй шууд холбоо тогтоох нь дээр гэж зөвлөмөөр байна. Ингэснээр илүү сайн үнэ олж авах боломжтой. БНХАУ-ын Гадаад худалдааны хууль, "Арилжааны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын захиргааны дүрэм"-ийн дагуу гадаадынхан¹³⁷ бүртгүүлсэн хөрөнгө харьцангуй багатай худалдааны компанийг байгуулж болохгүй тул, зэс хайлуулах боловсруулах үйлдвэр төвлөрсөн гол бүс нутгуудад салбар бүхий борлуулалтын компанийг байгуулах боломжтой бөгөөд зүйтэй юм. Эдгээр салбар нь зах зээлийн байдлыг тасралтгүй хянаж, шинжлэх үүргийг гүйцэтгэж болно.

¹³⁴ Мөн эх сурвалж. х. 36

¹³⁵ Дээрхийг үз х.4

¹³⁶ Өөр талаас нь авч үзвэл, Банзе (мөн эх сурвалж. х. 36/37), өөр өөр түвшин бүхий тарифын дэглэмтэй байхыг шүүмжилж байна. Учир нь тэрээр үүний хувийн баялаг болон экспортод үзүүлэх сөрөг нөлөөг тооцож байна

¹³⁷ Дээрхийг үз х. 39 f.

Энэхүү ашигт малтмалын нөөцийг илүү ашигтай ашиглах нэг арга зам бол зэс цэвэршүүлэх хүчин чадлаа нэмэгдүүлэхэд оршино. Эрдэнэтийн өгсөн мэдээллээс харж байхад ийм үйл ажиллагаа эхэлсэн боловч үр шимээ өгөх болоогүй ажээ.

Ноос ноолуурын экспорттой холбоотой асуудлууд нь худалдааны бодлогын шинжгүй юм. Монголын Засгийн газар хил дээрх хууль бус ажиллагааг таслан зогсоох шаардлагатай арга хэмжээг авахгүй бол их хэмжээний экспорт ердийн бус замаар орж ирэх нь зогсохгүй. Улаанбаатарын бизнесийн хүрээнийхний үзэж байгаагаар хилийн хоёр талын эрх барих байгууллагууд хайхарсан бол ийм үйл ажиллагаа газар авахгүй байх байжээ. Үүнээс болж Монголд хоёр байдлаар хохирол учирч байна. Засгийн газар экспортын татвараа хурааж чадахгүй алдаж байгаа бөгөөд дотоодын боловсруулах үйлдвэрүүд түүхий эдээ алдаж байна.

Ирээдүйд Монгол Улс Хятад болон түүний хөрш зэргэлдээ Вьетнам зэрэг улстай амьд мал, махан бүтээгдэхүүний зах зээлийнх нь хувьд харилцаагаа хөгжүүлж болох юм. Энэ зорилгыг хангахын тулд Монгол Улс малын гаралтай бүтээгдэхүүнийхээ ариун цэврийн стандартыг дээшлүүлэх ёстой. Хятадын амьд мал, маханд тавьдаг ариун цэврийн стандарт шаардлага амар хялбар биш; тэр байтугай АНУ-ын экспортлогчид энэ шаардлагыг хангахад их хэцүү байдаг.¹³⁸ Нөгөө талаар, Хятад хүний болон малын эрүүл мэндийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр дамжин орж ирдэг шимэгч хорхой, өвчнөөс хамгаалахын тулд хилийн хатуу хяналт тогтоох хууль зүйн үндэстэй. Хятадын нутаг дэвсгэр асар уудам бөгөөд мал эмнэлгийн дэд бүтэц сул хөгжсөн тул хилээр оруулж ирсэн өвчин улс даяар тархвал хянахад хэцүү юм. Тиймээс ч урьдчилан сэргийлэх нь чухал ач холбогдолтой. Тиймээс Монгол Улс шаардлагатай чадавхыг бий болгохоос өөр хувилбар байхгүй. ЕХ-ны ивээн тэтгэсэн техникийн тусалцааны төсөл энэ зорилгыг хангахад хувь нэмрээ оруулж болно.

Одоогоор Монголын ба Хятадын компаниудын хоорондох эдийн засгийн харилцаа хэтэрхий бага байна. Бие биенээ нөхөх зарим бүтэц, чиглэл байсаар байтал ийм байгаа нь гайхалтай. Хятадын компаниуд Монголд салбараа байгуулах цорын ганц сэдэл нь Хятадын сүлжмэл эдлэлийн экспортод тавьсан квотын хатуу хязгаарлалтаас зугтах зарим хувийн бизнес эрхлэгчдийн хүсэл эрмэлзэл байсаар иржээ. 2004 оны эцэс гэхэд энэхүү хязгаарлалт байхгүй болох тул Монголын Засгийн газар ямар орчин бүрдүүлбэл хөрөнгө оруулагчид ялангуяа хөрш Хятадын хөрөнгө оруулагчдыг татаж чадах вэ гэдэг талаар эрэгцүүлэн бодох нь зүйтэй.

Энэ асуудал зөвхөн сүлжмэлийн салбараар хязгаарлагдаагүй. Монгол Улс өөрийн түүхий эдийн асар их нөөцөө боловсруулах үйлдвэрийн чадавхыг дээшлүүлэх хэрэгцээ байгаа билээ. Монголын аж үйлдвэржих үйл хэрэгт Хятадын компаниуд түнш болж чадна. Дээр дурдсанчлан¹³⁹ Хятадын зах зээлийг сонирхсон хөрөнгө оруулагчид Хятадын үйлдвэрийн гол нэгтгэл ердийн технологийнүйл ажиллагаанд хэтэрхий их өртөгтэй болж байгаа тул өөр байршлыг хайх болно. Арьс шир боловсруулах салбар нь ийм нэг тохиромжтой салбар байж болно. Учир нь Хятадынавтомашин үйлдвэрлэх салбар, гутал, спортын бараа үйлдвэрлэгчдийн дунд арьс ширэн бүтээгдэхүүний эрэлт хүчтэй байхад Монгол Улсад энэ түүхий эдийн нөөц асар их байна. Монголын дэд бүтэц сул хөгжсөн тул хилдээ ойрхон үйлдвэрийн парк/төв зэрэг тусгай байгууламжуудыг байгуулах шаардлагатай байж болно. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, ялангуяа Хятадаас хөрөнгө оруулалтыг татах тодорхой хөтөлбөрийг боловсруулах талаар бодох хэрэгтэй. Цаашилбал, Хятадын зэсийн салбар хилийн чанадаас шинэ нөөцийг хайх сонирхолтой байдаг. Уламжлалт хамтын ажиллагааны түншүүдээсээ

¹³⁸ Дээрхийг үз х. 30 f.

¹³⁹ Дээрхийг үз х. 57 f.

хамаарсан хамаарлаа багасгахын тулд Хятадтай хамтран ажиллах боломжуудыг судлах хэрэгтэй.

Тээвэрлэлтийн өндөр өртөг Монголын гадаад худалдаанд муугаар нөлөөлдөг. Хэдэн жилийн өмнө нэлээд буурсан ч гэсэн Хятадын төмөр замын тарифын бүтэц ТХЕХ 1994-ийн III зүйлд заасан Үндэсний нөхцөлийн дүрэм, Хятадын ЭТП, ЮНКТАД-ын далайд гарцгүй орнуудын далайн боомт хүртэлх тээвэрлэлтийн тухай Барселоны дүрмийг илэрхий зөрчиж байна. Монголын Засгийн газар Бээжинтэй хоёр талт яриа хэлэлцээрийг хийж байхдаа энэ асуудлыг гаргаж ирэх нь зүйтэй.

Хятадын татаас нь худалдааны бодлогын хамгийн ноцтой нэг асуудал юм. Хятадын эрх баригчид буюу улсын банкнууд Монголоос ноос ноолуур худалдан авч байгаа сүлжмэлийн компаниудад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлийн хэлбэртэй татаас өгч байгаа нь Монголын эдийн засагт хохирол учруулж болно. НӨАТ-ын буцаан олголт мөн ижил нөлөөтэй. НӨАТ-ын буцаан олголтыг, ялангуяа зэс хайлуулах үйлдвэрүүдэд өгдөг. Гэхдээ энэ буцаан олголт нь зэс боловсруулах компаниудын экспортын гүйцэтгэлээс хамаарах шинжтэй. Монгол Улс цэвэршүүлсэн зэс их хэмжээгээр экспортолдоггүйгээс хойш Хятадын энэхүү практик Монголын эдийн засагт тийм ч их сөргөөр нөлөөлөхгүй. Гэхдээ Монгол Улс цэвэршүүлсэн зэс үйлдвэрлэх хүчин чадлаа нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа бол Засгийн газар нь Хятадын энэхүү байдалд алсын хараатай хандах хэрэгтэй.

Хятадын татаасын хөтөлбөрүүдийн тухай мэдээллийг олж авахад хэцүү. Учир нь дүрэм журмуудыг хэзээ ч хэвлэн нийтэлж байгаагүй. Хянаж ажиглах асар том, үр дүнтэй механизм бүхий энэ асуудлыг АНУ хүртэл бүрэн судалж чадаагүй. ЕХ-ны комисс, Европын салбарын холбоод онигоо мэт нотлох баримтаас өөр зүйл олж авч чадаагүй. Тиймээс татаасын тухай асуудал нэг хэсэг хугацаанд ШДХМ-ын нэг гол асуудал хэвээр байх болно.

Хятадын Монголд гаргаж байгаа экспортын бүтээгдэхүүнийг хэр их хэмжээнд татаасаар тэтгэж байгаа болон үнийг нь зах зээлийн үнээс хэр их доогуур тогтоож байгаа талаар ямар ч мэдээлэл байхгүй. ДХБ-ын хэм хэмжээний үүднээс татаасын хэргийг батлахад угаасаа хэцүү байдаг билээ. Хамгаалах арга хэмжээний тухай заалт (ТХЕХ 1994-ийн XIX зүйл) болон ЭТП-ын 16-р заалтад туссан тодорхой бүтээгдэхүүний хамгаалах арга хэмжээний тухай заалтын хувьд ч мөн ижил байдалтай байна. (Жишээлбэл АНУ-д Хятадаас оруулдаг тодорхой барааны импортыг зогсоохын тулд тодорхой бүтээгдэхүүний хамгаалах арга хэмжээний тухай заалтыг долоон удаа шүүхэд хандсан ч үр дүнд хүрээгүй). Гомдол гаргагчид шаардлагатай нотлох баримтыг гаргаж ирж чаддаггүй тул өргөдлүүд бүгд амжилтгүй болсон. Ийм ганцхан хэрэг л ЕХ-нд шийдэгдэх гэж байна.

Тиймээс ихэнх улс орон худалдааны үйл ажиллагаагаа буцааж хэвийн байдалд оруулахын тулд дампингийн эсрэг арга хэрэгслийг ашиглаж байна. Учир нь дампингийн шалгуурт нийцэж байгааг нотлоход илүү амархан байдаг. Тиймээс Монгол Улс дампингийн эсрэг хуулийг аль болох даруй гаргах хэрэгтэй байна.

Эдгээр дүгнэлтийн үндсэн дээр дараах зөвлөмжүүдийг гаргаж ирлээ. Үүнд:

Монголын Засгийн газар дангаараа шийдэх асуудлууд:

- Хятад руу гаргах ноос ноолуурын экспортод гарч байгаа хэвийн бус практикийг засаж залруулах,
- Дампингийн эсрэг хууль гаргах.

Хятадтай хоёр талын харилцааны хүрээнд шийдвэрлэх асуудлууд:

- Хятадтай төрийн захиргааны төв байгууллагын түвшинд (ХЯ), шаардлагатай бол Монголтой хил залгаа мужуудын засаг захиргаатай худалдааны бодлогын тогтмол яриа хэлэлцээг бий болгох,
- Монголын экспортын бараа, бүтээгдэхүүний Хятадын зах зээлд нэвтрэх нөхцөл цагийн аясаар өөрчлөгдөж болох учраас энэ тухай хэлэлцэх,
- Санал болгож байгаа АСЕАН-ын Чөлөөт худалдааны бүсийн Монгол-Хятадын эдийн засгийн харилцаанд үзүүлэх нөлөөний талаар хамтран судлах,
- Хятадын татаасын үйл ажиллагаа, Хятадад мал, махан бүтээгдэхүүн импортлох ариун цэврийн стандартын талаар мэдээлэл цуглуулах,
- Монголын компаниудад Хятадын иргэдтэй адил төмөр замын тээврийн тариф тогтоож, Үндэсний нөхцөлийн дүрэм болон ЮНКТАД-ын Барселоны дүрмийг дагаж мөрдөхийг Хятадад уриалах,
- Эдийн засгийн харилцан хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжих, эрх ашиг нэгдэх төсөл, чиглэлүүдийг судлах, хөрөнгө оруулалтыг харилцан дэмжих, хамгаалах тухай хэлэлцээрийг байгуулах.

Олон талт хамтын ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлэх асуудлууд:

- ШДХМ-ыг хэрэгжүүлэхэд байр сууриа шууд илэрхийлэхгүй байж, Монгол Улсын их сонирхож байгаа хэд хэдэн асуудлыг дэмжигч гол улс орнууд болон БНХАУ-ын худалдааны гол түншүүдтэй ойрхон хамтран ажиллаж, мэдээллээр хангах замаар тэдэнд туслах,
- Хятадын гадаад худалдааны дэг журмыг, ялангуяа Гадаад худалдааны хууль, дампингийн эсрэг болон татаасын эсрэг дүрэм журмыг ДХБ-ын дүрэм журамтай бүрэн нийцүүлэх зорилгоор дахин хянахад чиглэсэн санаачилгыг дэмжих,
- Олон шатлалт үнийн тогтолцоог арилгах зорилгоор Хятадыг татаасныхаа тухай мэдээлж байхыг уриалах санаачилгыг дэмжих,
- Гадаад худалдаа, ялангуяа гаалийн журам, тусгай зөвшөөрөл олгох, тарифын түвшний квот, стандарт, тохирлын үнэлгээ зэрэг асуудалтай холбоотой хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэхдээ улам их нээлттэй байхыг Хятадаас уриалах санаачилгыг дэмжих,
- Үйлчилгээний зах зээлийг нээхэд учирч байгаа саад тотгорыг арилгахад чиглэсэн санаачилгыг дэмжих, ингэхдээ Монгол Улсын сонирхож байгаа үйлчилгээний салбарыг онцгойлон анхаарах.

Лавлах материал

Алмстэдт, К.В., Нортон, П.М., Хятадын татаасын эсрэг дүрэм журам: Хятадын худалдааны хуулийг сахиулах хамгийн сүүлийн үеийн зэвсэг, Хэвлэгдсэн сэтгүүлийн нэр: Хятадын хууль ба практик 2002 оны 12-р сар/2003 оны 1-р сар 16(10); Дахиж хэвлэгдсэн: Хятадын эрх зүйн сэдвүүд, О'Мэлэвэни ба Майэрс ХХТ-ийн судалгаа, 2003 оны 4-р сар

Банзэ, М. ДХБ-д Хятад улс гишүүнээр нэгдэн орох нь Монгол улсад нөлөөлөх тухай; "Олон улсын худалдааны бодлого/ДХБ-ын талаарх Монгол-Германы хамтын ажиллагаа" ГТХАН-ийн төслийн захиалгаар хийсэн богино хугацааны судалгаа, Улаанбаатар 2003

Улаанбаатар дахь Германы Элчин сайдын яам, Эдийн засгийн жилийн тайлан – 2002 он - нийтлэгдээгүй

Бриллиант, М.А., ДХБ-ын Хятадын талаарх бүртгэл: Хоёр жилийн судалгаа, АНУ-ын Худалдааны танхим, Худалдааны бодлогын орон тооны хорооны өмнө өгсөн мэдүүлэг, 2003 оны 9-р сарын 19

Кассиди, Р.Б. Хятад дахь үйлчилгээний худалдаа, ДХБ-ын хэрэгжилт, Хэвлэгдсэн: Хятад ДХБ-д элссэн нь – Хэрэгжүүлэх зам, Азийн судалгааны үндэсний товчоо
Чан, Г. Хятад ба ДХБ: Дүрмийг дагаж мөрдөх онол, практикийн асуудал; Эзэн хааны олон улсын харилцааны хүрээлэн, Азийн ажлын илтгэл №5, Лондон 2003

Дойчэ банкны Дэлхийн зах зээл судлалын хүрээлэн, ДХБ-д элссэний дараа Хятадад хийсэн аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлт, *Ма Жун, Цинг Хай, Ли Хонгшэнг* нарын хийсэн судалгаа, Лондон 2001

Хятад дахь Европын худалдааны танхим, Хятад дахь Европын бизнес, Нөхцөл байдлын тухай илтгэл 2002-2003, Бээжин 2003

Европын комисс, ЕХ-ны мэдээллийн нийтлэг сэдвүүд, Хятад; Брюссель, 2004 оны 5-р сар - нийтлэгдээгүй

Хуанг Жикүн, Розелле С., Хятад ДХБ-д элссэн нь, хөдөө аж ахуй дахь өөрчлөлтүүд; Хятадын хөдөө аж ахуйн бодлогын төв, Хятадын шинжлэх ухааны академи

Янчовичина Е., Мартин, В., Хятад Дэлхийн Худалдааны Байгууллагад элссэний эдийн засгийн нөлөө, Дэлхийн Банкны бодлого судлалын ажлын илтгэл; хэвлэгдсэн: *Крумм, К., Хараш Х.*, (хянан тохиолдуулагчид): Зүүн Азийн интеграци – Хамтын өсөлтөд чиглэсэн худалдааны бодлогын асуудлууд; Дэлхийн Банк, Оксфордын Их сургуулийн хэвлэлийн газрын хамтарсан хэвлэл, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк, Лондон

Янчовичина, Е., Валмслий, Т., Хятад ДХБ-д элссэний Зүүн Азид үзүүлэх нөлөө, Дэлхийн Банкны бодлого судлалын ажлын илтгэл, Дэлхийн Банк, Вашингтон, Колумбын тойрог, 2003

Янчовичина, Е., Сутхиварт-Нареупут, С., Жао Мин, Хятад ДХБ-д элссэнээр бүс нутагтаа үзүүлэх нөлөө, хэвлэгдсэн: *Крумм, К., Хараш Х.*, (хянан тохиолдуулагчид): Зүүн Азийн интеграци, х. 21 f.

Олон улсын худалдааны төв, Хамтын нөхөрлөлийн орнуудын хэрэг эрхлэх газар, Дэлхийн худалдааны тогтолцоон дахь бизнесийн гарын авлага, Хоёр дахь хэвлэл, Женев 1999

Мартин, В., Бхаттасали, Д., Ли Шантунг, Хятад ДХБ-д элссэн нь – Хятадад үзүүлэх нөлөө, Дэлхийн Банк ба Хөгжлийн судалгааны төв, хэвлэгдсэн: Крумм, К., Хараш Х., (хянан тохиолдуулагчид): Зүүн Азийн интеграци, х. 3 f.

Мөрфи, Д., Нааш нь хураа, Хэвлэгдсэн: Алс Дорнодын эдийн засгийн тойм, 2002 оны 6-р сарын 27 х. 37

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага Дэлхийн эдийн засаг дахь Хятад – Дотоод бодлогын сорилууд, Парис 2002

Шлэзингэр, М. ба бусад, Хятад улс ДХБ-д элссэний эдийн засаг, шинэчлэлтийн үйл явцын нөлөө болон Ази дахь эдийн засгийн өсөлтийн хандлага, Базэл 2003

Штиль, Д. Монгол, Хятадын ноолуурын үйлдвэрийг харьцуулсан дүн шинжилгээ; Монгол-Германы Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого төслийн захиалгаар хийсэн судалгаа, Улаанбаатар 2003

Твэстэн, Х., Хятад ДХБ-д элссэнээр хөрш хөгжиж буй орнууддаа хэрхэн нөлөөлөх вэ? Хэлэлцүүлгийн илтгэл, Монгол-Германы хамтарсан Олон улсын худалдааны бодлого/ДХБ-ын төсөл, Улаанбаатар 2002

Америкийн Нэгдсэн Улсын Худалдааны төлөөлөгч, 2003 Худалдааны бодлогын тойм (х. 57-95)

АНУ-Хятадын бизнесийн зөвлөл, ДХБ-ын дүрэм, өөрийн амлалт үүргээ Хятад хэрэгжүүлж байгаа нь, Хагас жилийн үнэлгээ, 2003

Ванг Жинг, Рус, М., Дотоод, гадаад худалдааг нээлттэй болгосон нь, Хэвлэгдсэн: Ванг Жинг ба түншүүд. Хуулийн сонин, №4, 2004 оны 4-р сар, Гонконг

Вайс В., Хэррманн Х., Үүлэр Х. Дэлхийн худалдааны хууль, Мюнхэн 2003

Дэлхийн худалдааны байгууллага

Бүгд Найрамдах Хятад Ард Улс ДХБ-д элсэн орсон тухай протокол; 2001 оны 11-р сарын 10-ны шийдвэр; Баримт бичиг WT/L/ 432 (2001 оны 11-р сарын 23)

Хятадыг ДХБ-д элсүүлэх ажлын хэсгийн тайлан; ДХБ-ын Сайд нарын бага хурал Баримт бичиг WT/MIN (01)/3/ Хавсралт 2 (2001 оны 11-р сарын 10)

Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас ирүүлсэн мэдээлэл (Үйлчилгээний худалдааны зөвлөлд Хятадын элсэн орсон тухай протоколын 18-р хэсгийн дагуу өгсөн мэдэгдэл) Баримт бичиг S/C/W/ 218 (2002 оны 10-р сарын 22)

Хятадын шилжилтийг дахин хянасан тухай Барааны худалдааны зөвлөлийн тайлан; Баримт бичиг G/L/ 596 (2002 оны 12-р сарын 3)

Хамгаалах арга хэмжээний тухай хороо: Хятадын шилжилтийг дахин хянасан тухай Барааны худалдааны зөвлөлийн өмнө даргын тавьсан тайлан; Баримт бичиг G/SG/ 66 (2003 оны 11-р сарын 17)

Татаас, саармагжуулах арга хэмжээний хороо: Хятадын шилжилтийг дахин хянасан тухай Барааны худалдааны зөвлөлийн өмнө даргын тавьсан тайлан; Баримт бичиг G/SCM/ 111 (2003 оны 11-р сарын 18)

Дампингийн эсрэг үйл ажиллагааны хороо: Хятадын шилжилтийг дахин хянасан тухай Барааны худалдааны зөвлөлийн өмнө даргын тавьсан тайлан; Баримт бичиг G/ADP/ 12 (2003 оны 11-р сарын 11)

Барааны худалдааны зөвлөл: Хятадын шилжилтийг дахин хянасан тухай Барааны худалдааны зөвлөлийн тайлан; Баримт бичиг G/L/ 664 (2003 оны 12-р сарын 4)